

# **ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Захиалагч: ХНХЯ, Жайка төсөл  
Гүйцэтгэгч: Д.Сүнжид

УЛААНБААТАР ХОТ  
2018 ОН

## **Товьёог**

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ .....	3
I.УДИРТГАЛ.....	4
II.ТҮҮВЭРЛЭСЭН ХУУЛИЙН ЗААЛТ .....	8
III.ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАР, ТУЛГАМДСАН АСУУДАЛ.....	8
3.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний ажиллаж амьдрах орчин нөхцөлийг сайжруулах арга хэмжээ .....	9
3.2 Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрх.....	16
3.3 Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлт.....	21
3.4 Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ .....	32
3.5. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх нийгмийн халамж .....	34
3.6 Хөгжлийн бэрхшээлтэй хүний хууль зүйн туслалцаа авах эрх.....	36
3.7. Хөгжлийн бэрхшээлтэй хүний бусад эрх .....	37
3.8.Хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоох .....	38
IV. ГАДААД УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА .....	39
4.1.АНУ-ын хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай хууль (ADA) .....	40
4.2. Болгар улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд татан оролцуулах тухай хууль	49
4.3. Япон улсын хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаархи хууль тогтоомж.....	60
V. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ДАВХАРДАЛ, ЗӨРЧИЛ, ХИЙДЭЛ .....	61
5.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн давхардал .....	62
5.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн зөрчил .....	67
5.3. Хуулийн зүйл, заалт, зохицуулалт нь хэл зүйн найруулгын хувьд салаа утгатай эсэх .....	77
5.4. Хуулийн зүйлийн нэр тухайн зүйлд байгаа хэсэг, заалтын агуулгын нийлбэртэй нийцэж байгаа эсэх .	77
5.5. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хийдэл.....	78
5.6.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой батласан эрх зүйн актын уялдаа.....	86
VI. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ.....	90
АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ .....	93
ХАВСРАЛТ .....	97

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНУ- Америкийн нэгдсэн Улс

БНБД – Барилгын норм ба дүрмүүд

БЗД- Баянзүрх дүүрэг

БСШУСЯ- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам

ГСТ- Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө

ГССҮТ- Гэмтэл согог судлалын үндсний төв

ГҮТ – Геронтологийн үндэсний төв

ЕБС- Ерөнхий боловсролын сургууль

ЗГ- Засгийн газар

ЗДТГ – Засаг даргын тамгын газар

МХЕГ- Мэргэжлийн хяналтын ерөнхий газар

НЗДТГ- Нийслэлийн Засаг даргын тамгын газар

НҮБ – Нэгдсэн үндэстэний байгууллага

СБД- Сүхбаатар дүүрэг

СХД-Сонгинохайрхан дүүрэг

СЭМҮТ - Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв

СЗКЭ – Сэргээн засах клиник эмнэлэг

СЗСҮТ – Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв

ТББ- Төрийн бус байгууллага

УИХ – Улсын их хурал

УГТЭ- Улсын гуравдугаар төв эмнэлэг

ХНХЯ – Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

ХНХСайд- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд

ХХҮХ – Хөдөлмөр халамж, үйлчилгээний хэлтэс

ХЗДХЯ- Хууль зүй, дотоод хэргийн яам

ХБИ- Хөгжлийн бэрхшээлтэй иргэн

ХЭДС - Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан

ЦЕГ- Цагдаагийн ерөнхий газар

ЭМЯ – Эрүүл мэндийн яам

ЭХМК – Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс

## І.УДИРТГАЛ

“Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын Конвенц”, “Эрхийг бодитой болгоё” Инчеоны стратегийн үзэл санаанд нийцүүлэн, хөгжлийн бэрхшээлтэй Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнд Монгол улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг эдлүүлэх боломжийг бодитой бүрдүүлэхийг эрмэлзэн, 2005 оны Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль, холбогдох бусад хууль, эрх зүйн актын амьдралд хэрэгждэггүй заалтыг өөрчлөн сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хамгаалалтыг бодитой, хүртээмжтэй болгох, улмаар хөгжлийн бэрхшээлтэй хүн нь нийгмийн амьдралд бусдын адил оролцоотой байх боломжийг бүрдүүлэх суурийг хуулиар тогтоох үндсэн зорилготойгоор уг хуулийг 2016 онд УИХ-аас баталсан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээг “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”<sup>1</sup>-д /цаашид “аргачлал” гэх/ дурдсаны дагуу дараах үе шаттайгаар хийлээ:

1. төлөвлөх;
2. хэрэгжүүлэх;
3. үнэлэх.

Хуулийн хэрэгжилтийн үнэлгээний төлөвлөх үе шатанд

1. үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
2. үнэлгээ хийх хүрээг тогтоох;
3. шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
4. харьцуулах хэлбэрийг сонгох;
5. шалгуур үзүүлэлтийг томъёолох;
6. мэдээлэл цуглуулах аргыг сонгох ажлыг хийж гүйцэтгэлээ.

Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийх гол шалтгаан нь тухайн хууль тогтоомжийг хэрэглэх субъектүүдийн хувьд ойлгомжгүй, зөрчилтэй зохицуулалттай байх, тэдгээр нь цаашид тухайн харилцаанд сөрөг үр дагавар үүсгэх шинжтэй байж болзошгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад түүний зохицуулалт бодит байдалтай нийцэж байгаа эсэхэд дүгнэлт өгөх шаардлагатай, хуулийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн захиргааны байгууллагаас эрх хэмжээнийхээ хүрээнд хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад хүндрэл

---

<sup>1</sup> Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт,

бэрхшээл үүсч байгаа, үүний улмаас төрөөс хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хангах талаарх үүргээ зарим талаар биелүүлэхгүй байна гэдгийг дурдаж болно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх хүрээг энэ салбарын өмнө хийгдсэн судалгаа, дүн шинжилгээ, өгүүлэл, илтгэл, бодлогын баримт бичгийн үндэслэлийг судласны үндсэн дээр тулгамдсан асуудлыг тоймлон гаргаж улмаар агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалт хэмээн 15 заалт эхлэн түүвэрлэсэн байсан бөгөөд мэдээлэл цуглуулах явцад нэмэгдэж сүүлийн байдлаар нийт 26 заалтыг түүвэрлэв.

Түүвэрлэсэн хуулийн заалтын хүрээнд дараахь таван шалгуур үзүүлэлтийг сонгосон болно. Үүнд:

1. зорилгод хүрсэн түвшин-тухайн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойш хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэхийг тогтооно.

2. зардлын өсөлт, бууралт<sup>2</sup>-хууль тогтоомж хэрэгжсэнээр иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллага болон улсын төсөвт үүсч байгаа зардлын өсөлт, бууралтыг тодорхойлно. Энэ шалгуур үзүүлэлтийг хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотойгоор зардал өссөн, эсхүл буурсан өөрчлөлтийг гаргах үүднээс томъёолно.

3. хүлээн зөвшөөрөгдсөн байдал-иргэд, хуулийн этгээдээс хууль тогтоомжийг хэрэгжүүлснээр гарсан үр дагаврыг хэрхэн хүлээн авч байгааг тодорхойлно. Өөрөөр хэлбэл, хууль тогтоомжийг нийгэм хүлээн зөвшөөрч, сайн дураар сахин биелүүлж байгаа эсэхийг энэ шалгуур үзүүлэлтээр шалгана.

4. практикт нийцэж байгаа байдал-тухайн хууль тогтоомжийн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэхийг тодорхойлно.

5. бусад үр дагавар-урьдчилан тооцоогүй болон шинээр гарч болзошгүй ямар үр дагавар байж болохыг тооцоолно.

Хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхээр түүвэрлэсэн заалт тус бүрт энэхүү таван шалгуур үзүүлэлтийн нэгэн зэрэг хэрэглэхгүй бөгөөд аль тохиромжтойг нь тухай бүр аргачлалд заасны дагуу хэрэглэсэн болно.

Хууль хэрэгжиж эхлэсэнээр нийгмийн харилцаанд гарсан эерэг, сөрөг өөрчлөлтүүдийг олж тодорхойлоход дараахь харьцуулах хэлбэрүүдийг ашиглана.

1. байх ёстой болон одоо байгаа-хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш гарсан үр дагавар

2. хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойш-хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнөх нөхцөл байдлыг хууль тогтоомж хүчин төгөлдөр

---

<sup>2</sup> Хууль тогтоомж хэрэгжүүлэхтэй холбоотой зардлын тооцоо хийх аргачлал, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт

хэрэгжсэний дараах нөхцөл байдал буюу хууль тогтоомжийн хэрэгжилтийн явцад гарч байгаа үр дагавартай харьцуулан дүн шинжилгээ хийх

3. хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш-хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөнийг он дарааллаар судалж тогтоох

4. тохиолдол судлах-хууль тогтоомж (түүний зүйл, хэсэг, заалт), эсхүл үнэлгээний хүрээгээр тогтоосон ижил төстэй эрх зүйн хэм хэмжээ өөр, өөр орчин нөхцөлд (бусад улсад, өөр орон нутагт гэх мэт) хэрэгжиж байгаа байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийх.

Хуулийн хэрэгжилтийн үнэлгээний хүрээнд сонгосон таван шалгуур үзүүлэлтийн асуултыг дараахь байдлаар ерөнхий томъёолов. Үүнд:

1. Хуулийн заалт зорилго, зорилтдоо хүрч чадсан эсэх
2. Хуулийн заалтыг оролцогч талууд хүлээн зөвшөөрч, сайн дураар сахин биелүүлж байгаа эсэх
3. Хуулийн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа эсэх, үүсч буй эерэг болон сөрөг үр дагавар, хүндрэл бэрхшээл гарч байгаа эсэх.
4. Урьдчилан тооцоогүй болон шинээр гарч болзошгүй ямар үр дагавар байгаа эсэх.

Хуулийн хэрэгжилтийн үнэлгээг хийхэд шаардлагатай мэдээллийг цуглуулахдаа дараахь аргыг ашиглалаа. Үүнд:

**1.бэлэн байгаа мэдээллийг цуглуулахдаа** тухайн хууль тогтоомжийг хэрэглэж гаргасан шүүхийн шийдвэр буюу шүүхийн практик, тухайн сэдвээр гарсан мэргэжлийн ном, товхимол, гарын авлага, эмхэтгэл, өгүүлэл, илтгэл, эрдэм шинжилгээ, судалгааны тайлан, статистикийн тоо баримт, хэвлэл мэдээллийн хэрэгслийн эх сурвалжийг ашиглах. Энэхүү хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийхдээ үзэл баримтлал, эрх бүхий байгууллагуудаас батлан гаргасан журам, стандарт, статистик тоон үзүүлэлтүүд, тайлан мэдээлэл, холбогдох хууль тогтоомж, тэдгээрийн албан ёсны болон албан бус тайлбарууд, илтгэл, өгүүлэл, тайлан зэрэг олон нэмэлт материалыг ашигласан билээ. Эдгээр материал, баримт бичгийг тайланд тусад нь хавсаргасан болно.

**2.холбогдох субъектээс судалгаа авах**

Энэ хүрээнд **хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөллөөс** судалгаа авахдаа аливаа төрийн болон төрийн бус байгууллагад харьяалагддаггүй төлөөллийг хамруулахыг зорьсон бөгөөд 2018 оны 07 дугаар сарын 05-ны өдөр Сэргээн засалт, сургалт үйлдвэрлэлийн төвд нийт төвийн 6 дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл болох 16 хүнийг хүлээн авч бүлгийн ярилцлага, болон асуулгын аргаар холбогдох мэдээллийг нэгтгэсэн болно.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 10 **ТББ-ын байгууллагын төлөөллөөс** ярилцлагын аргаар судалгаа авсан, эдгээр байгууллагын 4 нь хөдөлмөр халамжийн үйлчилгээ үзүүлдэг байгууллага бөгөөд дээд боловсролын байгууллага, ерөнхий

боловсролын байгууллага зэрэг төрийн бус байгууллагууд хамрагдсан байна.Тухайн байгууллагуудын ихэнх нь 6-10 ажилтантай байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд хамтран ажиллаж буй ТББ-ын тоог тодруулахад байгууллага бүр өөр өөр 1-10 хүртэл байна.

Судалгааны ажлын хүрээнд чиг үүргийн дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийн хангах үүрэг хүлээдэг **төрийн байгууллагууд** болох Боловсрол соёл, шинжлэх ухааны яам, Барилга хот байгуулалтын яам, Эрүүл мэндийн яам, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Зам тээвэр хөгжлийн яамны Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлийн нарийн бичгийн дарга нартай ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагыг зохион байгуулж, уулзалтын явцад дурдагдсан асуудлуудыг нэмэлтээр тодруулах зорилгоор Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны төрийн нарийн бичгийн даргын албан бичгээр дээрх яамдаас гадна Сангийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Үндэсний аудитын газар, Мэдээлэл, харилцаа холбоо технологийн газруудад хандаж хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах хүрээнд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаарх мэдээлэл болон түүнд зарцуулсан төсвийн талаарх мэдээллийг ирүүлэхийг хүссэн боловч 2018 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар 9 байгууллагаас албан бичгээр хариу ирүүлсэн, 2 байгууллагаас холбогдох мэдээллийг ирүүлээгүй, төсвийн талаар мэдээлэл бүх байгууллагууд бүрэн ирүүлээгүй, ирүүлсэн мэдээллийн хүрээнд дүн шинжилгээ хийв.

### 3.биечлэн судалгаа хийх

Энэ хүрээнд Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалтын үйлдвэртэй очиж танилцан, ганцаарчилан ярилцлаа. Хавсралтаас дэлгэрэнгүйг үзнэ үү. Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх энэхүү үнэлгээний ажлын зорилт нь хуулийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах, түүний хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид тухайн хуулийн зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлоход оршино.

Энэхүү судалгааны ажлын хэсэг бүр өөрийн санал, дүгнэлтийг агуулсан бөгөөд тэдгээрийн дагуу судалгааны ажлын дүгнэлт, зөвлөмжийн хэсгийн боловсрууллаа. Ингэхдээ өмнөх хэсгүүдэд дэлгэрэнгүй дурдагдсан, санаа давхардсан дүгнэлтийг дахин нуршилгүйгээр товч тодорхой, зарчмын болоод агуулгын ач холбогдолтой саналуудыг нэгтгэн багтаахыг зорилоо.

**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫГ ТООЦОХ СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН-г дараах агуулгын хүрээнд хийж гүйцэтгэлээ.**

1. Удиртгал
2. Түүвэрлэсэн хуулийн заалт
3. Хуулийн зохицуулалтын хэрэгжилтийн үр дагавар, тулгамдсан асуудал
4. Гадаад улсуудын хууль тогтоомжийн харьцуулалт
5. Хууль тогтоомж хоорондын давхардал, хийдэл, зөрчил

## 6. Дүгнэлт, зөвлөмж

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийн эдийн засгийн үр дагавар, зардлын тооцооны талаар тусдаа зөвлөхийн бие даасан тайлангаас үзнэ үү.

## II. ТҮҮВЭРЛЭСЭН ХУУЛИЙН ЗААЛТ

Монгол Улсын 2016 оны Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль нь нийт 12 бүлэг, 45 зүйлтэй. Эдгээрээс хангалттай хэрэгжиж чадаж байгаа эсэхэд уг харилцаанд оролцогчдоос эргэлзээтэй болох нь холбогдох илтгэл, судалгаа, дүн шинжилгээ, салбарын мэргэжилтнүүдийн дүгнэлт зэргээс ажиглагдаж буй дараахь хуулийн заалтыг түүвэрлэсэн болно. Үүнд: Гуравдугаар бүлгийн 8 дугаар зүйлийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний ажиллаж, амьдрах орчин, нөхцөлийг сайжруулах арга хэмжээ. 8.1 дэх хэсэг. 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4, 9.5 дахь хэсэг. 10 дугаар зүйл. Нийтийн тээврийн үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх. 10.1, 11 дүгээр зүйл. Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх. 11.1, 11.2.1-11.2.6 дахь заалт. Дөрөвдүгээр бүлгийн 14 дүгээр зүйл. Сурч боловсрох эрх. 14.1.3 дахь заалт, 14.3.2 дахь заалт, 15 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох нөхцөл, 15.1.1-15.1.4, 15.2, 15.3, 15.4, 15.8, 15.9, 15.10, 15.12 дахь хэсэг, 16.3, 16.4 дэх хэсэг, Тавдугаар бүлгийн 17 дугаар зүйл. Хөдөлмөрлөх эрх, 17.3 дахь хэсэг. 18 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг төрөөс дэмжих 18.1.1-18.1.6 дахь хэсэг. Зургадугаар бүлгийн 20 дугаар зүйл. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ 20.1, 20.2 дахь хэсэг. 26 дугаар зүйл. Нийгмийн халамжийн сангаас хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх тусламж, хөнгөлөлт, 26.1.6, 26.1.7, 26.1.9, 26.1.12, 26.1.13, 26.1.16, 26.2, 26.3, 26.4 дахь хэсэг. Есдүгээр бүлгийн 27 дугаар зүйл. Хууль зүйн туслалцаа авах эрх, 27.1, 27.2, 27.3, 27.4 дэх хэсэг, дахь хэсэг, 33 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүний биеийн тамир, спортын үйл ажиллагааг дэмжих. 33.2, 33.3, 33.4 дахь хэсэг, 37 дугаар зүйлийн 37.1, 37.2, 38 дугаар зүйлийн 38.4, 38.5 дахь хэсгийг тус тус сонгон авлаа.

## III. ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАР, ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Дээр тайлангийн 2 дугаар хэсэгт түүвэрлэсэн хуулийн үнэлгээ хийхээр сонгосон заалтуудаас эдийн засгийн үр дагаврыг тооцох зүйл, заалтын үнэлгээг 7 дугаар бүлэгт илэрхийлэх тул энэ бүлгийн хүрээнд бусад үр дагаврын хэрэгжилтийг авч үзсэн болно.

<b>Хөгжлийн бэрхшээлтэй хүний статистик</b>		
Үндэсний статистикийн 2017 оны судалгаагаар Монгол улсад нийт 100,993 хөгжлийн бэрхшээлтэй иргэн (55,758 эрэгтэй, 45,235 эмэгтэй) буюу нийт хүн амын 3,24%-ийг эзэлж байна. (Европын Ардчиллын Холбоо, Тэгш нийгэм ТББ-ын "Монгол Улсын хөгжлийн	Монгол Улсад 2017 оны байдлаар 103,6 мянга буюу нийт хүн амын 3.3 орчим хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна. (ХНХЯ, Жайка ОУХАБ, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: бодлого, үйл ажиллагаа, 2017 он, 9, 24 дэх тал)	Монгол Улсанд нийт 108.1 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаагийн 59.7 мянга нь эрэгтэйчүүд, 48.4 мянга нь эмэгтэйчүүд байна. (Хүн ам, орон сууцны 2010 тооллого "Хөгжлийн бэрхшээлтэй



бэрхшээлтэй иргэдийг эдийн засгийн эрхийг үнэлэх" төслийн тайлан, 2018 он, 11 дэх тал)		иргэд" сэдэвчилсэн судалгаа, 15 дахь тал)
--	--	---

Юуны түрүүнд хөгжлийн бэрхшээлтэй холбоотой тоо мэдээллийн зөрүүтэй байдал хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт, хүүхэд, гээд бүх салбар хүрээнд түгээмэл ажиглагдаж байна. Тиймээс цаашид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ерөнхий болон салбарын мэдээллийн санг нэгдмэлээр бүрдүүлж, өсөлт, бууралтыг хэмжихийн тулд тогтмол шалгуур үзүүлэлтэй болох, мэдээллийн нэгдмэл санг бүрдүүлэх шаардлага байгаа нь зүй ёсны асуудал байна.

### **3.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний ажиллаж амьдрах орчин нөхцөлийг сайжруулах арга хэмжээ**

Хуулийн Гуравдугаар бүлэг: “Хөгжлийн бэрхшээлтэй хүний ажиллаж амьдрах орчин нөхцөлийг сайжруулах арга хэмжээ”

8 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүний ажиллаж, амьдрах орчин, нөхцөлийг сайжруулах арга хэмжээ

8.1.Орон сууц, олон нийтийн барилга байгууламж, зам талбай, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны технологи нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байна.

9 дүгээр зүйл.орон сууц, дэд бүтцийн байгууламжийг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх

9.1 Төрөөс хөгжлийн бэрхшээлтэй хүн дэд бүтэц, орон сууц, олон нийтийн барилга байгууламжид саадгүй хүрэх, тэдгээрийг чөлөөтэй ашиглах нөхцөлийг энэ хууль, хот байгуулалтын болон барилгын тухай хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэх ажлыг иргэн, хуулийн этгээдтэй хамтран зохион байгуулна.

9.4.Орон сууц, нийгмийн дэд бүтцийн байгууламжийг ашиглалтад оруулах барилгын комиссын бүрэлдэхүүний дөрөвний нэгд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулна.

9.5.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагыг хангаагүй барилга байгууламжийг улсын комисс хүлээж авахыг хориглоно.

10 дугаар зүйл. Нийтийн тээврийн үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх

10.1.Нийтийн тээврийн байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүн нийтийн тээврийн хэрэгслээр чөлөөтэй зорчих нөхцөлийг бүрдүүлнэ.

11 дүгээр зүйл. Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх

11.1.Мэдээллээр үйлчилдэг хуулийн этгээд нь өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэх явцад хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрхийг хангах, техник, технологийн хэрэгсэл, бусадтай харьцах боломж, нөхцөлийг бүрдүүлнэ.

11.2.Хуулийн этгээд нь хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрх, харилцаа холбооны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

11.2.1.төрийн байгууллагын цахим хуудас хөгжлийн бэрхшээлтэй хүн мэдээллийг чөлөөтэй авах боломжийг бий болгох;

11.2.2.хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан компьютерын дэлгэц дээрх бичгэн мэдээллийг дуу авиа руу хөрвүүлэн хувиргах дэлгэц уншигч, программ хангамж болон шинэ технологи, систем, тусгай хэрэглээний тоног төхөөрөмжийг хөгжүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэх, тэдгээрийг эх хэл дээрээ ашиглах боломжийг бий болгох;

11.2.3.ном, сурах бичиг, сонин сэтгүүл, төрийн байгууллагын шийдвэр, албан бичиг, барааны шошго зэрэг бүх төрлийн хэвлэмэл материалыг хүртээмжтэй ашиглахад зориулсан бар кодтой хэвлэх;

11.2.4.цахим хуудас болон телевизийн мэдээ, мэдээлэл, танин мэдэхүйн болон өргөн нэвтрүүлгийг дохионы хэлний хэлмэрчтэй, текст унших боломжтой байдлаар нэвтрүүлэх арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх;

11.2.5.төрийн болон нийтийн үйлчилгээний байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүнд дохионы хэлний хэлмэрч, орчуулагч, бичигч, уншигч, хөтөчийн үйлчилгээ үзүүлэх арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх;

11.2.6.хараа, сонсголын бэрхшээлтэй хүмүүст мэдээлэл хүргэх зорилгоор байгуулагдсан ашгийн бус радио, телевизийг төрөөс дэмжих.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд орчны саад бэрхшээлээс шалтгаалан бусдаас байнга дэмжлэг авч, тэднээс хараат, нийгмийн идэвхгүй нэгэн болж байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан орчны дэд бүтцийн асуудал шийдвэрлэгдэхгүй байгаатай холбоотой ажээ. Монгол улсад өнөөдөр 103,6 хөгжлийн бэрхшээлтэй иргэд амьдарч байгаас, нийслэл Улаанбаатар хотод 67069 байна. Эдгээр иргэд жирийн иргэдийн адил нийгмийн үйлчилгээг авч чадахгүй байгаа ба үйлчилгээ авч чадахгүй байгаа нэг гол шалтгаан нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан дэд бүтэц байхгүй, төр захиргаа олон нийтийн үзвэр үйлчилгээний газрууд тэдний асуудлыг орхигдуулсны улмаас хязгаарлагдмал нөхцөл байдалд амьдрахаас өөр аргагүй байдал үүсээд байна. Аймаг, суманд амьдардаг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд нийгмийн харилцаанд оролцох, нэг газраас нөгөө газар луу хүрэх гэдэг бол цэвэр гэр бүлийнхэнээс хараат болдог нь ойлгомжтой юм.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг зориулалтын дагуу байгуулах шаардлагатай байгаа төрийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагыг доорх хүснэгтээр /маш сайн, сайн, дунд, муу гэсэн/ хэмээн үнэлж үзвэл ийм дүр зураг харагдаж байна.<sup>3</sup>

№	Байгууллагын нэр	Орц Гарц	Лифт	Ханийн бариул	Хөтлөвч хавтан	Ариун цэврийн өрөө	Гүйдэг хаалга
1.	Дүүргийн ХХҮХэлтэсүүд	сайн	дунд	муу	муу	байхгүй	муу
2.	Хороод	дунд	муу	муу	муу	муу	муу
3.	Дүүргийн ЗДТГ	дунд	дунд	муу	муу	муу	муу
4.	Эмнэлгүүд	сайн	дунд	маш	дунд	дунд	дунд
5.	Банк	дунд	дунд	муу	муу	муу	дунд

<sup>3</sup> С.Цэрэндулам, Я\_Төгөлдөр, "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлж байгаа дэд бүтцийн үйлчилгээнд хийсэн судалгаа", Хөгжлийн бэрхшээл судлал нь салбар дундын шинжлэх ухаан болох нь сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, 2017 он, 21 дэх тал

6.	Зочид буудлууд, эмийн сангууд	дунд	дунд	муу	муу	дунд	муу
7.	Үзвэр үйлчилгээний газрууд	дунд	дунд	дунд	муу	муу	муу
8.	Ууш хоолны газрууд	муу	дунд	дунд	муу	муу	муу
9.	Хүнс барааны дэлгүүр	дунд	дунд	муу	муу	муу	муу
10.	Сургуулиуд	дунд	муу	дунд	дунд	дунд	муу

Барилга байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан дэд бүтцийг бий болгох явган хүний зам, саадыг багасгах, протез, ортопедийн хэрэгслээр хангах, харааны бэрхшээлтэй хүнд зориулж байр ном сурах бичгээр хэвлэх том үсгээр бичих дохионы орчуулагчтай болгох гэх мэт аргуудаар хүртээмжийг бий болгож болно.

Өвчлөл гэмтлийн шалтгаан нь авто ослоор 40% нь, үйлдвэрлэлийн ослоор 22,8%, ахуйн ослоор мөн 22,8% ба төрөлхийн 3,8%, өвчний улмаас 1,9% гэсэн үзүүлэлттэй гарсан байна. Үүнээс үзэхэд авто ослоор гэмтэгчдийн тоо харьцангуй өндөр байгаа сүүлийн үед энэ төрлийн осол нэмэгдэх болсны жишээ бөгөөд хүмүүс төрөл бүрийн осол гэмтлийн золиос болсоор байна. Тиймээс эрүүл хүмүүст зам тээврийн автоослын ийм эрсдэлтэй нөхцөлд хөгжлийн бэрхшээлтэй хүний дэд бүтцийн хүртээмж хангалтгүй байх нь тэднийг нийгмийн харилцаанаас шууд тусгаарлах хүчин зүйл болох нь илэрхий ажээ. Нийгмийн харилцаанд тэгш эрхтэй оролцоход юу саад болж буй талаарх асуултад 2,36% нь өөрөө сонирхолгүй, 27,6% нь нийгмийн харилцаа, 80,0% нь зам шат хаалга, 98,0% нь унаа гэсэн хариултыг өгчээ.<sup>4</sup>

**Шуугтээ**<sup>5</sup>: Автобусанд орох налуу зам байдаггүй. Харааны бэрхшээлтэй хүмүүсийг дуудах дуут дохио Монголд хоёрхон байдаг, 100 айлын 129 дүгээр сургуульд байдаг. Такси барьж явах дургүй, явган замаар явахаар олон самбар, шон тэмдэг тавьсан байдаг. Үзвэр үйлчилгээний газар үйлчлүүлэхэд хүндрэлтэй. Монголд хөгжлийн бэрхшээлтэй иргэн хөгжиж чадахгүй байгаа нь төрөөс баримталж байгаа бодлого бодитой хэрэгждэггүй, зөвхөн чуулган дээр яригдаад өнгөрдөг. Сүүлийн үед оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд нэмэгдэж байгаа үүний гадаад дотоод шалтгааныг олох хэрэгтэй гэж бодож байна.

ЦЕГ-аас СБД-ийн 11 хороо, 29 дүгээр тусгай дунд сургууль, харааны бэрхшээлтэй хүүхдийн 116 дугаар сургууль орчмын замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор хурд сааруулагч, сургууль орчмын бүс тэмдэг, тэмдэглэл, явганы хүний гарцын тэмдэг, хайс, хашлага байрлуулах тухай саналыг Нийслэлийн автозамын хөгжлийн газарт 2018.03.20-ны албан бичгээр хүргүүлсэн. ХУД-т байрлах Хараагүй иргэдийн эрхийг хамгаалах холбооны урд талын явганы хүний гарцын гэрлэн дохио нь дуут дохиогоор тоноглогдсон бөгөөд явган хүний гарцын тэмдгийг шар хүрээтэй тэмдгээр солиулан стандартад нийцүүлж харагдах байдлыг сайжруулж, хурд сааруулагч, саадыг тойрч гарах чиг тэмдэг, хурд сааруулагч тэмдэг, тэмдэглэлийг иж бүрнээр шинэчлэн хийлгэсэн.<sup>6</sup>

Монгол Улсын Барилгын тухай хуулийн 11.1.6-д хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн

<sup>4</sup>Мөн тэнд, 22 дахь тал

<sup>5</sup> Мөн тэнд, 23 дахь тал

<sup>6</sup> ХЗДХЯ-ны 2018\_07.20-ны өдрийн 1-4/3700 тоот албан бичгээр ирүүлсэн мэдээллээс.

эрхийг хангах, барилга байгууламж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг зорчих, хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангасан байхаар төлөвлөн баригдсан байх. 12.1.6-д зааснаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ, техникийн шаардлагыг хангасан байх шаардлагыг барилгын зураг төсөлд тавина. Энэхүү хуулийн заалтад нийцүүлэн Монгол Улсын барилгын норм, дүрмээр Олон нийт, иргэний барилга /БНБД 31-03-03/, Олон нийт, иргэний барилга (нэмэлт) /БНБД 31-03-03\*/11/, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцсэн зураг төсөл зохиох дүрэм /БД 31-112-11/, Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм /БНБД 30-01-04/, Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль /БД 31-101-04/, Иргэний барилгын төлөвлөлтөнд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин, үндсэн шаардлага MNS 5682-2006, Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөлт /БНБД 31-01-10/, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцсэн зураг төсөл зохиох дүрэм /БД 31-112-11/, Захиргааны зориулалттай олон нийтийн барилга /БНБД 31-04-12/, Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин, үндсэн шаардлага MNS 6055-2009, Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам, техникийн шаардлага MNS 5682-2006, Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар MNS 6056-2009-аар тус тус зохицуулдаг байна.

ХНХСайдын 2018.04.18-ны өдрийн А/93 тушаалаар хөдөлмөр хамгааллын салбарын нийслэл дэх нийт 37 байгууллагуудын барилга, байгууламжууд холбогдох стандартад нийцсэн эсэх хүртээмжийн үнэлгээг нэгдсэн удирдамжийн дагуу Түгээмэл хөгжил төв, Сонгино бие даан амьдрах төв, Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо ТББ-аас 2018 оны 05-06 дугаар сарын хооронд гүйцэтгэсэн байна. Энэхүү үнэлгээг хийсэн Түгээмэл хөгжил төвийн ажлын тайландаа дурдсанаар дараахь дүгнэлтийг хийжээ.

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> <li>• Байгууллагууд орчноо сайжруулах, налуу замтай болох зэргээр төлөвлөгөөт үйл ажиллагаатай байна.</li> <li>• ХХҮХ-ийн ажилтан нар бүгд байгууллага хүртээмжтэй байх ёстой тухай ойлголт авсан байв.</li> <li>• Үнэлгээ хийгдсэн ихэнх байгууллага ямар нэг байдлаар орчин бүрдүүлэх, ажил хийгдсэн байв.</li> </ul> <p>Хөгжлийн бэрхшээлтэй хүний зорчих боломжийг бүрдүүлэх ажил, төлөвлөгөөтэй байсан</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Хөрөнгө гаргаж хийсэн хүртээмжийн асуудал бодит хэрэгцээг хангаагүй байх, ХБ иргэдийн оролцоогүй хийгдэх, ойлголт мэдлэг дутмаг, стандарт баримтлаагүй байх</li> <li>• Хөрөнгө санхүүгүй байх, бага төсөвтэй.</li> <li>• Хэрэгжүүлэгч байгууллагын талаарх мэдээлэлгүй</li> <li>• Уялдаа холбоогүй байдал</li> </ul>

Анхаарах зүйлс:

- Нийт байгууллагуудын налуу замаас нэг ч стандарт зам байхгүй нь мэдээлэл дутуу нэг хэсэг байхад, ор нэр төдий аргалах гэсэн Монгол хандлага ч байгаа гэж үзэж байна.
- Үнэлгээ хийсэн ХХҮХ-үүдээс цөөнгүй байгууллага стандарт огт хангаагүй түрээсийн байранд байгаа нь онцгой анхаарал татаж байв.
- Нийт байгууламжуудын 90% нь авто зогсоолдоо хөгжлийн бэрхшээлтэй хүний авто зогсоолын төлөвлөлт хийгээгүй
- Зогсоолын өргөн стандарт бус өргөн

- Тэмдэг тэмдэглэгээ 90% байхгүй.
- Нийт 11-н байгууллагаас 1 нь налуу замгүй байв.
- 8 байгууллагын налуу зам нь стандарт бус.
- Нийт 11-н байгууллагаас 1 нь налуу замгүй байв.
- 8 байгууллагын налуу зам нь стандарт бус.
- Стандартад заагдаагүй ч цаг уурын онцлогоос хамаарч давхар хаалга төлөвлөдөг.
- 6-н байгууллага стандарт бус дотор хаалганы өргөнтэй бол 8 нь стандарт бус гадна

хаалгатай

- 3 байгууллага хаалга хоорондын зай хэт ойр
- 8 байгууллага дотор болон гадна хаалганы босго стандарт бус буюу саадтай
- Үнэлгээ хийгдсэн бүх байгууламжийн ариун цэврийн өрөөний хаалга стандарт бус.
- Өөр нэг чухал үзүүлэлт болох суултуурын өмнөх орон зай 11 газар стандарт бус

буюу хүртээмжгүй

- байгууламж нэмэлт тоноглол буюу бариулгүй

Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо ТББ-ын <sup>7</sup> тайланд дурьдсанаар

• Налуу зам 1 талдаа бариулгүй 7,4 м урт буюу сандарт бус налууулалттай тул тэргэнцэртэй иргэд зорчиход хэт огцом унах эрсдэлтэй

- Хаалганд хүрэх хэсэгт шат төлөвлөсөн нь ХБХ-т хүртээмжгүй болгосон
- Лавлагаа мэдээллийн хэсэг хүртээмжтэй хэдий ч үйлчлүүлэгчийн ашиглах ширээний тавцан хэт бага эсхүл лавлагаа мэдээллийн тавцангийн өндөр-117см тэргэнцэртэй иргэнд үйлчилгээ авах боломжгүй
- Ариун цэврийн өрөөний хаалганы өргөн 65 см байгаа тул тэргэнцэр иргэд үйлчилгээ авах боломжгүй . Мөн өрөөний доторх зай талбай хангалтгүйн дээр хананд зориулалтын бариулыг суурилуулаагүй
- Мэдээллийн самбар өнгө үзэмжтэй хийгдсэн хэдий ч тэргэнцэртэй одой иргэдэд , өндөр настанууд харж ашиглах боломжийг хааж, саМбарын өмнө сандал байршуулсан Мөн харааны бэрхшээлтэй иргэдэд хүртээмжгүй
- Байгууллагын гадна тайлбайд харааны бэрхшээлтэй хүнд зориулсан хөтөч зам төлөвлөөгүй
- Угтах үйлчилгээний ажилтан ажиллуулдаг сайн туршлагатай хэдий ч үйлчилгээний ажилтанг дохион хэлний анхан шатны мэдлэгтэй болгох
- Авто зогсоол төлөвлөөгүй болохыг дурджээ.

Сонгино бие даан амьдрах төвийн үнэлгээний тайланд дурьдсанаар дараах дүгнэлтэнд хүрсэн байна. Үүнд:

- Нийт 12 байгууллагаас 3 байгууллага л ариун цэврийн өрөөнд бариул төлөвлөсөн боловч дотор талдаа багтаамж байхгүй.
- Сайн байсан зүйл ихэнх байгууллагуудын өрөөний хаалганууд босго байхгүй байсан.
- Гадна, дотор хаалганууд босготой.
- Хаалга стандарт хангаж буй газар бараг байхгүй.
- Нэг байгууллагаас бусад нь стандартад нийцсэн налуу зам байхгүй, байгаа газруудад нь хэт огцом ашиглах боломжгүй байна.

<sup>7</sup> “Түгээмэл хөгжил” төвийн ХНХЯ-ны харъяа байгууллагуудад дэд бүтцийн хүртээмжийн үнэлгээ хийсэн тайлангаас

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар ойлголт мэдээлэл хомс, ихэнх нь эмнэлэгийн загвар талаас харж хүлээж авч байна.
- Мэдээллийн хүртээмжгүй байдал бүх газруудад.
- Авто машины зогсоолд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэмдэг тэмдэглэгээ байхгүй зэрэг асуудлууд байна.

Иймээс цаашид стандартыг хэрэгжүүлэх шаардлагатай зөвлөмжийг дээрхи гурван байгууллагаас асуудал тус бүр дээр тодорхойлон бичсэн байна. Тухайлбал, налуу замын стандарт, шатны бариулын үзүүр хэсэг, орох хэсгийн босгоны өндөр, байгууламжийн гадна болон дотор талбайд харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан брайль замыг хийх буюу бариулыг хана дагуулан хийх, орох хаалганы гадна тал дотор тал хоёрт анхааруулах хавтанг хийх, байгууллагын доторх шатны бариул дээр брайль тэмдэглэгээ хийж, шатны эхлэл төгсгөлийг тод өнгөөр ялгаж өгөх эсвэл анхааруулах хавтанг хийх, нэгээс доошгүй хүртээмжтэй ариун цэврийн өрөөг 1 дүгээр давхарт төлөвлөх, ариун цэврийн өрөөний зай, тоноглолыг стандартын дагуу хийх, байгууллагын гадна талбайд хөгжлийн бэрхшээлтэй зорчигчид зориулсан машины зогсоолыг төлөвлөх, байгууллагын үйл ажиллагааны зорилго чиглэл, байгууламжийн бүтэц зохион байгуулалтыг харуулсан мэдээллийн самбарыг тэргэнцэртэй, одой, сул хараатай, өндөр настнуудад хүртээмжтэйгээр хийж төлөвлөх асуудлыг стандартын дагуу хэмжээ, зай, нөхцөлтэй нь тодорхойлсон байна. Үүнээс гадна энэхүү үнэлгээний дагуу урт ба богино хугацааны ажлын төлөвлөгөө боловсруулах, шийдвэр гаргах төрийн зохих шатны эрх бүхий этгээдэд энэхүү үнэлгээний товч мэдээлэл боловсруулан хүргүүлэх, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн бус байгууллагуудтай хамтарч ажиллахыг мөн зөвлөмждөө тусгасан байна.

**Шигтгээ:** Тэргэнцэртэй хүний хувьд би хотод үнэхээр муу дүн тавина. Улаанбаатар хот бол аймшигтай, үнэхээр харгис байна л гэж хэлнэ. Би өөрөө машинаа бариад явдаг. Нийгмийн амьдралаа идэвхитэй байж ажлаа хийнэ, мөн хувийн амьдралаа зохицуулна, бусдад дараа болохгүй гээд бүх чадлаараа зүтгэдэг. Гэтэл энэ ярьж байгаа дэд бүтцээс авахуулаад хүмүүсийн хандлага, ойлголт маш хэцүү байдаг. Би уг нь ажил хөдөлмөр эрхлээд, цалин аваад, улсдаа татвар төлөөд, өрхийнхөө амьдралыг аваад явж байгаа. Зарим үед жирийн хүнээс илүү ачаалалтай ажилладаг. Гэтэл хүмүүс тэгж ойлгодоггүй, бидний ялгаатай талыг л хараад байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд халамжийн мөнгө өгөөд, гэрт нь байлгах ёстой гэдэг социализмын үеийн сэтгэлгээ одоо хүртэл ард иргэдэд байсаар л байна. Энэ утгаараа төрийн бодлого, хийж байгаа дэд бүтцийн төлөвлөлт нь үнэхээр муу. Улаанбаатар хотод олон гоё шинэ барилгууд баригдаж байна. Хүмүүс тэнд орж амьдарч, үйлчлүүлэх ёстой. Бид бас хүн шүү дээ. Бид бусадтай адил дэлгүүр орж, ресторанд сууж, үйлчилгээний газруудаар үйлчлүүлэх эрхтэй. Гэтэл тэр дэд бүтцүүд нь байдаггүй. Имарт дэлгүүр гарч ирээд бидний хувьд нөхцөл байдал нилээд таатай болж ирсэн. Хүнтэй гадуур хоолонд оръё гэхээд аль газар налуу замтай билээ, аль ресторан нь тусгай 00-той билээ гээд ярьсаар байгаад таардаг. Тэргэнцэртэй хүн өөрөө ороод, бие даагаад зорчоод явах байшин барилга Монголд байдаггүй.<sup>8</sup> (Б.Отгонтуяа ikon.mn-д нийтлэгдсэн ярилцлагын хэсгээс)

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 9.4 болон 9.5-д заасан орон сууц, нийгмийн дэд бүтцийн байгууламжийг ашиглалтад оруулах барилгын комиссын

<sup>8</sup> <https://ikon.mn/opinion/1613>

бүрэлдэхүүний дөрөвний нэгд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагыг хангаагүй барилга байгууламжийг улсын комисс хүлээж авахыг хориглоно хэмээсэн заалтын дагуу Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 184 дугаар тушаалаар Сайдын зөвлөлийн бүрэлдэхүүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах байгууллагуудын төлөөлөл болгож “Тэргэнцэртэй иргэдийн нэгдсэн холбоо” ТББ-ын тэргүүн Б.Чулуундолгорыг оруулан ажиллаж байна. Барилгын хөгжлийн төвийн мэдээгээр 2017 онд нийт 38 шинэ барилга, байгууламж ашиглалтанд орсон байна.<sup>9</sup> Хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагыг хангаагүй барилга байгууламжийг улсын комисс хүлээж авахыг хориглосон буюу хөгжлийн бэрхшээлтэй иргэний төлөөлөл татгалзсан тохиолдол байхгүй байх бөгөөд 2016 оноос өмнө зураг төсөл батлагдсаны дагуу баригдсан тул дараа нь хүлээж авах эсэх дээр татгалзах бодит боломж хомс байгаагаар тайлбарлаж байв.

Нийтийн тээврийн аль төрлөөр зорчдог талаар асуухад автобусаар 8,5%, микро автобусаар 0.0%, 75% таксигаар, 46.6 % нь бусдын унаагаар, 7.6 хувь нь өөрийн унаагаар зорчдог гэжээ.<sup>10</sup> Үүнээс үзэхэд нийтийн автобус, микро автобусаар зорчих боломж хомс, голчлон такси болон бусдыг гуйж явдаг байна.

Хуулийн 11 дүгээр зүйлд заасан Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх зүйлийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн яаралтай тусламжийн дуудлагыг дуут болон дүрст хэлбэрээр хүлээн авч, дамжуулах тэдэнд зориулсан үйлчилгээний байгууллагатай холбох зорилготой тусгай дугаар 104 үйлчилгээ 2017 оны 09 дүгээр сараас эхлэн Улаанбаатар хотод нэвтэрч өнгөрсөн хугацаанд нийтдээ 300 орчим хэрэглэгчтэй болжээ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан “Миний туслах-104” дүрсээ харж ярих, эсхүл үүрэн холбооны цахим зурвас хүлээн авах үйлчилгээг Дархан-Уул аймагт 2018 оноос эхлэн хэрэгжүүлэхээр бэлтгэж байна.<sup>11</sup> Бусад заалтууд нь бодит байдалд хэрэгжүүлээгүй байна.

ЦЕГ-аас сонсголтгүй иргэдэд эмнэлэг, цагдаа, онцгой байдал зэрэг яаралтай түргэн тусламжийг шуурхай хүргэх үүднээс тусгай дугаарын 101,102,103,105 утасны дугаарт цахим зурвас (sms)-аар дуудлага өгөх, мэдээлэл авах үйлчилгээг ХНХЯ-тай хамтран нэвтрүүлж, нэг шугамыг чөлөөлж, программ хангамжийн асуудлыг шийдвэрлэсэн.<sup>12</sup>

**Дүгнэлт:** Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 8.1,9.1,10.1,11.1, 11.2.1-11.2.6 дахь заалтуудын тухайд зорилгодоо бүрэн дүүрэн хүрч чадаагүй, практикт хэрэгжилт хангалтгүй, талуудаас бүрэн хүлээн зөвшөөрөгдөөгүй байна. Эдгээр заалтын хэрэгжилт хангалтгүй байгаа гол шалтгаан нь өмнө баригдсан барилга, байгууламж, зам, талбайн хэрхэх талаар хуульд ямар нэгэн зохицуулалт хийгээгүй, зөвхөн 2016 оноос хойш баригдаж, ашиглалтад оруулж буй дэд бүтцийн барилга байгууламжинд хамааралтай байхаар заасан. Мөн түүнчлэн хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний, санхүүгийн нөөцийн боломжтой шууд хамааралтай байна. Харин 11.2.1-11.2.6 дахь заалтыг амьдралд хэрэгжүүлж эхлэсний дараагаар тодорхой дүгнэлт өгөх нь зүйтэй байна.

<sup>9</sup> Б.Энхболд, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах чиглэлээр Барилгын хөгжлийн төвийн 2017 онд зохион байгуулсан ажлын биелэлт”, 2018.07.03-ны өдрийн онол, практикийн бага хуралд хэлэлцүүлсэн илтгэлээс.

<sup>10</sup> С.Цэрэндулам, Я.Төгөлдөр, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлж байгаа дэд бүтцийн үйлчилгээнд хийсэн судалгаа”, Хөгжлийн бэрхшээл судлал нь салбар дундын шинжлэх ухаан болох нь сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, 2017 он, 22 дахь тал

<sup>11</sup> <http://montsame.mn/read/79405>

<sup>12</sup> ХЗДХЯ-ны 2018.07.20-ны 1-4/3700 тоот албан бичгээр ирүүлсэн мэдээллээс.

### 3.2 Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрх

Хөгжлийн бэрхшээлтэй хүний статистик: боловсрол	
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо 2017-2018 онд нийт 7279 байна. (БСШУСЯ-ны газрын дарга Т.Ням-Очирын "Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийн хэрэгжилт, тулгамдсан асуудал" сэдэвт 2018.07.03-ны өдрийн онол, практикийн бага хуралд хэлэлцүүлсэн илтгэлээс)	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо 2017-2018 онд нийт 10437 байна. (ХНХЯ-ны газрын дарга С.Тунгалагтамирын "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хэрэгжилт, тулгамдсан асуудал" сэдэвт 2018.07.03-ны өдрийн онол, практикийн бага хуралд хэлэлцүүлсэн илтгэлээс)

Хуулийн Дөрөвдүгээр бүлэг. Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрх. 14 дүгээр зүйлийн 14.1.3 дахь заалт бүх шатны боловсролын тогтолцоонд хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох, мэргэжил эзэмших нөхцөлийг бүрдүүлэх, тохирох хэрэглэгдэхүүнээр хангаж, дэмжлэг туслалцаа үзүүлэх,

14.3.2 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудыг тэдний хүйс, оршин суугаа газар, нийгэм, эдийн засгийн хүчин зүйлээс үл хамааран бүх шатны боловсролд тэгш хамруулах, тухайн хүүхэд, залуучуудын онцлог, хэрэгцээг харгалзсан боловсролын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх, тэдний шаардлагад нийцсэн хичээлийн анги, танхимыг ердийн сургуулиудад зохион байгуулах үүргийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хүлээх.

15 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох нөхцөл 15.1.Бүх шатны сургалтын байгууллага болон мэргэжил олгох төв нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид амьдрах ухаан, мэргэжлийн ур чадварыг үр дүнтэй эзэмшүүлэх бөгөөд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ: 15.1.1.тухайн суралцагчийн онцлогт тохирсон хамгийн зохистой арга хэлбэрээр боловсрол олгох;15.1.2.хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг онцлог хэрэгцээнд нь тохирох ном, сурах бичиг, гарын авлага, материал, тусгай хэрэглээний сургалтын тоног төхөөрөмж, хэрэгслээр хангах;15.1.3.сургалтын тусгай хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу сургалтыг явуулах;15.1.4.сургалтыг хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлог хэрэгцээнд нийцсэн заах арга зүй, арга барил эзэмшсэн багш, сурган хүмүүжүүлэгч явуулдаг байх;15.2.Бүх шатны сургалтын байгууллагын хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирох хэрэглэгдэхүүн, сургалтын орчныг бүрдүүлэх журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.15.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол олгох сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.15.4.Хавсарсан хөгжлийн бэрхшээлтэй болон байнгын асаргаа шаардлагатай хүүхдийн ганцаарчилсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг тухайн сургалтын байгууллагын мэргэжил арга зүйн зөвлөл, эцэг эхийн оролцоотойгоор боловсруулж батална.15.8.Энэ хуулийн 15.6-д заасан сургалтын зардлын хэмжээ, олгох журмыг Засгийн газар батална.

15.9.Энэ хуулийн 15.7-д заасан ном, сурах бичиг, тусгай хэрэглээний сургалтын тоног төхөөрөмж, хэрэгслийн жагсаалт, зардлын хэмжээ, олгох журмыг боловсрол болон хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.



15.10. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь харьяалах засаг захиргааны нэгжид үйл ажиллагаа явуулж байгаа бүх шатны боловсролын байгууллагыг энэ хуулийн 15.1-д заасан сургалтын орчныг бүрдүүлэхэд зориулж тусгай хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлж, холбогдох зардлыг орон нутгийн төсөвт тусган шийдвэрлэнэ.

15.12. Ерөнхий боловсролын тусгай сургуулийн суралцагчийн үдийн хоолны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж, үдийн хоолоор үйлчлэх журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

16 дугаар зүйл. Багшийн мэргэжил

16.3 Энэ хуулийн 16.2-т заасан арга зүй, арга барилыг олгох сургалт болон зөвлөх үйлчилгээг гэрээний үндсэн дээр төрийн бус байгууллага гүйцэтгэж болно.

16.4 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол олгох багш, хэл засалч, хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч, дохионы хэлний багш, сэтгэл зүйч, арга зүйчийг сургалтын төрийн сангийн зардлаар дотоод, гадаадад сургаж бэлтгэнэ.

Өнөөдөр Монгол улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 10 түүнээс дээш насны нийт 103 6300 иргэн байгаагийн 80400 албан боловсрол эзэмшсэн, 22600 нь боловсрол эзэмшээгүй гэдэг статистик байна. Хөгжлийн бэрхшээлтэй болон нийт хүн амын аль алиных нь хувьд бүрэн дунд боловсрол эзэмшсэн хүн амын хувь хамгийн өндөр буюу 30 орчим хувь бөгөөд үүний дараагаар суурь, бага боловсрол орж байна. Хөгжлийн бэрхшээлтэй нийт хүн амын 7.7 хувь нь дээд боловсролтой байхад нийт хүн амын дундах дээд боловсролтой хүн амын эзлэх хувь түүнээс 2.4 дахин өндөр байна. Харин эсрэгээрээ хөгжлийн бэрхшээлтэй боловсрол эзэмшээгүй хүн амын хувь нийт хүн амаас 3 дахин өндөр байна<sup>13</sup>. Нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэний 20.5 хувь бүрэн бус дунд, 19.5 хувь бага боловсролтой, үлдсэн боловсролгүй хүмүүсийн 72.6 хувь нь бичиг үсэг мэдэхгүй байна.<sup>14</sup>

Монгол Улсын боловсролын тогтолцоонд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг ердийн сургалттай болон тусгай сургалттай сургуульд сурах эрхтэйг нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 14.1.3, 14.3.2 дахь заалтаар заасан байдаг. Гэвч ердийн сургалттай сургуульд тэд суралцах нь цөөн, олонх нь тусгай сургуульд сурдаг. 2016-2017 онд нийтдээ 8362 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байсан бол 2017-2018 онд 7279 байна. Сургууль завсардсан хүүхэд 354 байгаа ажээ.<sup>15</sup> Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо 1599 байна.<sup>16</sup> Хөгжлийн бэрхшээлтэй хүн бусад иргэний хамт сурч боловсрох эрхтэй (14.1) бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг бэрхшээлээс нь үл хамааран бүх шатны боловсролд бүрэн хамруулах (14.3.2) тухай уг хуульд заасан нь тэгш хамруулан сургах бодлогод нийцжээ. Улмаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ердийн ангид бусад хүүхэдтэй хамт суралцаж, үндэсний стандартыг хангасан боловсрол эзэмших боломж баталгаажиж байна. Үүний зэрэгцээ Бага, дунд боловсролын тухай хуульд туссан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тусгай сургуульд сургах заалт хүчинтэй хэвээр байгаа ба хүүхдээ тусгай эсхүл ердийн сургуульд сургах сонголт эцэг, эхчүүдэд нээлттэй байна. Тусгай боловсролын 6 сургууль, 2 цэцэрлэг зөвхөн Улаанбаатар

<sup>13</sup> [www.meds.gov.mn](http://www.meds.gov.mn)

<sup>14</sup> Б.Мөнхзаяа, "Монгол Улс дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өнөөгийн эрх зүйн зохицуулалт", Хөгжлийн бэрхшээл судлал нь салбар дундын шинжлэх ухаан болох нь сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, 2017 он, 38 дахь тал

<sup>15</sup> Т.Ням-Очир, БСШУСЯ, "Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийн хэрэгжилт, тулгамдсан асуудал", 2018.07.03-ны өдрийн онол, практикийн бага хуралд хэлэлцүүлсэн илтгэлээс.

<sup>16</sup> Боловсролын салбарын 2017-2018 оны хичээлийн жилийн статистикийн мэдээллийн эмхэтгэл (I), 12 дахь тал

хотын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг нь хөдөө орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжгүй болдог. Тэгш хамруулан сургах бодлогыг тунхаглаад орхилгүй, хэрэгжилтийг хангах механизмыг уг хуульд зааж өгчээ. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээнд нийцсэн ганцаарчилсан дэмжлэг үзүүлэх тухай хуульд заасан (14.1.3,15.1) нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурлагын амжилтыг дэмжих чухал бодлого юм. Энэ бодлого хэрэгжсэнээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 40 орчим хувь нь цэцэрлэг, сургуулийн бага ангид суралцаж байгаад.. дунд ахлах ангид 14 хувь хүртлээ буурдаг байдлын засаж сайжруулахад хуулийн заалт чухал үүрэг гүйцэтгэх юм. Харин хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээг үнэлэх, үнэлгээнд түшиглэн ганцаарчилсан дэмжлэгийг тодорхойлох аргазүйг боловсруулж, нэвтрүүлэх шаардлагатай юм. Хэрэгцээг стандартчилж болохгүй ч гэсэн хэрэгцээг тодорхойлох үйл явц, процессыг нэгдсэн байдлаар тогтоох ёстой.<sup>17</sup>

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 15.4-т заасан "мэргэжил, аргазүйн зөвлөл" хэмээх бүтэц ерөнхий боловсролын сургууль дээр байдаггүй тул өнөөдрийн байдлаар хэрэгжихгүй, тайлбар шаардлагатай хэвээр байгаа ажээ.<sup>18</sup> БСШУСЯ-ны газрын дарга Т.Ням-Очирын "Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийн хэрэгжилт, тулгамдсан асуудал" сэдэвт 2018.07.03-ны өдрийн онол, практикийн бага хуралд хэлэлцүүлсэн илтгэлд дурдсанаар Ердийн ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургах анги, бүлэг нээх харилцааг зохицуулсан журмын төсөл, Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний үлгэрчилэн загвар, Сургалтын төлөвлөгөөний шинэчилсэн хувилбарыг тус тус боловсруулаад, батлуулахаар төлөвлөж байгаа ажээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн боловсролд хамруулахад гол бэрхшээл нь

- **орчны бэрхшээл** болох орц, гарц, шат, довжоо, 00-ийн өрөө зэрэг байдаг, сургуулиуд налуу зам, шат хийсэн хэдий ч стандарт нормыг хангаж чадаагүй байна. Өөрөөр хэлбэл гялгар, гөлтгөр материалаар хийсэн нь халтирч унах эрсдэлд оруулж байна. Ихэнх сургуулиуд налуу зам, шат, лифт, чиглүүлэгч зэргийг төлөвлөөгүй байна.
- **хуулийн хэрэгжилтийн хангах механизм, хөшүүрэг сул.** Барилгын стандарт, норм-шаардлага хангахгүй байна. Түүний араас хяналт шалгалт шахалт муу. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиар БСШУСЯ-ны үүрэг хүлээсэн журам, стандартууд ихэнхи нь батлагдаагүй.
- багшийн заах аргазүй, туслах багш ажиллахгүй бол нэг үндсэн багш хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хүрч заахад бэрхшээлтэй, ачаалалтай болдог,
- мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээн тохирсон ганцаарчилсан дэмжлэгийг одоогоор ерөөс практикт хэрэгжүүлэхгүй байна. Илүү эцэг, эхийн болон тухайн анги даасан багшийн, эсхүл захирлын санаачилгын асуудал болдог ажээ.

СХД-ийн 162 дугаар сургуулийн захирал хандлага зөв, ойлголт сайтай учир ЕБС-даа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургахад сайн анхаарч, сурах орчныг хангахад болон багш нартай нь хамтран сургалтыг дэмждэг.

ТББ-ын төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас, 2018.06.26

<sup>17</sup> ННФ, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өгөх санал, шүүмж, 2018 оны 6 дугаар сар, Хуулийн шүүмжийн цуврал 20, 2 дахь тал

<sup>18</sup> ННФ, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өгөх санал, шүүмж, 2018 оны 6 дугаар сар, Хуулийн шүүмжийн цуврал 20, 3 дахь тал

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхчүүдийн холбоо ТББ нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хангуулах тал дээр төрийн болон бусад байгууллагатай ойр хамтран ажилладаг байна. Зөвлөх эцэг эхчүүд Улаанбаатар хотын хэмжээнд хэсэгчилсэн байдлаар хороодод холбогдох үйл ажиллагаанд тусалж, дэмждэг байна. Хуулийн 16.3-т заасан ТББ-д чиг үүрэг шилжүүлэх заалт одоогоор хэрэгжээгүй байна. Цаашид хэрэгжүүлэхийн тулд ямар шалгуураар хэрэгжүүлэх вэ гэдэг асуудлыг шийдвэрлэх шаардлагатай хэмээн БСШУСЯ-ны хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлийн нарийн бичгийн дарга тайлбарлаж байна.

Тусгай цэцэрлэг, ерөнхий боловсролын тусгай сургуулийн багш, удирдах ажилтаны мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын хөтөлбөрийг боловсруулан 395 багш, удирдах ажилтан, туслах багшийг сургасан байна. ЕБС-ын сургуулийн бага ангид 72 туслах багш ажиллаж байна. "Журам чиглэл шинэчлэн батлах тухай " 2014 оны Засгийн газрын 71 дүгээр тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах замаар тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр суралцаж байгаа магистр, докторын зэрэг олгох сургалтын зардлын хэмжээ, олгох асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна. МУБИС-ын Боловсрол судлалын сургууль дээр Тусгай хэрэгцээт боловсролын мэргэжлийн тэнхимийг 2017 оны 12 дугаар сард байгуулж үндсэн 3 багш, гэрээт 3 багш, 1 аргазүйчтэйгээр үйл ажиллагааг нь эхлүүлээд байна. Тусгай хэрэгцээт боловсролын хөрвөх 1 жилийн сургалтыг МУБИС, Дорнод Их сургуульд түшиглэн зохион байгууллаа. 2018 онд Улаанбаатар хотоос 21, аймгаас 2 хөгжлийн бэрхшээлтэй шалгуулагч ЭЕШ өгсөн байна. 2017 онд их, дээд сургуулийн элсэлтийн шалгалтанд нийт 24 хөгжлийн бэрхшээлтэй иргэн шалгалт өгсөн байна.<sup>19</sup>

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 14.1.3, 15.2-т заасан "тохирох хэрэглэгдэхүүн" гэдгийг Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн тодорхойлсоноор тохирох хэрэглэгдэхүүн гэдэг нь "тодорхой тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын нэгэн адил хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг эдлэх явдлыг хангах үүднээс зохицоогүй, эсхүл үндэслэлгүй саад тотгорыг арилгах, багасгахад чиглэгдсэн нэн хэрэгцээтэй бөгөөд шаардлагатай тохируулга хийж өөрчилж засварлахыг хэлнэ."Сургалтын орчин нөхцөлд тохирох хэрэглэгдэхүүн гэж суралцагчдын онцлог хэрэгцээг хангахын тулд авах арга хэмжээ, арга хэрэгсэл, төхөөрөмжүүдээр хангахыг хэлнэ. Сургалтын байр, орчин нь анхнаасаа хүртээмжтэй байдлаар тоноглогдон зохион байгуулагдсан бол зөвхөн цөөн тооны нэмэлт өөрчлөлт шаардагдана. Гэсэн хэдий ч, арилгах шаардлагатай саад бэрхшээл нь тухайлсан онцгой хэрэгцээнд хамаатай, эсвэл нийтлэг шинжтэй эсэхээс үл хамааран дор дурдсан асуудлуудыг анхааралдаа авч харгалзан үзэх хэрэгтэй. Ийм байдлаар түгээмэл загварыг нэвтрүүлж, хүртээмжтэй байдлыг хангах явцдаа гарцан дээр хашлагагүй налуу зам барих, орцны хаалгыг өргөн болгох, ариун цэврийн өрөөг хэрэглэхэд илүү дөхөмтэй болгох зэргээр хүрээлэн буй орчинд байгаа зарим саад бэрхшээлийг арилгах боломжтой байдаг.Түүнчлэн суралцагчийн хувьд урьдчилан харж тооцоолоогүй саад бэрхшээл анги танхимд тулгарч болдог. Жишээлбэл өрөөний ширээний өндөр нам, эгнээ хоорондын зай, гэрэлтүүлэг, байршил, ашиглах хэлбэр зэрэг нь тухайн суралцагчийн хувьд бэрхшээлтэй байж болно. Сургалтын материал, сургалтын арга хэлбэртэй холбоотой саад бэрхшээлийг хүн тус бүрийн хэрэгцээ шаардлагад нийцүүлж арилгахыг хичээх хэрэгтэй. Хэрэв хичээлийг үзүүлж харуулах байдлаар явуулах бол харааны бэрхшээлтэй хүмүүст зориулж нэмэлт арга хэмжээ авах шаардлагатай. Ийм хүмүүст том үсгээр бичсэн материал бэлтгэж тараах, тэмдэглэл хийх хэрэгслээр хангах, мөн дүрс бичлэг, зураг зэргийг ашиглахдаа аман тайлбар хийж байх

<sup>19</sup> Т.Ням-Очир, БСШУСЯ, "Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийн хэрэгжилт, тулгамдсан асуудал", 2018.07.03-ны өдрийн онол, практикийн бага хуралд хэлэлцүүлсэн илтгэлээс.

хэрэгтэй юм. Ямар хэрэгсэл, дэмжлэг шаардлагатай байгааг хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй уулзахаасаа өмнө тодорхойлох боломжгүй учраас тухайн хүмүүстэй уулзаж сургалтыг ямар байдлаар явуулж болох, ямар дэмжлэг туслалцаа хэрэгтэй байгаа талаар ярилцсаны дараа шийдвэр гаргах хэрэгтэй.<sup>20</sup>

**Шигтгээ:** Би 2006 оноос 29-р сургуульд багшилж байна. Би хоёр настайдаа сонсголын бэрхшээлтэй болсон. Манай гэрийнхэн намайг мэдээгүй явж байгаад найман нас хүрээд сургуульд ороход л мэдсэн. Жирийн сургуульд явж байгаад дөрвөн жилийн дараа би нэг ч үсэг бичиг чадахгүй байгаагаа гэнэт анзаарсан. Дарханд тусгай сургууль байдаг тухай анх сонсч холбогдон, дараа нь 29-р сургуульд орж суран бүх юмныхаа учрыг нь олсон. Элсэлтийн ерөнхий шалтгалтыг би амжилттай өгөөд, гурван шалгалтын нэгээр нь нийгмийн ухааныг сонгож байсан. Үүний дараа би Боловсролын их сургуульд орох гэтэл чи сонсголгүй байж яаж сурдаг юм бэ гээд аваагүй. Шалгалтаа ном журмаар нь өгөөд, тэнцээд байхад Боловсролын их сургууль нь өөрөө намайг ялгаварлан гадуурхаж, авахгүй гэхэд маш их гомдож байсан. Ээж маань хөөцөлдсөөр байгаад намайг оюутан болгосон. Би бусад оюутнуудтай адил дөрвөн жил сурахдаа нэг ч удаа хэлмэрч, орчуулагчийн туслалцаа авч байгаагүй. Би хүнээс хуулж л хичээлээ хийдэг байсан. Юу ч сонсохгүй учраас их сургуульд ном л надад найз болдог байв. Шөнөжин номоо уншиж хичээлээ хийж, жирийн оюутнуудаас хэд дахин их хөдөлмөр гаргаж сурсан. Манай нийгмийн хандлага ийм л байгаа. Бид сурч, ажиллаж чадна аа. Хүмүүс ээ, энэ хандлагаа өөрчлөөч ээ гэж дахин дахин хэлмээр байна. Энгийн иргэд та нар өөрсдөө нээлттэй нийгэмд амьдардаг мөртлөө хөгжлийн бэрхшээлтэй иргэд биднийг ялгаварлан гадуурхаж хаалттай нийгэм рүү түлхдэг.<sup>21</sup> (Б.Туул ikon.mn-д нийтлэгдсэн ярилцлагын хэсгээс)

Аймаг, суманд тусгай сургууль байхгүй, зөвхөн Улаанбаатар хотын хэмжээнд 6 сургууль байна. Хуулийн 15.7, 15.10-т заасан орон нутгийн төсөвт тусгах тодорхой хувь хэмжээгээр заахгүй бол энэ заалт тэр бүр хэрэгжихгүй байгаа ажээ. 15.6-д зааснаар “Элсэлтийн шалгалтад тэнцэж, дотоод, гадаадын их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсролын байгууллагад суралцах эрхтэй болсон хөгжлийн бэрхшээлтэй хүний бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалтын зардлыг, хөдөлмөрийн чадвараа алдсан гишүүнтэй өрхийн нэг суралцагчийн сургалтын төлбөрийг боловсролын зээлийн сан хариуцна.” гэсэн заалтын дагуу хөдөө орон нутгаас суралцахыг хүсэгчид заавал Улаанбаатар хотод ирэх шаардлагатай болдог. Тиймээс аймаг, дүүргийн боловсролын газраар дамжуулан шийдвэрлэхээр журмыг нарийвчилж оруулах нь хуулийн заалтын зорилгыг хангах, практик хэрэгжилтийг хангахад шууд ач холбогдолтой.

**Дүгнэлт:** Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийн бүлгийн 14.1.3, 14.3.2 дахь заалт, 15.1-15.4, 16.3,16.4 дэх заалтуудын тухайд зорилгодоо бүрэн дүүрэн хүрч чадаагүй, практикт хэрэгжилт хангалтгүй, талуудаас бүрэн хүлээн зөвшөөрөгдөөгүй байна. Эдгээр заалтын хэрэгжилт хангалтгүй байгаа гол шалтгаан нь хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний, санхүүгийн нөөцийн боломж, мөн хэрэгжүүлэх механизм - журам, стандарт батлагдсан байдал, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн багш, албан хаагчдын ойлголт, хандлагатай холбоотой байна.

<sup>20</sup> [https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---asia/---ro-bangkok/---ilo-beijing/documents/publication/wcms\\_370167.pdf](https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---asia/---ro-bangkok/---ilo-beijing/documents/publication/wcms_370167.pdf), 23-24 дахь тал

<sup>21</sup> <https://ikon.mn/opinion/1613>

### 3.3 Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлт

<b>Хөгжлийн бэрхшээлтэй хүний статистик: хөдөлмөр эрхлэлтийн хувь</b>	
<p>Үндэсний статистикийн 2017 оны судалгаагаар Монгол улсад нийт 100,993 хөгжлийн бэрхшээлтэй иргэн (55,758 эрэгтэй, 45,235 эмэгтэй) буюу нийт хүн амын 3,24%-ийг эзэлж байна. Улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 15, түүнээс дээш насны 98,841 хөгжлийн бэрхшээлтэй хүн байгаагийн 24,875 нь эдийн засгийн үйл ажиллагаанд нэгээс дээш цагаар оролцсон буюу ажил эрхэлдэг иргэн, 75,296 хөгжлийн бэрхшээлтэй, эдийн засгийн идэвхгүй хүн ам буюу ажил эрхэлдэггүй иргэн байна.(Европын Ардчиллын Холбоо, Тэгш нийгэм ТББ-ын "Монгол Улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эдийн засгийн эрхийг үнэлэх" төслийн тайлан, 2018 он, 11 дэх тал)</p>	<p>Монгол Улсад 2017 оны байдлаар 103,6 мянга буюу нийт хүн амын 3.3 орчим хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна. Хөгжлийн бэрхшээлтэй, хөдөлмөр насны 19974 хүн хөдөлмөр эрхэлж байна. Харин хөдөлмөр эрхэлж буй тэтгэврийн насны хүн 3018 байгаа юм. Хөдөлмөр эрхэлдэггүй хөгжлийн бэрхшээлтэй хүн 73285 байна.(Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал:бодлого, үйл ажиллагаа, 2017 он, 9, 24 дэх тал)</p>

Хөгжлийн бэрхшээлтэй холбоотой тоо мэдээллийн зөрүүтэй байдал хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн хүрээнд илэрч байгааг дээрхи харилцан адилгүй тоо, баримтаас харагдана. Улмаар энэхүү мэдээллийн сангийн зөрүүтэй байдал Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн хэрэгжилтийг үнэлэхэд ч тулгамдсан асуудал болж дурдагдана.

#### **17 дугаар зүйл. Хөдөлмөрлөх эрх**

17.3.Төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээд нь хөгжлийн бэрхшээлтэй хүний бие эрхтэн, хөгжлийн онцлогт нийцсэн ажлын байрыг Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу бий болгож ажиллуулах үүрэгтэй.

#### **18 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг төрөөс дэмжих**

18.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтэд төрөөс дараахь дэмжлэг үзүүлнэ:18.1.1.хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулж байгаа иргэн, хуулийн этгээдийг хууль тогтоомжийн дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах, тохирох хэрэглэгдэхүүн бүхий ажлын байр бий болгохыг урамшуулах;18.1.2.хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөрлөх чадварт тохирох хэрэглэгдэхүүн бүхий ажлын байр бий болгох, тэдгээрийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, төсвийн хөрөнгөөр хийх худалдан авалтад тэргүүн ээлжинд хамруулах;18.1.3.хөгжлийн бэрхшээлтэй хүн мэргэжлээрээ ажиллахад шаардагдах ажлын багаж, тоног төхөөрөмж,

материал болон бусад шаардлагатай хэрэгслийг худалдан авахад нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас нэг удаа санхүүгийн дэмжлэг үзүүлэх;18.1.4.хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дунд мэргэжлийн ур чадварын тэмцээн зохион байгуулахад төрөөс дэмжлэг үзүүлэх;18.1.5.мэргэжлийн ур чадварын олон улсын тэмцээнд амжилттай оролцсон хөгжлийн бэрхшээлтэй хүнд урамшуулал олгох ба урамшуулал олгох журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлах;18.1.6.хөгжлийн бэрхшээлтэй хүнд мэргэжлийн чиг баримжаа, ур чадвар олгох чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа сургалтын байгууллагад төрөөс дэмжлэг үзүүлэх.

"Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль тогтоомжийн хэрэгжилт"-ийн шалгалтыг үндэсний хэмжээнд МХЕГ-аас 2017 оны нэгдүгээр сарын 25-наас 2017 оны 10 дугаар сарын 01-ний хооронд хийсэн байна. Уг шалгалтын үр дүнг танилцуулсанаар төрийн болон төсвийн байгууллагын дөнгөж 30 гаруй хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг зохих орон тоонд ажиллуулж байна. Боловсрол, эрүүл мэндийн салбарын байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажилд авдаггүй мөртлөө, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд ч мөнгө төлдөггүй. Яагаад эдгээр иргэдийг авч ажиллуулдаггүй шалтгаанаа өндөр дээд мэргэжилтэй хүмүүсийг авч ажиллуулдаг, төсөвт мөнгө тусгагдаагүй учир хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд мөнгө төвлөрүүлдэггүй гэдэг. Энэ бол шалтаг, хууль Засгийн газрын тогтоолоор тодорхой зохицуулсан харилцаа юм. Байгууллагууд нийт ажилчдынхаа 0.4-өөс доошгүй хувьд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ажиллуулах ёстой. Ингэж ажиллуулаагүй нөхцөлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд мөнгө төвлөрүүлэх ёстой. Тодруулбал, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 40.3-д "Төрийн захиргааны төв байгууллагууд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлж байгаа бодлого арга хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн харилцаанд тэгш оролцох боломжийг бүрдүүлэх асуудлыг тусгаж, хэрэгжүүлнэ" гэж заасан байдаг. Үүний дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийн санд төвлөрүүлсэн хөрөнгийг тэдний бие эрхтэн, хөгжлийн онцлогт нийцсэн тогтвортой орлого бүхий байнгын ажлын байрыг шинээр бий болгоход зарцуулах учиртай гэж дүгнэжээ.<sup>22</sup> МХЕГ-аас үндэсний хэмжээнд 2017 онд зохион байгуулса "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль тогтоомжийн хэрэгжилт"-ийн шалгалтад нийт 1,281 аж ахуйн нэгж хамрагдсанаас 131 аж ахуйн нэгж, байгууллага нь ажлын байрны төлбөрийг хуулийн дагуу төлж, 794 аж ахуйн нэгж байгууллага 1,908 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг зохих орон тоонд ажиллуулж байна.<sup>23</sup>

2017 оны байдлаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 4.2 тэрбум төгрөг төвлөрсөн бөгөөд 3.2 тэрбумыг зарцуулж, 1461 ажлын байр бий болгож, хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээнд 672 иргэнийг хамруулж, 44.3 сая төгрөг зарцуулсан, дэмжлэгтэйгээр ажилд зуучлах арга хэмжээнд 171 иргэн хамрагдаж, 62 иргэн ажлын байраар хангагдаж, 7 сая төгрөг зарцуулсан, хөдөлмөр эрхлэлтийн сургалтанд 584 иргэн хамрагдаж 104 иргэн ажлын байраар хангагдаж 144.6 сая төгрөг зарцуулжээ. Аж ахуй эрхлэлтийн сургалтанд 2729 иргэн хамрагдаж 57.6 сая төгрөгийг зарцуулсан бол борлуулалтын болон ажлын байрны түрээсийн төлбөрийн дэмжлэгт 515 иргэн хамрагдаж, 93.9 сая төгрөг, ажил олгогчийг дэмжих арга хэмжээнд 213 иргэн хамрагдаж, 759.3 сая төгрөгийг, эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 898 иргэн хамрагдаж, 1082 иргэн ажлын байраар хангагдаж

<sup>22</sup> <https://ikon.mn/n/17mn>

<sup>23</sup> МХЕГ-ын 2018.07.16-ны өдрийн 05/2426 тоот албан бичиг

2.1 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгээс 69.5 сая төгрөг эргэн төлөгдсөн байна. Харин 2018 оны эхний 5 сарын байдлаар 670 иргэнд, 549.3 сая төгрөг зарцуулж, 206 ажлын байр бий болгосон байна. Аж ахуй эрхлэлтийн сургалтанд 440 иргэн хамрагдаж, 11.9 сая төгрөгийг, борлуулалтын болон ажлын байрны түрээсийн төлбөрийн дэмжлэгт 16 иргэн хамрагдаж, 6.7 сая төгрөгийг, ажил олгогчийг дэмжих арга хэмжээнд 3 иргэн, 3 ажил олгогч хамрагдаж, 8.6 сая төгрөгийг, эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 188 иргэн хамрагдаж, 203 иргэнийг ажлын байраар хангаж, 520.6 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгээс 3.3 сая төгрөг эргэн төлөгдсөн байна.<sup>24</sup>

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар дээрхээс илүү дэлгэрэнгүй мэдээлэл байхгүй байна. Жишээ нь: ХБИ-ийн үйлдэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээ, түүний борлуулалт, тухайн жилд тохируулгатай ажлын байр бий болгосон байгууллагын тоо, зөвлөлдөх уулзалтын тоо, ХБ-тэй ахмадуудын үзүүлсэн үйлчилгээ г.м.<sup>25</sup>

2017 онд МХЕГ-ын улсын байцаагчийн 149 акт үйлдэж, 734 сая төгрөгийн нөхөн төлбөр тавьсанаас 119 байгууллагад 587 сая төгрөгийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн санд төвлөрүүлсэн байна. Мөн 131 аж ахуйн нэгж, байгууллагад 33.5 сая төгрөгийн захиргааны хариуцлага ногдуулж, 100 гаруй аж ахуйн нэгж байгууллагад 6 заалт бүхий улсын ахлах байцаагчийн зөвлөмжийг хүргүүлсэн байна.<sup>26</sup>

Хөдөлмөр эрхлэлтийн санд 2017 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулаагүй ажлын байранд төлөх төлбөрт 1.0 тэрбум төсөвт төвлөрүүлсэн байгаа бол, 2018 оны эхний 5 сарын байдлаар нийтдээ 497.0 сая төгрөг төвлөрчээ.<sup>27</sup> Энэхүү заалтын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэн хөдөлмөр эрхлэхэд үр дүн гарах байдал төдийлөн хангалттай бус байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрт төвлөрдөг хөрөнгө нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт зарцуулж байгаа хөрөнгийн 25-30 орчим хувийг эзэлж байна. Энэ нь хууль тогтоомжийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан ажлын байрны шинээр бий болгох, ажил олгогчдыг дэмжих арга хэмжээнд зарцуулагдаж байгаа болно. 2014 онд Хөдөлмөрийн биржүүд, хөдөлмөрийн хэлтсүүдээр зуучлагдаад 340 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажлын байртай болсон байдаг. Гурван жилийн дараа буюу Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль батлагдсаны дараа 2017 онд (2016 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай хууль батлагдаж хэрэгжсэн) хэр ахиц дэвшил, өөрчлөлт байгааг зарим статистик тоон мэдээлэл болон 400 хүнээс асуулгын аргаар авсан судалгаанаас харж болох юм.<sup>28</sup>

**Хөдөлмөрийн зах зээлийн гол үзүүлэлтүүд: нийт хүн ам болон ХБИ**

<sup>24</sup> ХХҮЕГ, Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Б.Мандхай, "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын өнөөгийн байдал, тулгамдсан асуудал", онол практикийн бага хуралд хэлэлцүүлсэн илтгэлээс, 2018.07.03

<sup>25</sup> Европын Ардчиллын Холбоо, Тэгш нийгэм ТББ-ын "Монгол Улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эдийн засгийн эрхийг үнэлэх" төслийн тайлан, 2018 он, 16 дахь тал

<sup>26</sup> ХНХЯ, Жайка ОУХАБ, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: бодлого, үйл ажиллагаа, 2017 он, 24 дэх тал

<sup>27</sup> ХХҮЕГ, Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Б.Мандхай, "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын өнөөгийн байдал, тулгамдсан асуудал", онол практикийн бага хуралд хэлэлцүүлсэн илтгэлээс, 2018.07.03

<sup>28</sup> Европын Ардчиллын Холбоо, Тэгш нийгэм ТББ-ын "Монгол Улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эдийн засгийн эрхийг үнэлэх" төслийн тайлан, 2018 он, 11 дэх тал


Эх

Шалгуур үзүүлэлтүүд	Нийт хүн ам		хби		тайлбар
	тоо	Хувь	тоо	Хувь	
		(%)		(%)	
Нийт хүн ам	3,119,935		100,993	3.24%	
15 ба түүнээс дээш настай хүн	2,107,016	67.53%	98,841	93.90%	
Эдийн засгийн идэвхитэй хүн (= ажиллах хүч)	1,275,650	60.54%	24,875	25.20%	<i>Хөдөлмөр эрхэлж буй + хөдөлмөр эрхлээгүй</i>
					15 ба түүнээс дээш настай хүмүүсээс
Хөдөлмөр эрхэлж буй	1,147,843	89.98%	23,545	94.70%	Эдийн засгийн идэвхитэй хүмүүсээс (= ажиллах хүч)
Хөдөлмөр эрхлээгүй (ажил идэвхитэй хайж байгаа)	127,807	10.02%	1,330	5.30%	Эдийн засгийн идэвхигүй хүмүүсээс (= ажиллах хүч)
Эдийн засгийн идэвхигүй хүн	831,366	39.46%	62,515	70.30%	Эдийн засгийн идэвхигүй хүмүүсээс (= ажиллах хүчид багтаагүй):нийт хүн амаас
Хөдөлмөр эрхэлдэггүй хүн ам	830,814	42.80%	75,296	76.20%	Хөдөлмөр эрхлээгүй+ Эдийн засгийн идэвхигүй хүмүүс: 15 ба түүнээс дээш настай хүмүүсээс

үүсвэр: Үндэсний статистикийн газрын мэдээлэл



## ХБИ-ийн ажилд орж чадахгүй байгаа шалтгаан<sup>29</sup>



Судалгаанд оролцсон хүмүүс хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажилд орж чадахгүй байгаагийн гол шалтгааныг тэдэнд тохирох ажлын байр олддоггүй, ажил олгогчийн ойлголт, хандлага муу байгаа, ХБИ-ийг хөдөлмөр эрхлэхэд бэлтгэхгүй учир тэдний дасан зохицох чадвар сул байгаа, ХБИ-ийн талаар нийгэмд сөрөг ойлголт түгээмэл байдаг, хөдөлмөр эрхлэх чадваргүй гэж үзсэн байна. Судалгаанд оролцсон 400 хүмүүсийг хөдөлмөр эрхэлдэг эсэхийг тодруулахад 56% нь эрхэлдэг, 44% нь эрхэлдэггүй байна. Ажил эрхэлж буй иргэдийн 43% нь 5 ба түүнээс дээш жил ажиллаж байгаа нь ХБИ ажлын байранд тогтвор суурьшилтай, хариуцлагатай ажилладгийг харуулж байна. Харин хөдөлмөр эрхлэхгүй байгаа, ажлаас гарсан ХБИ-ийн 54% нь эрүүл мэндийн байдлаас, 17% нь ажлын байр тохиромжтой байгаагүй, дэд бүтэц шийдэгдээгүй болон ажлын хамт олонтойгоо таатай харилцаа үүсгэж чадаагүй, хэт ачаалал гэсэн шалтгаанаас ажлаас гарсан гэж хариулсан байна. ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийн байдал хангалтгүй, тааруухан болохыг статистик мэдээлэл болон энэхүү судалгааны дүн харуулж байна.

Энэхүү судалгаанд оролцогчдын анкетын болон ярилцлагын протоколоос тэдний хөдөлмөрлөх эрх, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замтай холбоотой өнөөгийн нөхцөл байдал, мэдээлэл, саналуудыг багцалж үзлээ<sup>30</sup>. Үүнд:

### 3.3.1. Хууль тогтоомжтой холбоотой асуудал

ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилт тун тааруу байгааг юуны санал нэгтгэйгээр илэрхийлсэн байна. Монгол Улсын хөдөлмөрийн тухай хуулийн 111-р заалт нь хотод хэрэгжих боломжтой байдаг гэхэд хөдөө орон нутагт 25-аас дээш албан

<sup>29</sup> Европын Ардчиллын Холбоо, Тэгш нийгэм ТББ-ын "Монгол Улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эдийн засгийн эрхийг үнэлэх" төслийн тайлан, 2018 он, 14 дэх тал

<sup>30</sup> Европын Ардчиллын Холбоо, Тэгш нийгэм ТББ-ын "Монгол Улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эдийн засгийн эрхийг үнэлэх" төслийн тайлан, 2018 он, 22-26 дахь тал

хаагчтай байгууллагууд цөөн байдаг учир ХБИ орон нутагт ажилд орох боломж байдаггүй. Тиймээс дээрх квотыг хот суурин болон хөдөө орон нутагт ялгаатай тогтоох хэрэгцээг илэрхийлж байна. Мөн ажил олгогчид ХБИ-ийг ажилд авчихаад 7 хоногт 35-аас доошгүй цагаар ажиллуулж, ээлжийн амралтыг 20 хоног байлгах сонирхол эдийн засгийн үүднээс байдаггүй. Тиймээс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд мөнгө төлөх нь тэдэнд хялбар санагдаж байж болох талтай. Тиймээс энэ асуудлыг үр дүнтэй шийдэхийн тулд байж болох нэг хувилбар нь ажил олгогчийн төлөх мөнгөн төлбөрийг илүү өндөр тогтоож болох юм. Ер нь Хөдөлмөрийн хуулинд хатуу тогтоосон дээрхи заалтыг дахин судлах шаардлагатай. Хуулиар тодорхой сонгох орон зайг зааж, харин тэр хүрээнд хөдөлмөрийн болон хамтын гэрээгээр тохиролцон уян хатан байхаар зохицуулах нь энэ харилцаанд оролцогчдод аль алинд нь давуу тал олгох боломжтой гэж үзэж байна. Иймэрхүү хатуу тодорхойлсон хуулийн заалт нь ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж байгаа харагдавч үнэндээ ажил олгогчдыг үргээх шалтгаан болдог байна. Нөгөө талаар ХБИ-т зориулсан ажлын байр бий болгох гэдэг ойлголтыг өөрчилж илүү чөлөөтэй, уян хатан болгох хэрэгцээ, шаардлага байна. Жишээ нь: тохируулгатай ажлын байр бий болгосон, түрээсийн хөнгөлөлт үзүүлсэн, ХБИ-ийн хийсэн, үйлдвэрлэсэн зүйлсийг борлуулалтын сүлжээнд хамруулсан байвал, гэрээрээ юм хийдэг хүмүүсээр гэрээт ажил гүйцэтгүүлсэн бол квотыг хангасан гэж тооцох зэрэг өөрчлөлтийг хуулинд хийж өгөх нь ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдлыг дээшлүүлэх болно гэж үзэж байна.

ХЭДС-ийн хөрөнгийн зарцуулалтанд тавих хяналт сул байдаг ба ХБИ-д өгдөг зээлийг буцаан төлөх нөхцөл тавихгүй байх талаар судалгаанд оролцсон ХБИ хүсэлтээ ихэнхи хувь нь илэрхийлсэн байна. МХЕГ-аас 2017 онд хийсэн шалгалтын үр дүнд үндэслэн Сангийн яаманд хандаж "Төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2009 оны 26 дугаар тогтоолын 2-т заасны дагуу "Бүх шатны төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг тогтоосон хувь хэмжээгээр ажиллуулах, ажиллуулагүй тохиолдолд зохих төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг төсвийн ерөнхий менежер нарт үүрэг болгосугай" гэдэг заалтын хэрэгжилтийг хангаж төсвийн болон төрийн байгууллагуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрны төлбөрийг төсөвт тусгахыг авч хэрэгжүүлэх, эсхүл төсвийн бүх байгууллагуудын судалга гаргаж Сангийн яамнаас нэгдсэн журмаар зохих төлбөрийг улсын төсөвт төвөрүүлж ХНХЯ-аас нэгдсэн журмаар зарцуулдаг байхыг зөвлөмж болгожээ.

### **3.3.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой асуудал**

Хуулинд дээрхи байдлаар нэмэлт өөрчлөлт оруулья гэж бодоход дараагийн шатанд ХБИ-ийг ажилд ороход бэлтгэдэг тогтолцоог бий болгох хэрэгтэй байна. Үүний тулд:

1. Тэднийг хөдөлмөрт бэлтгэх ажилд зуучлах төвийг тусад нь байгуулан ажиллуулах
2. Тухайн орон нутаг, зах зээлд шаардлагатай мэргэжил, өөрийн нь хийж чадах ажлын чиглэлээр мэргэшүүлэх сургалт, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн чиглэлээр сургах,
3. Хөдөлмөр эрхэлж буй хүмүүс нь ажил үүргээ хариуцлагатай гүйцэтгэж ажил олгогчид итгэл төрүүлэх,

4. Өөрийгөө ажил олгогчид танилцуулж, өөрийн мэдлэг чадвараа харуулж ойлгуулж чаддаг, хуулинд заасан эрхээ мэдэж, эдэлж сурах зэргээр ХБИ-ийг чадавхижуулах,,
5. ХБИ-ийн хийсэн үйлдвэрлэсэн зүйлсээр үзэсгэлэн худалдаа зохион байгуулах замаар сайн туршлагуудаа солилцох тал дээр ТББ-ууд санаачлагатай ажиллах,
6. ХБИ хөдөлмөрөө хоршин, хоршоо, нөхөрлөл байгуулж хамтарч ажиллах,
7. ХБ-тэй ахмад настнуудын мэдлэг чадварыг зөвлөх үйлчилгээ маягаар ажиллуулах.

**Шигтгээ:** 2017 онд хөдөлмөр эрхлэлтийн дадлага олгох сургалтанд 388 ХБИ хамрагдсан. Тохируулгатай ажлын байр 159 байна.

### 3.3.3. Ажил олгогчтой холбоотой асуудал

ХБИ-ийг хөдөлмөрлөх эрхээ эдлэхэд ажил олгогчийн талаар анхаарах асуудлыг юуны түрүүн орон нутагт ажил олгогчид ХБИ-ээр хөдөлмөр эрхлүүлэх талаар эрх зүйн ойлголт, мэдлэг байхгүйн зэрэгцээ тэдний талаар бүр хуучинсаг ойлголттой, мөн эрхээ эдлэхэд нь ялгавартай ханддаг байдал хэвээр байгаа талаар ярьж байна. 2017 онд 123 ажилтны дунд хийсэн судалгаагаар Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн тухай зохицуулалтын талаархи мэдлэгийг асуухад ердөө 8 хүн нь мэдлэгтэй, харин 115 хүн огт ойлголтгүй байв. Улмаар эдгээр 123 хүний 19 нь хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар зөв ойлголттой, 39 хүн нь огт ойлголтгүй байжээ.<sup>31</sup> Хэлгүй, дүлий иргэд сургуульд сурах, ажил хийх болоход дохионы хэл мэдэх хүн байхгүй, харааны бэрхшээлтэй хүн сурч хөдөлмөрлөхөд зориулсан барриал ном, зориулалтын зам байхгүй гээд орон нутгийн нөхцөл хүнд байна.

**Шигтгээ:** Судалгаанд оролцогчдын 44% нь хөдөлмөр эрхэлдэг, 56% нь хөдөлмөр эрхэлдэггүй байсан ба хөдөлмөр эрхэлдэг хүмүүсийг хаана ажилладаг вэ? Гэж асуухад 34% нь хувиараа, 27% нь хуулийн дагуу, төрийн байгууллагад, 15% нь ТББ-д цалинтай, 7% нь ТББ-д цалингүй, 11% нь өрхийн бизнестээ, цалингүй тусалдаг байна.

Мөн ажил олгогчид ХБИ-ийг ялгаварлан гадуурхах, дарамтлах үзэгдэл түгээмэл байдгийг хэлжээ.

**Шигтгээ:** Судалгаанд оролцогчдоос ажлын байранд ялгаварлан гадуурхалтанд хэр өртдөг вэ? Гэж асуухад 36% нь хааяа мэдэрдэг гэсэн бол 11% нь байнга, 12% нь хариулахад хүнд гэж хариулсан бол 41% нь л үгүй гэжээ.

### 3.3.4. Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагатай холбоотой асуудал

ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтэнд Засгийн газрын тогтворгүй байдал болон орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудын ажилтан албан хаагчдын богино хугацаанд өөрчлөгдөх байдал сөрөг нөлөө үзүүлдэг. Энэ тохиолдолд үйлчлүүлэгчид өөрчлөгддөг, шинэ албан хаагчдад бүх зүйлийг тайлбарлаж ойлгуулах гэж хугацаа, хүчин зүтгэл

<sup>31</sup> Т.Ганцэцэг, П.Энх-Учрал, Х.Балжмаа, А.Баярмаа, Д.Дэнсмаа, З.Хишигсүрэн, "Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хандах хандлага ба ажлын байр", Хөгжлийн бэрхшээл судлал нь салбар дундын шинжлэх ухаан болох нь сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, 2017 он, 26-27 дахь тал

шаарддаг, өмнө төлөвлөсөн ажил, гаргахаар төлөвлөсөн шийдвэр хойшлох зэргээр цаг хугацаа алдаж, хөдөлмөр, чармайлтыг үрэгдүүлдэг. Аймаг, дүүргийн хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт ХБИ-ийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь тэдний төлөөлөл байж, орон нутагт баригдаж байгаа барилгын стандартанд шаардлага тавих гэх мэтээр ХБИ-ийн эрх ашгийг хамгаалах ТББ-уудтай хамтраад ч ажилладаг, санаачлагатай, сэтгэлтэй, мэдлэгтэй, шаардлагатай хүн байх хэрэгтэй байна. Гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг байгууллагаас ХБ-тэй залуучуудад амьдрах арга ухааныг зааж, сургаж хөдөлмөрт бэлтгэхэд илүү анхаармаар, ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн журам дүрмийг шинэчилж өөрчлөхөд санаачлага гаргах шаардлагатай байна. Жишээ нь: Үйлдвэрлэл эрхлэхэд зээл өгөөд байгаа хэрнээ үйлчилгээ эрхлэхэд зээл өгдөггүй байдлыг өөрчлөх, тогтвортой хөдөлмөр эрхэлж буй хүмүүсийн түрээсийн төлбөрт нь хөнгөлөлт үзүүлэх, тоног төхөөрөмжийн зээл өгдөг болох г.м. Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэргэжилтнүүд ХБИ-дэд мэдээлэл өгдөггүй, хүйтэн хөндий сэтгэлээр ханддаг. Цаашид хөдөлмөрийн улсын байцаагчаас эхлээд гүйцэтгэх засаглалын түвшинд ХБИ-ийн асуудал хариуцсан орон тоон дээр ХБХ ажиллуулах нь онвчтой гэж үзжээ.

**Шуигтгээ:** ХБИ-ээс таныг ажил эрхэлж байхад ямар бэрхшээл илүү тулгардаг вэ? гэж асуухад тэдний 26% нь ажлын байр хүртээмжгүй, үргэлж хүний туслалцаа шаардлагатай байдаг, 22% нь бусад ажилтнуудын харилцаа хандлага хөндий, 20% нь мэдлэг дутмаг байсан гэж тус тус хариулжээ.

### 3.3.5. ТББ-ын үйл ажиллагаатай холбоотой асуудал

ХБИ-ийн эрх ашгийг хамгаалах ТББ-уудын үйл ажиллагаа харилцан адилгүй түвшинд байгаа аж. Тиймээс ХБИ-ийн үүсгэн байгуулсан, тэдний эрхийг хамгаалах чиглэлийн ТББ-ыг чадавхижуулах асуудал өнөөгийн бас нэг тулгамдсан асуудал болжээ. ТББ-ууд чадавхитай болохыг баталгаажуулж чадвал төрийн байгууллагаас ХБИ-д үзүүлэх зарим үйлчилгээ, үйл ажиллагааг гэрээтээр хүргэх боломжтой. Нөгөө талаар ТББ-ууд хоорондын уялдаа холбоо, хамтын үйл ажиллагааг хөгжүүлэхгүйгээр үйл ажиллагааны далайц, үр дүн муутай байдаг. ХБИ, тэдний эрх ашгийг хамгаалах ТББ-ууд аль алиных нь үйл ажиллагаанд багаар ажиллах сэтгэлгээ, хамтын үйл ажиллагаа чухал байгааг ярилцлагын үеэр олон хүн хэлж байлаа.

**Шуигтгээ:** ХБИ-ийн эрх ашгийг хамгаалах, албан ёсны бүртгэлтэй ТББ-ууд 304 орчим байдгаас 80 нь тогтмол үйл ажиллагаа явуулдаг.<sup>32</sup>

### 3.3.6. ХБИ-ийн асран хамгаалагчдын хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуудал

ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг ярихад тэднийг асран хамгаалагчдын ажил эрхлэлтийг зайлшгүй авч үзэхээс өөр аргагүй. ХБИ-д зээл өгдөг хэрнээ асран хамгаалагчдад зээл өгдөггүй, гэтэл асаргааны мөнгө бага учир хөдөлмөр эрхлэх хэрэгцээ байнга байдаг. Мөн асран хамгаалагчдын ажиллах боломжийг харгалзан дахин мэргэшүүлэх шаардлага гарахыг үгүйсгэхгүй байна.

<sup>32</sup> НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцийн хэрэгжилтийн талаархи Монгол Улсын үндэсний тавдугаар тайлан илтгэл, 2014.10.20

**Шигтгээ:** 2017 оны байдлаар 21 000 орчим хүн ХБИ-ийг асран хамгаалж байна. Сарын асаргааны тэтгэмж 64 000 төгрөг байдаг.

**Шигтгээ:** Иргэн Д 18 настай, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй. Төрсний дараа 6 сар болоод ажилдаа орсон. Энэ цагаас хүүхэд асрагч авч гэрээр ажиллуулж байгаад хүүхдээ 2 наснаас нь цэцэрлэг, сургуулиар явуулсаар 12 нас хүргэсэн. Хүүхэд нь энгийн сургуульд явах боломжгүй учраас мөн гэрээр асрагч ажиллуулсаар өдий хүрсэн. Тэр ярихдаа “ХБХ-тэй хүн ажил эрхлэхгүйгээр, зөвхөн асаргааны мөнгөөр хүүхдээ асарч, сувилна гэж байхгүй. Тиймээс би анхнаасаа ажлаа яагаад ч орхиж болохгүй гэж бодсон. Ажлаасаа холдвол би өөрөөр оюуны хоцрогдолд орох гэж байгаа юм шиг санагддаг байлаа. Манай ажлын хамт олон намайг ХБ-тэй хүүхэдтэй гэж бараг мэддэггүй учраас элдэв дарамт, буруу ойлголцол гардаггүй юм. Хүүхэд асрагчид сарын цалингийнхаа дөрөвний нэгийг зориулдаг .” гэж ярилаа.

ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийн нийгэм эдийн засгийн орчны талаар авч үзэхэд ажил хайгаад гадагш гарах, байгууллагуудаар явж уулзах болоход дэд бүтэц, муу, орчин хэцүү, ялангуяа орон нутагт хүртээмжтэй орчин маш тааруу байдаг. Эдийн засгийн талаас бол зах зээл муу хөгжсөн байдгаас хийсэн зүйлээ борлуулах суваг, арга хаалттай. Тэр ч бүү хэл ХБИ-ийг дорд үзэх, ялгаварлах хандлага орон нутагт хэвээр байгааг сануулж байна. Амьдралын баталгаажих түвшнээс доогуур орлоготой хүнд зээл олгоно гээд байгаа мөртлөө барьцаа хөрөнгө шаарддаг зэрэг хуулиудын хувьд зөрөөтэй ойлголтууд байна. Ялангуяа орон нутагт хүмүүст бага багаар зээл өгч байхаар бүгдийг төвлөрүүлэн, бэлэн ажлын байр бий болгож түүндээ ХБИ-ийг ажиллуулах нь илүү үр дүнтэй болно гэдэг саналыг судалгаанд оролцогчид илэрхийлжээ.. Энэ саналыг төвлөрсөн төлөвлөгөөт үеийн зохион байгуулалтыг хүсэж, хуучнаа санагалзаж байна гэж үзэх талтай ч ХБИ-ийн хувьд бүс нутгуудад өөр өөр чиглэлийн үйлдвэрлэл үйлчилгээг бий болгоод хооронд нь сүлжээнд оруулчихвал үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ солилцоод, борлуулалт ба менежмент талаас хамтран зохион байгуулахад хялбар, үр дүнтэй, үр ашигтай байх магадлалтай.. Мөн Засгийн газрын зүгээс дорвитой ажил болгох бас нэг санал гэвэл хувийн хэвшлийн томоохон компаниудтай хэлэлцээр хийж, тэдний боломжит зарим дамжлага, цехийн үйл ажиллагааг ХБИ-ээр гүйцэтгүүлж, тэдгээр компаниудын нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх, хамтрах боломж байж болох юм.

**Дүгнэлт:** Европын ардчиллын төлөөх түншлэл, Тэгш нийгэм ТББ-ын "Монгол Улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эдийн засгийн эрхийг үнэлэх" хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн талаархи бодлогын баримт бичиг, хууль, эрх зүйн актанд дүн шинжилгээ хийж, тэдгээрийн хэрэгжилтэнд үнэлгээ хийж, тоо статистик мэдээлэл, 400 хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс үндэсний хэмжээнд анкетын, оролцогч талуудын фокус бүлгийн ярилцлагын аргаар цуглуулан тайланг 2018 оны 03 сард хэвлэн гаргасан тул энэхүү шинэ судалгааны эх сурвалжийг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой хэсэгт шууд ишлэсэн болно. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 17.1, 18 дугаар зүйлийн хэрэгжилтийг бүрэн хангалттай гэж үзэх боломжгүй байх бөгөөд цаашид хуулийн зохицуулалтын зорилгод хүрэхийн тулд холбогдох салбарын бусад хууль тухайлбал, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн уялдаа холбоон дунд хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн нэмэгдүүлэх, эдийн засгийн байдлыг дээшлүүлэх арга хэмжээ

авах шаардлагатай байна. Энэ талаар өмнөх судалгааны хийсэн дүгнэлттэй санал нийлж байна. Үүнд:<sup>33</sup>

ХБИ-ийн талаарх статистик мэдээлэл болон асуулгын болон ярилцлагын аргаар гарч ирсэн мэдээлэлд дүн шинжилгээ хийж үзэхэд дараахь дүгнэлтийг хийж болно. Үүнд:

1. ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийн талаар ХЭДС-нд төвлөрсөн нийт хөрөнгийн хэмжээ, үүнээс ХБИ-ийн ажлын байр бий болгоход зарцуулсан хөрөнгө, ажилд зуучилсан тоо, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрт хамрагдсан болон дадлага олгох сургалтанд хамрагдсан ХБИ-ийн тооноос илүү дэлгэрэнгүй мэдээлэлийн бааз, статистик, судалгаа байхгүй байна. ХБИ-ийн талаар гардаг статистик мэдээлэл дутагдалтай, маш цөөн төрөл төдийгүй шаардлагатай мэдээллийг хаана, ямар байгууллага гаргах нь тодорхойгүй. Цаашид холбогдох статистик үзүүлэлтийг дэлгэрэнгүй гаргах, хариуцах эзэнтэй байх шаардлагатай байна. Тухайлбал, ХБИ-ийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээ, түүний борлуулалт, тухайн жилд тохируулгатай ажлын байр бий болгосон байгууллагын тоо, ХБ-тэй ахмадуудын үзүүлсэн үйлчилгээ зэрэг мэдээлэл тодорхойгүй байна.
2. Судалгаанд оролцсон 400 ХБИ-ийн боловсролын байдлаас харахад 30% нь бүрэн дунд, 23% нь дээд, 21% нь бүрэн бус дунд боловсролтой байхад мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвөөр ердөө 8% нь мэргэжил эзэмшсэн байна. Хөдөлмөрийн биржийн дадлага олгох сургалтанд 388 хүн 2017 оны байдлаар хамрагдсан боловч тогооч, эсгий тавчик урлах, гоёлын зүүлт сувсаар хэлхэх г.м чиглэлээр чадамжийн гэрчилгээтэй болоод ч ажлын байр, зах зээлийн багтаамж муу, байдаггүй ажээ. Мөн хөдөө орон нутагт нэг ХБИ бүх төрлийн ажлын дадлага олгох сургалтанд хамрагдах, үр дүнд нь хөдөлмөр эрхэлж чадахгүй хэвээр үлдэх тохиолдол түгээмэл байна. Тэгэхээр ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх нэг чухал арга зам нь хөдөлмөрийн зах зээлийн судалгаанд үндэслэн, шаардлагатай, хэрэгцээтэй чиглэлээр мэргэжлийн боловсрол эзэмших боломжийг дэмжих үйл ажиллагаа болох нь харагдана. Хөдөлмөрийн зах зээлд нэн шаардлагатай мэргэжлийн чиглэлээр ХБИ-ийг бэлтгэх, ажилд орох болоход дадлагажуулах, давтан сургах тогтолцоог бүрдүүлэх, үйл ажиллагааг энэ чиглэлийн ТББ-ууд өөрсдөө эрхлэх боломжийг бас судлах нь шийдлийн нэг хувилбар байх боломжтой.
3. Судалгаанд оролцсон 400 хүмүүсийг хөдөлмөр эрхэлдэг эсэхийг тодруулахад 56% нь эрхэлдэг, 44% нь эрхэлдэггүй байна. Ажил эрхэлж буй иргэдийн 43% нь 5 ба түүнээс дээш жил ажиллаж байгаа нь ХБИ ажлын байранд тогтвор суурьшилтай, хариуцлагатай ажилладгийг харуулж байна. Харин хөдөлмөр эрхлэхгүй байгаа, ажлаас гарсан ХБИ-ийн 54% нь эрүүл мэндийн байдлаас, 17% нь ажлын байр тохиромжтой байгаагүй, дэд бүтэц шийдэгдээгүй болон ажлын хамт олонтойгоо таатай харилцаа үүсгэж чадаагүй, хэт ачаалал гэсэн шалтгаанаас ажлаас гарсан гэж хариулсан байна. ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийн байдал хангалтгүй, тааруухан болохыг статистик мэдээлэл болон энэхүү судалгааны дүн харуулж байна.
4. Монгол Улс хүний эрхийг хамгаалах, хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах, хөдөлмөрлөх эрхийг дэмжих чиглэлээр Хүний эрхийн түгээмэл

<sup>33</sup> Европын Ардчиллын Холбоо, Тэгш нийгэм ТББ-ын "Монгол Улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эдийн засгийн эрхийг үнэлэх" төслийн тайлан, 2018 он, 76-80 дахь тал

тунхаглал, I ба II дугаар пакт, Алагчилахгүй байх /ажил, мэргэжил, хөдөлмөр эрхлэлт/ тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 111 дүгээр конвенц, Тахир дутуу хүмүүсийн мэргэжлийн нөхөн сэргээлт, хөдөлмөр эрхлэлтийн тухай Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 159 дүгээр конвенц, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай 61 дүгээр конвенци зэрэг нийт 15 олон улсын баримт бичигт нэгдэн орсон байна.

5. Монгол Улсын Үндсэн хууль болон бусад ердийн 9 хуульд, УИХ, Засгийн газар, салбарын яамнаас баталсан найман хөтөлбөр, журам зэрэг баримт бичигт хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөрлөх эрхийг баталгаажуулсан байна. Энэ харилцааг зохицуулж буй хамгийн гол хууль нь Хөдөлмөрийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль байна. Хуулийн зохицуулалтын тухайд хэрэгжилтийн асуудал яригдаж байгаа бөгөөд ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхийн тулд энэ харилцаанд оролцогчдод зориулан цогцоор зохицуулах, тухайлбал Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлд Хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүний хөдөлмөрийг нарийвчлан зохицуулсан бөгөөд тодруулбал, 25, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулна. Хэрэв ийнхүү ажиллуулаагүй бол ажиллуулбал зохих орон тоо тутамд сар бүр төлбөр төлөх бөгөөд уг төлбөрийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлэн, уг хөрөнгийг хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулахыг заасан. Гэвч энэ хөшүүрэг нь нийслэл хот, төв суурин газар хэрэгжих магадлал өндөр бол хөдөө орон нутагт, аймаг, суманд 25-аас дээш ажилтантай ААН, байгууллага цөөхөн учир хэрэгжүүлэх боломж хомс байна. Тиймээс цаашид хууль тогтоомжийн заалтыг өөрчлөхдөө ХБИ-ийн квотын асуудлыг цогцоор авч үзэж, хөдөө ба хотын ялгааг харгалзах, ажил олгогчид татварын хөнгөлөлт, төрөөс урамшуулал олгох боломжийг ХБИ-ийн хөдөлмөр эрхлүүлэхтэй уялдуулах хэрэгцээ, шаардлага байгааг илэрхийлж байна. Гэртээ өөртөө тохирох ажлын байр бий болгоод түүнээсээ орлого олж амьдралаа дээшлүүлж байгаа бол түүнийг нь тохируулгатай ажлын байр гэж үзэж болох талаар эрх зүйн өөрчлөлтийг хүмүүс хүсэж байгаа нь харагдлаа. Тиймээс тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хүрээнд холбогдох хууль тогтоомж хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хэрэгжих нөхцөл, механизмыг бүрдүүлэхэд цаашид анхаарах, тухайлбал, хөдөлмөр эрхлэлтийн сангийн хөрөнгийн зарцуулалт, түүнийг зээл хэлбэрээр олгох асуудал, жижиг дунд үйлдвэрийг дэмжих тухай салбарын хуультай уялдуулах, ХБИ-ийг асран хамгаалагчийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зэрэг эрх зүйн орчны асуудлыг цогцоор нь авч үзэж, уялдаа холбоотой зохицуулах нь үр дүнтэй гэж үзэж байна.
6. ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтэнд нийгэм, эдийн засгийн орчин маш их нөлөөлж байна. Ялангуяа дэд бүтэц, гудамж талбай, нийтийн тээвэр, байгууллагуудын орц, гарц, дотоод орчин г.м. Нийт 400 судалгаанд хамрагдсан иргэдийн ажил эрхэлж буй иргэдийн 43% нь 5 ба түүнээс дээш жил ажиллаж байгаа нь ХБИ ажлын байранд тогтвор суурьшилтай, хариуцлагатай ажилладгийг харуулж байна. Эндээс харахад 54% нь эрүүл мэндийн байдлаас, 17% нь ажлын байр тохиромжтой байгаагүй, дэд бүтэц шийдэгдээгүй болон ажлын хамт олонтойгоо таатай харилцаа үүсгэж чадаагүй, хэт ачаалал гэсэн шалтгаанаас ажлаас гарсан

гэжээ. Хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаагаас гадна ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд албан газрууд налуу зам, өргөн хаалга, лифттэй байх зэргээр ээлтэй, хүртээмжтэй орчныг бий болгох нь шууд нөлөөлөх нэг хүчин зүйл болдог байна.

7. ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтэнд нөлөөлдөг дараагийн нэг хүчин зүйл нь байгууллага хамт олны хандлага, ойлголтыг өөрчлөх асуудал юм. Ажил олгогчид болон ХБИ-ийн мэдээлэл, ойлголт, боломж дутмаг, хязгаарлагдмал, ХБИ-ийг мэдээллээр хангах төрийн үйлчилгээ ч дутагдалтай байна. Хаана ямар байгууллагад ажлын байр гарсан, түүнд ямар шаардлага тавигдаж байгаа, хэрхэн зуучлах, ХБХ-ийг яаж бэлтгэх, сургах, ажилд ороход хамт олон болон ажлын байранд дасгах зэрэг үйлчилгээг төрөөс авах сонирхол, хэрэгцээ их байдаг ажээ. Судалгаанд оролцсон 400 иргэдээс ажлын байранд 48% нь ялгаварлан гадуурхагдах явдлыг хааяа болон байнга мэдэрдэг гэсэн нь ажил олгогчийн хандлага, ойлголтын байдлыг илэрхийлж байна. Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэргэжилтнүүд ХБИ-дэд бүрэн мэдээлэл өгдөггүй, аргацаадаг, хөндий харьцдаг тухай судалгаанд оролцогчид ярилцлагын үеэр илэрхийлсэн байх бөгөөд цаашид хөдөлмөрийн улсын байцаагчаас эхлээд гүйцэтгэх эрх мэдлийн түвшинд ХБИ-ийн асуудал хариуцсан орон тоон дээр ХБХ ажиллуулах нь онвчтой гэж үзжээ.
8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд төрийн бүх түвшний байгууллага үүрэг хүлээнэ. УИХ, Засгийн газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам бодлого боловсруулах, түүнийг хууль, журам хэлбэрээр батлах, баталсан хууль, эрх зүйн хэм хэмжээний актын хэрэгжилтэнд хяналт тавих үүрэгтэй байна. Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар батлагдсан төсөл, хөтөлбөр, хууль тогтоомжийг иргэнд хүргэх, мэдээллийн санг бүрдүүлэх ажлыг хариуцах бөгөөд аймаг, нийслэл, сум, дүүрэг бүх түвшинд өөрийн алба буюу ажилтанаар дамжуулан хэрэгжүүлнэ. Энэ харилцаанд Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс, мэргэжлийн хяналтын байцаагч, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ ба Засаг дарга зэрэг төрийн байгууллагууд, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөл гэсэн орон тооны бус зөвлөл ажилладаг. Түүнээс гадна донор байгууллагууд, гадаадын зорилтот төсөл хөтөлбөрүүд хэрэгждэг, ААН, байгууллагын санаачилгаар хэрэгжүүлдэг олон янзын арга хэмжээ, ТББ-ууд тодорхой үйл ажиллагаа хэрэгжүүлдэг байна. ХНХЯ, түүний харьяа салбар нэгжүүд, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөл нь ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг гол зохицуулах үүрэгтэй институт юм. Эдгээр институт хоорондын хамтын ажиллагааг уялдуулах, холбогдох нөөцийг бүрэн ашиглаж, үр дүнтэй зохицуулах хэрэгцээ, шаардлага байна.
9. ХБИ-ийг чадавхижуулах, хамтран ажиллах боломж, санаачилгыг өрнүүлэх, аргазүйн хувьд дэмжих үүний тулд ХБИ, тэдний эрх ашгийг хамгаалах ТББ-ууд аль алиных нь үйл ажиллагаанд багаар ажиллах сэтгэлгээ, чадавхийг суралцахад нь үе шаттайгаар дэмжих нь зүйтэй юм байна гэдгийг хөндлөнгийн зөвлөхүүд дүгнэж байна.

### **3.4 Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ**



## **20 дугаар зүйл. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ**

20.1.Төрөөс хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, оношлох, үнэлэх, урьдчилан сэргийлэх, эмчлэх, сувилах, сэргээн засах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

20.2.Эрүүл мэндийн байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ тэдний онцлог хэрэгцээ, шаардлагыг хангасан хүртээмжтэй орчин, техник, тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна.

ЭМЯ-наас 2018 оны 07 дугаар сарын байдлаар ирүүлсэн мэдээллээр УГТЭ, ЦССТ, СЭМҮТ, ГССҮТ, ГҮТ, СЗКЭ, СЗСҮТ, БЗД-ийн эрүүл мэндийн төв, Хэнтий аймгийн нэгдсэн эмнэлэг, Баянмөнх сум, Сэлэнгэ аймгийн БОЭТ, Орхон сум, Баян-Өндөр сумдад газар дээр нь очиж хөгжлийн бэрхшээлтэй иргэнд чиглэсэн эмнэлгийн гадаад, дотоод орчинд үнэлгээ хийсэн, орчин нөхцлийн тодорхой хэмжээнд бүрдүлсэн гэжээ.<sup>34</sup> Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хангахад эмнэлгийн тусламж, үйлчилгээнд дараахь стандартуудыг батлан, мөрдүүлж байна. Үүнд: 2017 онд батласан Нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандарт MNS 5095:2017, Клиникийн бүтэц, үйл ажиллагааны стандарт MNS 6673:2017, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн стандарт MNS 6330:2017 станартуудад Сэргээн засах тусламж, үйлчилгээнд нэн шаардлагатай 23 нэр төрлийн тоног төхөөрөмжийн жагсаалтыг тусгажээ. Хэрэгжилтийн байдлыг ирүүлээгүй байна.

**Шигтгээ:** Иргэдтэй хийсэн ярилцлагаас үзэхэд хуульд шууд заагаагүй хэдий ч сард нэг удаа өрхийн эмнэлэг, улиралд нэг удаа нарийн мэргэжлийн эмчид үзүүлэх ёстой. Ингэснээр эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын хуралдаанаар орж, группээ сунгуулах боломж бүрддэг. Зөвхөн улсын эмнэлэгт эрүүл мэндийн даатгал үйлчилж байгаа нь учир дутагдалтай, өрхийн, дүүргийн, клиник эмнэлгүүд ачаалал ихтэй, урьдчилан дугаар авах ёстой, эхлээд шинжилгээ хийлгэсний дараа дахин эмчид үзүүлэх цаг авах зэргээр олон дахин явдаг, хүндрэлтэй байдаг. Хувийн эмнэлэгт эрүүл мэндийн даатгалаар үйлчлүүлэх боломжийг олгодог бол явдал, чирэгдэл бага баймаар байна. Б.Ганчимэгтэй хийсэн ярилцлагаас. 2018.09.13

**Шигтгээ:** Би дауны холбооны төлөөлөл болон хүүгээ төлөөлж оролцож байна. Бидний хүүхдүүдийн эрх байнга зөрчигдөж байгаа. Наад зах нь халамжийн мөнгөө олж авахын тулд бишгүй хүнд суртлыг туулдаг. Хүүхэд нь заавал хэвтрийн байх ёстой, эсвэл тухайн айл нь нэн ядуу байх ёстой гэх зэрэг утгагүй цензурыг өөдөөс тавьдаг. Төрөөс халамж үйлчилгээгээ авахын тулд миний гэр бүл нэн ядуу болох, эсвэл миний хүүхэд хэвтэрт орох ёсгүй шүү дээ. Энэ бол шууд ялгаварлан гадуурхсан явдал. Үүнээс гадна боловсрол, эрүүл мэндийн салбарт хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдүүдийн эрх байнга зөрчигддөг. Саяхан манай “Монголын дауны холбоо”-ны эцэг эхчүүдээс санал асуулга авсан. Таныг, танай гэр бүлийг хамгийн их гомдоосон хүн хэн бэ гэж асуухад бараг тал нь эмнэлгийн байгууллага, эмч нар гэж хариулсан байсан. Уг нь хамгийн зөв мэдээлэл бидэнд өгч, биднийг дэмжиж сэтгэлзүйч байх ёстой хүмүүс маань эмч нар шүү дээ. Боловсролын салбарт тэр бидний хүүхдүүдэд зориулсан тусгай хөтөлбөр гэж албан ёсоор байхгүй. Эцэг, эхчүүд нь л өөрсдөө бүх ачаагаа нуруун дээрээ үүрээд явж байна. Тусгай сургуулиуд байдаг боловч яг тухайн хүүхдийн онцлогт тааруулсан хөтөлбөр байдаггүй. Би хүүхдээ хувийн сургуульд явуулсаар байгаад 12-р ангийг нь төгсгөсөн. Сургуульд хүүхдээ би юм сурсан ч

<sup>34</sup> ЭМЯ-ны 2018.07.20-ны өдрийн 2/2995 тоот албан бичиг

бай, сураагүй ч бай явуулж байгаа нь миний хүү олны дунд байж нийгэмших ёстой гэдэг бодлоос үүдэлтэй.<sup>35</sup> (У.Оюунчимэг ikon.mn-д нийтлэгдсэн ярилцлагын хэсгээс)

**Шигтгээ:** Тэргэнцэртэй хүмүүсийн хувьд эрүүл мэндийн үйлчилгээ авах туйлын хүнд байдаг. Хэдэн жилийн өмнө бариа засал гээд эмнэлгийн байгууллагаар явж байхад 00 олж чадаагүй. Эмч нарт хэлэхэд ойлгохгүй, өөдөөс бараг амаа дарж байсан. Эмнэлгийн шатаар дээш доош олон явуулна, өргөх хүн байхгүй, тусгай ор, тоног төхөөрөмж байхгүй тул хэн нэгэн дагаж эмнэлэгт хэвтэх болдог. Их төвөгтэй байдаг. Бүр зайлшгүй шаардлага гарах, хүндээр өвдөхгүй л бол бид эмнэлэг зорих боломжгүй. Эмчид цаг авах гэж нэг очно, цагаа аваад дахиж ирж үзүүлнэ, дахиж ирж шинжилгээ өгнө, дахиж ирж шинжилгээний хариугаа авна. Ийм олон удаа би эмнэлэгт явах ямар ч боломжгүй л дээ. (Б.Отгонтуяа ikon.mn-д нийтлэгдсэн ярилцлагын хэсгээс)

**Шигтгээ:** Сүүлийн үед сайжирч байгаа жишээнүүд сонсогдоод байгаа. Сүхбаатар дүүргийн эмнэлэгт манай нэг танил хараагүй хүн очиход угтах үйлчилгээ гаргасан байсан гэсэн. Та аль эмч дээр үзүүлэх вэ, ямар шинжилгээ өгөх вэ гээд дагуулж яваад, хоёр давхарт гарсан чинь бас дараагийн хүн нь угтаж аваад үйлчилсэн гэсэн. Бид энэ жишээгээ улам дэлгэрүүлж, олон хүнд сонсох ёстой болов уу. (Д.Гэрэл ikon.mn-д нийтлэгдсэн ярилцлагын хэсгээс)

Хөдөө орон нутгийн иргэд нарийн мэргэжлийн эмчид үзүүлэхийн тулд заавал Улаанбаатар хот луу ирэх шаардлагатай болдог бөгөөд энэ нь хамт явах хүнтэй хамт хоёр хүний ирэх очих тээвэр, улмаар нэмэлт зардал шаардлагатай болдог ажээ.

**Дүгнэлт:** Хуулийн 20.1, 20.2 дахь заалтын хэрэгжилтийг бүрэн зорилгодоо хүрсэн гэж үзэх боломжгүй байна. Шалтгаан нь эмнэлгүүдийн ачаалал, хүртээмжийн асуудал, улмаар эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтын асуудалтай холбоотой. Цаашид энэ зохицуулалтыг илүү тодорхой хэрэгжүүлэхийн тулд Эрүүл мэндийн салбарын хуулиуд, холбогдох журмуудад нарийвчилсан зохицуулалт оруулах шаардлагатай. Эмнэлгийн салбарт ажиллагсадын хандлагын асуудал ч мөн хамааралтай.

### **3.5. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх нийгмийн халамж**

26.1.6. насанд хүрсэн бүрэн хараагүй, сонсголгүй, хэл ярианы бэрхшээлтэй хүний харилцаа холбооны зардалд хөнгөлөлт үзүүлэх;

26.1.7. дотоодын рашаан сувилалд сувилуулах шаардлагатай дараах хүнд ирж, очих унааны, ор хоногийн зардлыг эрүүл мэндийн даатгалтай иргэний энгийн өрөөний тарифаар тус тус тооцон доор дурдсан хувиар жилд нэг удаа нөхөн олгох:

26.1.7.а. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд 100 хувь;

26.1.7.б. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асран халамжилж яваа нэг иргэнд 50 хувь;

26.1.7.в. үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас хөнгөлөлт авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 50 хувь.

26.1.9. бүрэн хараагүй хүн эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр эмчлүүлэх, рашаан сувилалд сувилуулахаар аймгаас нийслэлд, нийслэлээс аймагт зорчсон тохиолдолд ирж, буцах унааны зардлын 75 хувийг жилд нэг удаа нөхөн олгох;

26.1.12. хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нь хүүхдийн зусланд амарвал эрхийн бичгийн 50 хувийг жилд нэг удаа олгох;

26.1.13. хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд эмнэлгийн магадлагаагаар дотоодод усан эмчилгээ хийлгэсэн бол эмчилгээний төлбөрийн 70 хувийг нөхөн олгох;

<sup>35</sup> <https://ikon.mn/opinion/1613>

26.1.16. аарцаг эрхтэний үйл ажиллагаа алдагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүнд эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр зайлшгүй шаардлагатай асаргаа сувилгаа, ариун цэвэр-эрүүл ахуйн материалын дэмжлэг үзүүлэх.

26.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төрөлжсөн асрамжийн болон олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамруулж болно.

26.3. Өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэн болон тэдгээрийг асран хамгаалагчийг нийгмийн халамжийн үйлчилгээ, тусламжид хамруулна.

26.4. Энэ хуулийн 26.1.1, 26.1.2, 26.1.3, 26.1.4, 26.1.5, 26.1.6-д заасан тусламж, хөнгөлөлтийн хэмжээ, олгох журам, жишиг үнийг Засгийн газар батална.

Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх нийгмийн халамжийн зохицуулалтын хэрэгжилтийн талаар аймгуудын ХХҮГ-ын ажилтнуудаас дараахь санал гаргасан байна. Тодруулбал, 26.3-т заасан өрхийн мэдээллийн санд бүртгэлтэй иргэд нь дотоодын рашаан сувилалд сувилуулах, ирж орчих унааны, ор хоногийн мөнгөө өөрсдөө урьдчилан төлж үйлчлүүлэх эдийн засгийн бололцоо багатай хүмүүс байдаг тул хуулийн зохицуулалтыг тодорхой болгож, эхэлж хөнгөлөлт, дэмжлэгийн асуудлыг шийдвэрлэж, боломжийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэн, асран хамгаалагчдад олгохгүй бол хэт ерөнхий тунхаг маягтай заалт болдог ажээ. Тиймээс эсхүл байнгын асаргаанд байдаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, хүн, асран хамгаалагчийг гэдэг байдлаар ч юмуу өөрчлөн томьёолж байж зорилгодоо хүрэх магадлалтай. 26.1.6-д заасан “аарцаг эрхтэний үйл ажиллагаа алдагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүнд эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр зайлшгүй шаардлагатай асаргаа сувилгаа, ариун цэвэр-эрүүл ахуйн материалын дэмжлэг үзүүлэх” гэдэг нь өнөөдрийг хүртэл хэрэгжүүлээгүй. Учир нь “зайлшгүй шаардлагатай асаргаа сувилгаа, ариун цэвэр-эрүүл ахуйн материал” гэдэгт яг юуг хамааруулах нь тодорхойгүй, тиймээс ч төсөвт ийм зардал тусгадаггүй ажээ.

26.1.9-д заасан “бүрэн хараагүй хүн эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр эмчлүүлэх, рашаан сувилалд сувилуулахаар аймгаас нийслэлд, нийслэлээс аймагт зорчсон тохиолдолд ирж, буцах унааны зардлын 75 хувийг жилд нэг удаа нөхөн олгох” гэдгийг 26.1.10-т заасантай адилтган “аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын хяналтын комиссын шийдвэрээр нийслэлд ирж эмчлүүлэх, шинжилгээ хийлгэх тохиолдолд ирж, очих унааны зардлыг жилд нэг удаа нөхөн олгох” гэж оруулах нь зүйтэй. Хөгжлийн бэрхшээлтэй хүн дундаа бүрэн хараагүй хүмүүсийн унааны зардлыг 75 хувь хэмээн ялгаварласан нь илт хүний эрхийн дордуулсан, үндэслэл муутай заалт болжээ гэж аймгуудийн хөдөлмөр, халамжийн хэлтсээс ирүүлсэн саналд дурдсан байна. Мөн түүнчлэн тус хуулийн 26.1.7.б-д хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асран халамжилж яваа нэг иргэнд 50 хувь, 26.1.12-т заасан хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нь хүүхдийн зусланд амарвал эрхийн бичгийн 50 хувийг жилд нэг удаа олгох, 26.1.13-т заасан хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд эмнэлгийн магадлагаагаар дотоодод усан эмчилгээ хийлгэсэн бол эмчилгээний төлбөрийн 70 хувийг нөхөн олгох гэдэг заалт нь зорилгоо бүрэн хангаж чадахгүй байна. Хүүхдийн эрхийг хангах тухайд Үндсэн хуулиар хүлээсэн төрийн үүрэг байдаг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хангахад тэгш боломж олгох, нийгмийн харилцаанд оролцоход дэмжлэг үзүүлэхийн тулд 26.1.7б, 26.1.12, 26.1.13-т заасан нөхөн олгох заалтыг 100 хувь болгох нь зүйд нийцнэ. 26.1.6-д заасан “насанд хүрсэн бүрэн хараагүй, сонсголгүй, хэл ярианы бэрхшээлтэй хүний харилцаа холбооны зардалд хөнгөлөлт үзүүлэх” хэмжээг өнөөдрийг хүртэл тогтоогоогүй, хэн тогтоох нь шууд ойлгомжтой, тодорхой биш үлджээ.

26.4-т заасан тусламж, хөнгөлөлтийн хэмжээ, олгох журам, жишиг үнийг Засгийн газраас баталдаг, тэгэхдээ үнийн жишиг бодит байдалд нийцэж байгаа эсэх дээр хөгжлийн бэрхшээлтэй иргэд гомдолтой байдаг, өөрөөр хэлбэл баталсан үнээр сайн чанартай хэрэгсэл авах боломжгүй байдаг гэж үздэг байна.

**Дүгнэлт:** 2005 оны Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн хамгааллын тухай хууль гэж байсантай холбоотой өмнөх хуулиуд ерөөс хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн хамгаалал, халамжийн асуудлыг зонхилон зохицуулдаг байсантай холбоотой хуулийн 26 дугаар зүйлийн хөнгөлөлт, дэмжлэгийн асуудал зохицуулсан заалт нь практикт тодорхой хэмжээгээр хэрэгждэг. Гэсэн хэдий ч зарим заалтыг зорилгод хүрэх, оролцогчдын эрхийг хангахын тулд зарим нэмэлт өөрчлөлт, нийцүүлэх шаардлагатай байна.

### 3.6 Хөгжлийн бэрхшээлтэй хүний хууль зүйн туслалцаа авах эрх

27 дугаар зүйл. Хууль зүйн туслалцаа авах эрх.

27.1. Шүүх, прокурор, хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байна.

27.2. Төрөөс хөгжлийн бэрхшээлтэй хүн шаардлагатай хууль зүйн зөвөлгөө, тусламж үйлчилгээгээр үнэ төлбөргүй хангагдах нөхцөл бололцоог бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

27.3. Шүүх, прокурор, хууль хяналтын байгууллага нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох хөгжлийн бэрхшээлтэй хүнд түүний эрх, үүрэг болон холбогдох мэдээллийг хөгжлийн бэрхшээлийн онцлогт нь нийцүүлэн ойлгомжтой, хүртээмжтэй хэлбэрээр тайлбарлаж өгнө.

27.4. Шүүх, прокурор, хууль хяналтын байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүн эрх ашгаа хамгаалахад хүртээмжтэй орчныг бүрдүүлэх үүрэгтэй бөгөөд тэдгээрийг текст уншигч, бичигч, дохионы хэлний хэлмэрч, орчуулагчаар үнэ төлбөргүй хангах ба үйлчилгээний зардлыг улсын төсөвт тусгана.

ХЗДХЯ болон түүний харьяа агентлаг, байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж байгууллагын нөөцөд буй холбогдох хууль тогтоомжийг сурталчилсан видео санамж мэдээллийг дохионы хэлээр орчуулах ажлыг Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 29 дүгээр бүрэн дунд сургуулийн дохионы хэлний орчуулагч багштай хамтран зохион байгуулсан. Энэхүү видеог 2018 оны 06 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн байгууллагын үйлчилгээний зааланд байрлах дэлгэцэнд болон байгууллагын цахим хуудсанд байршуулан ажиллуулж байна. Улсын бүртгэлийн байгууллагын хэмжээнд 101 хэлмэрч, хөтөч энэ чиглэлийн үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд нийслэлийн 9 дүүрэг, нэгдсэн үйлчилгээний 4 төвийг брайл үсгээр хэвлүүлсэн нугалбараар хангасан.

ЦЕГ-ын даргын тушаалаар батласан 2014 оны 429 дүгээр тушаалаар батласан "Байгууллагын стандарт", 2015 оны А/04 дүгээр тушаалаар батласан ""Хэлний бэрхшээлтэй хүнд туслах журам код 238" 2015 оны А/18 дугаар тушаалаар батласан "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх код 326"-ыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.<sup>36</sup>

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах Улаанбаатар хотын сонсголгүй иргэдийг байцаан шийтгэх байгууллагын үйлчилгээг

<sup>36</sup> ХЗДХЯ-ны 2018.07.20-ны 1-4/3700 тоот албан бичгээр ирүүлсэн мэдээллээс.

хүртээмжтэй болгох зорилгоор дохионы хэлний орчуулгын үйлчилгээ үзүүлэх төлбөрийг НЗДТГ-ын төсвөөс гаргахаар А-419 дугаар тоот тушаалаар НЗДТГ-ын “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зөвлөл”-ийн 2016 оны 04-р сарын 27-ны өдрийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн. Энэхүү үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр 2016 онд Нийслэлийн нийгмийн халамж үйлчилгээний газартай Дохионы хэлний хэлмэрч орчуулагчдын холбоо (ДХХОХ) ТББ гэрээ байгуулан амжилттай гүйцэтгэсэн байна. Байцаан шийтгэх үйл ажиллагааны дохионы хэлний хэлмэрчийн үйлчилгээг амжилттай зохион байгуулахын тулд Нийслэлийн цагдаагийн газартай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулан ажиллажээ. Мөн Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурор, Цагдаагийн ерөнхий газар зэрэг байгууллагуудад “Байцаан шийтгэх үйл ажиллагаанд оролцох сонсголгүй иргэдэд дохионы хэлний хэлмэрчийн үйлчилгээ үзүүлэх” талаар албан тоот хүргүүлж, энэхүү үйлчилгээг үзүүлэх мэргэжлийн дохионы хэлний хэлмэрч, орчуулагчдын танилцуулгыг хүргүүлэн ажилласан. Нийслэлийн нийгмийн халамж үйлчилгээний газартай байгуулсан гэрээ 2016 оны 12 дугаар сард дуусгавар болсон ч Дохионы хэлний хэлмэрч орчуулагчдын холбоо нь сонсголгүй иргэдийн эрхийг хангах, байцаан шийтгэх байгууллагын үйлчилгээг хүртээмжтэй болгох зорилгоор дохионы хэлний орчуулгын үйлчилгээг мэргэжлийн хэлмэрч орчуулагчдаар дамжуулан өдийг хүртэлх хугацаанд өөрсдийн төсвөөр энэхүү үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлсээр байна. 2017 онд байгууллагуудын албан хүсэлтийн дагуу нийт давтагдаагүй тоогоор 90 (давтагдсан тоогоор 121) сонсголгүй иргэдийн байцаан шийтгэх үйл ажиллагаанд дохионы хэлний давтагдаагүй тоогоор 54 /давхардсан тоогоор 96/ хэлмэрч орчуулагчид нийтдээ 283,7 цаг 8,227,300 (найман сая хоёр зуун хорин долоон мянга гурван зуу) төгрөгийн үйлчилгээг хүргэжээ.

**Дүгнэлт:** 27 дугаар зүйлийг төрийн болон төрийн бус байгууллагаас тодорхой үйл ажиллагаа авч хэрэгжүүлэн зарим ахицтай үр дүн гарч эхэлж байна гэж үзэж байна. Энэхүү хуулийн заалт нь практикт хэрэгжиж, талуудад хүлээн зөвшөөрөгдөж, зорилгодоо хүрч чадсан байна.Үйл ажиллагааны тогтмол байдлыг хангахын тулд санхүүгийн нөөцийн асуудлыг цаашид харгалзах шаардлагатай.

### **3.7. Хөгжлийн бэрхшээлтэй хүний бусад эрх**

33.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг биеийн тамир, спортын тэмцээн, уралдаанд оролцоход нь төрөөс дэмжлэг үзүүлнэ.

33.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүний биеийн тамир, спортын арга хэмжээг зохион байгуулахад төрөөс дараахь дэмжлэг үзүүлнэ:

33.3.1.хөгжлийн бэрхшээлтэй хүн биеийн тамир, спортоор хичээллэх, өөрийн авьяас чадвараа нээн хөгжүүлэхэд дэмжих үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх;

33.3.2.биеийн тамир, спортын байгууламж нь хөгжлийн бэрхшээлтэй хүн тэмцээн уралдаан, нийтийн биеийн тамирын арга хэмжээнд оролцох, бэлтгэл сургуулилт хийхэд тохиромжтой заал, талбай болон тохирох хэрэглэгдэхүүнээр тоноглогдсон байх;

33.3.3.хөгжлийн бэрхшээлтэй тамирчдыг олимп, паралимп, тусгай олимп, дифлимп, дэлхийн, тивийн хэмжээний олон улсын тэмцээнд холбогдох журмын дагуу шалгаран явахад нь хуульд заасны дагуу дэмжлэг үзүүлэх.

33.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүн олимп, паралимп, дифлимп, тусгай олимп, тивийн наадам, дэлхийн зэрэглэлийн тэмцээнд оролцож алт, мөнгө, хүрэл медаль хүртсэн

тохиолдолд түүний оролцсон тэмцээний давтамжийн хугацаанд ногдох тэтгэвэртэй нь тэнцэх хэмжээний нэг удаагийн мөнгөн урамшуулал олгоно

Аймгуудын хөдөлмөр халамжийн хэлтсээс ирүүлсэн саналаар хамгийн их хэрэгжихгүй байна хэмээн ирүүлсэн заалт 33.3 болон 33.4 дэх заалт байна. Өөрөөр хэлбэл дээрхи хоёр хуулийн заалтын эх үүсвэр хаанаас гарах нь тодорхойгүй, нийгмийн халамжийн сангаас гардаггүй тул бодит байдал дээр олгох боломж бүрддэггүй болохыг дурджээ.

Шигтгээ: Манайд эрхийг цогцоор нь авч үздэггүй. Голцуу салангид байдлаар хараад хэрэгжүүлэх гээд бүтэлгүйтээд байдаг. Хэрвээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сургууль сурч чадаагүй бол дараа нь ажил эрхлэлтийн тухай ярихад хэцүү. Тэргэнцэртэй иргэдэд зориулсан налуу замтай байшин баригдлаа гэдэг. Очоод үзэхээр хаалганы босгоо янзлаагүй, хаалга нь тэргэнцэртэй хүн ороход багтахгүй, дотор нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан 00 байдаггүй. Барилга байшингаа барихдаа хүртэл бид хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хандаж асуудлаа цогцоор нь харж чадахгүй л байна. Эрх гээд ярихаар сурч боловсрох, хөдөлмөр эрхлэх, мэдээлэл авах, үзэл бодлоо илэрхийлэх гэх зэрэг олон зүйлийг ярих ёстой. Эдгээр эрхүүдийг цогцоор нь хараад бид нийгэмдээ эрхээ эдлээд амьдарч чадаж байгаа юу гэвэл чадахгүй байгаа<sup>37</sup>. (Д.Гэрэл ikon.mn-д нийтлэгдсэн ярилцлагын хэсгээс)

**Дүгнэлт:** Хуулийн 33.3, 33.4 практикт бүрэн хэрэгждэггүй ажээ. Тиймээс дээрхи хоёр заалтын санхүүгийн ямар эх үүсвэрээс, ямар журмаар хэрэгжүүлэх тухайд нэмэлт зохицуулалт, тодруулга шаардлагатай байна.

### **3.8.Хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоох**

#### **37 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоох**

37.1.Хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг дараахь шалгуураар тогтооно:

37.1.1.эрхтэн тогтолцооны бүтцийн алдагдал, ангилал, хугацаа;

37.1.2.биеийн үйлдэл, үйл ажиллагааны олон улсын ангилал.

37.2.Хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг дараахь комисс /цаашид “Комисс” гэх/ тогтооно:

37.2.1. 0-16 насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс;

37.2.2. 16 ба түүнээс дээш насны хүний хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс;

37.2.3.хөгжлийн бэрхшээлтэй болсон шалтгаан, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс.

38.4.Энэ хуулийн 38.1-д заасан үнэмлэхийн загвар, түүнийг олгох журмыг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

38.5.Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, нэгтгэсэн “Мэдээллийн нэгдсэн сан”-г бүртгэл, статистикийн төрийн захиргааны байгууллага, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал

<sup>37</sup> <https://ikon.mn/opinion/1613>

эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хамтран бүрдүүлж, холбогдох байгууллагыг мэдээллээр хангана.

37.1-д заасан шалгуур нь хязгаарлагдмал, хуулийн нэр томъёоны заалттай зөрчилддөг. 37.2.1-ийг хэрэгжүүлэхэд Засгийн газрын 2016 оны 200, 2017 оны 197 дугаар тогтоолоор батлагдсан журам, дүрэмд зрөчилтэй, тухайлбал байнгын асаргаа шаардлагатай эсэхийг хэн тогтоох нь тодорхойгүй. 37.2.2-ийг ажил мэргэжлийн өвчнөөс шалтгаалсан хөдөлмөрийн чадвар алдалтыг зөвхөн Улаанбаатар хотод тодорхойлдог тул энэхүү тоо, мэдээгээ аймгуудын ЭХМК-т өгч байхгүй бол тоо, мэдээлэл нь зөрдөг. Мөн түүнчлэн байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй ахмад настныг сумын их эмч тогтоодог нь тэтгэмжийг мөн хавтгайруулахад хүргэдэг тул анхаарах шаардлагатай. Хуулийн 38.4 дэх заалт төсөв батлагдаагүйн улмаас хэрэгждэггүй. Хуулийн 38.5-д заасан статистик мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг нэгдмэлээр зохион байгуулах шаардлагатай. Өмнө хэсгүүдэд дурьдсанаар статистик тоо байнга зөрүүтэй байдаг. Өмнө энэхүү тайлангийн 3.1, 3.2, 3.3 дахь хэсэгт дурьдсан статистик тоо өөр өөр байгааг тухай бүр харьцуулан дурьдсаныг үзнэ үү. Энд мөн тухайлсан төрийн байгууллагын албан ёсны илтгэл, мэдээлэлд нэрлэсэн зөрүүтэй тоог жишээлж дурдав.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй өрхийн ядуурлын түвшин бусад өрхөөс 2 дахин их, хөдөлмөрийн насны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 70 хувь нь ажилгүй, 6-18 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 50 хувь нь сургуульд хамрагдаагүй, бичиг үсэг мэдэхгүй, 3-5 насны насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 64 хувь нь цэцэрлэгт хамрагдаж чадаагүй гэсэн сэтгэл зовоосон статистик тоо байна. <sup>38</sup>	Монгол улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 20 хүрэхгүй хувь хөдөлмөр эрхэлж байна. <sup>39</sup>
	6-18 насны нийт 7279 хүүхэд байгаагаас 354 хүүхэд сургууль завсардсан. <sup>40</sup>

**Дүгнэлт:** Хуулийн 37.1 ба 37.2-ийн практик нийцэл хангалтгүй. Хуулийн 38.5-ийг тус хуулийн 43 дугаар зүйлтэй уялдуулан хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн агентлагт энэхүү чиг үүргийг хуулиар хариуцуулах боломжтой.

#### IV. ГАДААД УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Монгол Улсын УИХ-аас 2016 онд баталсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх ажлын хүрээнд дараахь гурван улсын адил зохицуулалт бүхий хууль тогтоомжийн судалгаа. Гол зорилго нь Монгол Улсад хэрэгжилт хангалтгүй байгаа зохицуулалтын харилцааг бусад улсад хэрхэн зохицуулж байгаад дүн шинжилгээ хийж, улмаар адилтган авч хэрэглэх, суралцах боломжтой туршлагын талаар дүн шинжилгээ хийхэд оршино. Дэлхийн улс орнуудад энэ салбарын хууль тогтоомжид өөрчлөлт оруулах сэдэл болсон, НҮБ-ийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай

<sup>38</sup> <https://president.mn/1352/>

<sup>39</sup> ХНХЯ, Жайка ОУХАБ, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: бодлого, үйл ажиллагаа, 2017 он, 24 дэх тал

<sup>40</sup> Т.Ням-Очир, БСШУСЯ, "Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийн хэрэгжилт, тулгамдсан асуудал", 2018.07.03-ны өдрийн онол, практикийн бага хуралд хэлэлцүүлсэн илтгэлээс.

конвенци батлахад нөлөөлсөн гэдэг утгаар АНУ-ын хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай хуулийг сонгон авлаа. Пост-коммунист тогтолцоотой улс байсан бөгөөд Монгол Улстай адил 1990 оны эхээр шилжилт хийж ардчилсан дэглэмтэй болсон, Европын холбооны гишүүн улс хэдий ч түүн дундаа тэргүүн хөгжилтэй улсын тоонд ордоггүй Болгар улсын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд татан оролцуулах тухай хуулийг, мөн Монгол Улстай хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлд хамтран ажилладаг хууль зүйн системийн хувьд онцлогтой Япон улсын хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг зохицуулж буй хууль тогтоомжийг сонгон, судалсан болно.

#### **4.1. АНУ-ын хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай хууль (ADA)**

Энэ хуулийн үндэс нь 1973 оны сэргээн засах тухай хуулийн 504 дүгээр хэсгээс эхтэй. АНУ-ын хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай хуулиар хөгжлийн бэрхшээлийн улмаас хөдөлмөрлөх, нийтийн үйлчилгээ хүртэх, нийтийн албан байгууллагаас үйлчилгээ авахад ялгаварлан гадуурхахыг хориглосон. Үүнээс гадна 1975 оны Хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсролын тухай хууль (IDEA) үйлчилдэг. 1990 онд баталсан АНУ-ын хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай хууль нь хөгжлийн бэрхшээлийн улмаас ялгаварлан гадуурхахыг хориглосон иргэний эрхийг баталгаажуулсан хууль юм. (42 U.S.C. § 12101) 1964 оны иргэний эрхийн тухай хуульд заасан хөгжлийн бэрхшээлтэй хүний ялгаварлан гадуурхагдахаас хамгаалахтай адил зохицуулалтыг агуулдаг: арьс өнгө, шашин шүтлэг, хүйс, угсаа гарал, бусад хууль бус шинжээр ялгаварлан гадуурхахыг хориглоно. Уламжлалт ойлголт дээр энэхүү хуулиар нэмж, ажил олгогчийг тухайн ажилтанд тохирсон тоноглолоор хангах, нийтийн барилга байгууламжийн хүртээмжийн асуудлыг зохицуулсан. 1986 онд Хөгжлийн бэрхшээлийн үндэсний зөвлөл энэхүү хуулийн төслийг зөвлөмж болгосоноор 1988 онд сенат ба конгресст танилцуулсан. Сүүлийн хувилбараар 1990 оны 07 сарын 26-нд батлагдсан. 2008 онд өөрчлөлт оруулсан ба нэмэлт өөрчлөлт 2009 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр болж үйлчилжээ. Хуулийн бүтэц нь 1. хөдөлмөр эрхлэлт, 2. нийтийн байгууллага (нийтийн тээвэр) 3. нийтийн тоноглол (бизнесийн байгууламж) 3.1 үйлчилгээний амьтан 4. телекоммуникаци 5. бусад асуудал хэмээх бүтэцтэй.

Энэ хуулиар хөгжлийн бэрхшээл гэдгийг биеийн болон оюуны бэрхшээлийг ойлгоно хэмээн заасан. Хөгжлийн бэрхшээл нь заавал үргэлжилсэн байнгын эсхүл хүнд хэлбэрийн байхыг шаардахгүй. Тэгш хөдөлмөрлөх боломжийг хангах комиссын баталсан журмаар хөгжлийн бэрхшээлийг дараахь байдлаар ангилна: дүлий, хараагүй, оюуны бэрхшээл, хэсэгчлэн эсхүл эрхтэн дутуу эсхүл хөдөлгөөний хязгаарлалтын улмаас тэргэнцэр ашиглах, аутизм, хавдар, цус харвалт, чихрийн шижин, эпилепси, ХДХВ халдвар, мэдрэлийн хавсарсан эмгэг, булчингийн сулрал, сэтгэл гутралын хүнд эмгэг, биполар эмгэг, өнгөрсөний траума стрессийн эмгэг, албадсан зуршлын эмгэг, шизофрени.

Үүнээс өөр бусад биеийн болон оюуны нөхцөл байдал тухайн хувь хүний илрэх симптомоос хамаараад "зовиурыг багасгах" (эмчилгээ, засал, туслах хэрэгсэл, нөхөн сэргээх бусад чиг үүрэг бүхий бусад хэрэгсэл), "идэвхижсэн үе шат"-анд байгаа үед хөгжлийн бэрхшээл гэж үзэх боломжтой. Зарим тусгай нөхцөл болох нийгэмшээгүй, хууль бус үйлдэл хийх зуршилтай, хүүхэд сонирхогч гаж зуршил, өөрт хэрэггүй эд зүйл хулгайлах зуршил, бэлгийн гаж зуршил зэрэг нь "хөгжлийн бэрхшээл"-д хамаарахгүй. Мөн хүйсийн өөрчлөлт зэрэг бусад онцлог нөхцөл ч хөгжлийн бэрхшээлд хамаарахгүй.

**I дүгээр бүлэг—Хөдөлмөр эрхлэлт 42 U.S.C. §§ 12111–12117.**



Энэ хууль нь "хамаарах ААН"-д үүрэг хүлээлгэсэн. Ажилд орох хүсэлт гаргах явц, ажилд томилох, ажилтаны хөгжил, дэвшил, ажлын сургалт, давуу талуудыг зохицуулна. "Хамаарах ААН" гэдэг нь 15 ба түүнээс олон ажилтантай ажил олгогчийг, ажил олгох агентлаг, хөдөлмөрийн байгууллага болон хөдөлмөр-менежментийн хамтарсан хороог ч багтаана. Энд хөгжлийн бэрхшээлтэй холбоотой асуулт асуух талаар шууд хязгаарлалт үйлчлэх бөгөөд эмнэлгийн үзлэг, эмчилгээний мэдээлэлийн нууцыг хадгалах үүрэг хүлээнэ. Холбогдох ААН-үүд нь тухайн хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулж ажил гүйцэтгэх нэмэлт тоноглолоор хангах үүрэг хүлээнэ. Шаардлагатай нэмэлт тоноглол гэдэг нь ердийн ажлын байр, ажлын тоног төхөөрөмж, хэрэгслийг уг ажлыг гүйцэтгэхийн тулд хөгжлийн бэрхшээлтэй хүний тусгайлсан хэрэгцээ шаардлагад тохируулан өөрчлөлтийг төлөвлөн, улмаар түүнийгээ хэрэгжүүлэхийг ойлгоно.

Ихээхэн хүндрэлтэй бий болгох, эсхүл маш их зардлаар бий болгохоор тусгай тоноглол хэрэгтэй бол түүнийг ажил олгогч заавал хангах үүрэг хүлээхгүй. Тусгай тоноглолоор хангагдсан ажилтан ажлын хамгийн гол чиг үүргийг гүйцэтгэх үүрэгтэй, ажил гүйцэтгэх ердийн шаардлагыг хангах ёстой болно. Хар тамхи хэрэглэдэг ажилд орох хүсэлт гаргагчийг ажил олгогчийн шаардлага хангахгүй гэж үзнэ. 15-аас дээш ажилтантай ажил олгогч бүх ажилтандаа шаардлагатай тоноглолыг хангахад шударга хандах үүрэгтэй. Хэдийгээр тухайн ажилтан ажил үүргээ хангалттай гүйцэтгэж байгаа хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй хүний бүх стандартыг ажил олгогч дагах үүрэгтэй.

АНУ-ын Дээд шүүхээс Board of Trustees of the University of Alabama v. Garrett хэрэгт зарим мужуудын бие даасан байдлыг тодорхойлох Үндсэн Хуулийн 11 дүгээр нэмэлтэд заасан эрхийг 1 дүгээр бүлэг хөндсөн, үндсэн хуульд нийцэхгүй байна гэж үзсэн. Шүүхээс мужийн ажил олгогчид АНУ-ын хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай хууль зөрчсөн гэдэгт үндэслэж болохгүй гэсэн. Харин ажилтан Холбооны Хууль зүйн департамент эсхүл Хөдөлмөрлөх тэгш боломжийг хангах комисст өөрсдийн нэрийн өмнөөс гомдол мэдүүлэх эрхтэй гэжээ.

## **II дугаар бүлэг—нийтийн албан байгууллага (нийтийн тээвэр) 42 U.S.C. §§ 12131–12165.**

Энэ хуулийн хоёрдугаар бүлэг нь нийтийн бүх албан байгууллага, хот, тосгон, дүүрэг, мужийн түвшний бүх сургууль хөгжлийн бэрхшээлийн улмаас ялгаварлан гадуурхахыг хориглоно. 2 дугаар бүлэг нь албан байгууллагаас үзүүлдэг үйлчилгээ, хөтөлбөрт оролцох, хамрагдах боломжийн талаар зохицуулсан. Хүртээмж нь АНУ-ын хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай хуулийн хүртээмжийн стандартыг дизайн дээр заасан биеийн хувьд болон ялгаварлан гадуурхаагүй бодлого, үйл ажиллагаанд илрэх хөтөлбөрийн хүртээмж байх ёстой. 2 дугаар бүлэг нь нийтийн тээврийн хэрэгслийг Тээврийн департаментийн зохицуулалтанд нийцсэн байдлаар хүртээмжийг бий болгохоор зохицуулсан. Үндэсний төмөр замын зорчигчдын корпораци (Amtrak), бусад холбогдох байгууллагууд мөн хамаарна. Энэхүү хэсэг нь нийтийн албан байгууллага нь замын үйлчилгээг, дамжих, суух үйлчилгээг бий болгохыг шаарддаг. Хуулиар нийтийн тээврийн хэрэгслээр зай талбайн хувьд тэргэнцэртэй явж болох хамгийн бага түвшний стандартыг байгуулахыг заасан. 2 дугаар бүлэг нь холбооны улсын болон муж улсын, орон нутгийн орон сууц, орон байрны тоноглол, мөн орон байрны зааварчилгааны талаар агуулсан байна. Орон байр болон тэгш боломжийн оффис нь энэхүү зохицуулалтын хэрэгжилтэнд хяналт тавих үүрэгтэй.

### **Үйлчилгээний амьтан**

Хуулиар үйлчилгээний амьтаныг (сургасан амьтан) тодорхой зохицуулжээ. Зааварчилгаа нь зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамгаалахад зориулсан төдийгүй өөрийн байрандаа үйлчилгээний амьтаныг байршуулах бизнес эрхлэгчийн эрсдлийг багасгахад чиглэдэг. Бизнес эрхлэгч нь тухайн амьтныг үйлчилгээний сургасан амьтан мөн эсэх, ямар нарийн ур чадвар гүйцэтгэх чадвартай болохыг асуух эрхтэй боловч харин тухайн амьтныг ямар нэг үүрэг гүйцэтгэхийг хүсэх, эсхүл амьтны тусгай үнэмлэх шаардах эрхгүй. Түүнчлэн тухайн иргэний хөгжлийн бэрхшээлийн төрлийг асуух эрхгүй. Дараахь хоёроос бусад тохиолдолд орон байрнаас хөөх эрхгүй: амьтан нь хяналтаас гарч, эзэн нь түнийгээ хянах чадваргүй бол (нохой ресторанд ороод хяналтгүй архирах г.м ) эсхүл амьтан бусад хүний эрүүл мэнд, аюулгүй байдалд шууд аюул заналхийлж байгаа.

Аллерги болон айдас нь бусад хүмүүсийн эрүүл мэнд болон аюулгүй байдалд хамаарахгүй, өөрөөр хэлбэл энэ үндэслэлээр амьтантай байхыг хориглох боломжгүй. Бизнес эрхлэгчид хэдийгээр ердийн үеийн журмаар амьтан нэвтрүүлэхийг хориглодог байлаа ч хоолны үйлчилгээ үзүүлдэг бол хөгжлийн бэрхшээлтэй хүнийг амьтны хамт нэвтрүүлэх үүрэгтэй. Энэ тохиолдолд бизнес эрхлэгч нь амьтны хоол бэлдэх, ариун цэврийн өрөөнд тусдаа талбай гаргаж өгөх үүрэг хүлээхгүй. Үйлчилгээний нохойтой орсоны төлөө илүү төлбөр нэхэмжлэх эрхгүй, эсхүл шударга бусаар ганцааранг бусад хүнээс тусгаарлаж суулгах ёсгүй. Хөгжлийн бэрхшээлтэй хүн нь бусад ердийн хүнээс "дор" ямар ч үйлчилгээ хүртэх ёсгүй. Хэдийгээр ийм төрлийн бизнес эрхлэгч нь хүний улмаас учруулсан хохирлыг хариуцдаг хэдий ч харин хөгжлийн бэрхшээлтэй хүн өөрөө амьтнаас өмчид нь учруулсан хариуцлага хүлээнэ.

### **III дугаар бүлэг—нийтийн байгууламж (үйлчилгээний төхөөрөмж) 42 U.S.C. §§ 12181–12189.**

АНУ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай хууль нь нийтийн байгууламжинд нэвтрэх барилгын стандартыг тогтоосон. 3 дугаар бүлгийн хүрээнд хөгжлийн бэрхшээлийн улмаас нийтийн газар дээр түрээслэж, өмчилж, эсхүл хамтран ажиллаж буй этгээдээс ямар ч хүн бараа, үйлчилгээ, байгууламж, эсхүл тоноглолын хувьд ялгаварлан гадуурхагдахгүйгээр бүрэн, тэгш хүртэх эрхтэй болохыг тусгасан. Нийтийн байгууламж гэдэгт зочид буудал ба дэн буудал зэрэг ч хамаарах бөгөөд тээвэр, боловсрол, хоолны газар, дэлгүүр, үйлчилгээний газар, амралтын зэрэг ихэнхи орон байрыг ойлгоно. Мөн нийтийн зар мэдээг хамааруулан ойлгоно.

3 дугаар бүлгийн хүрээнд 1992 оны 7 дугаар сараас хойшхи бүх шинэ барилга, өргөтгөл, өөрчлөн засварлах ажил нь энэ хуульд ишлэсэнээр Хөгжлийн бэрхшээлтэй америк хүний хүртээмжийн зааварчилгаа (Americans With Disabilities Act Accessibility Guidelines)-нд нийцсэн байхыг шаардана.

Энэ хуулийн 3 дугаар бүлэг нь өмнө баригдсан барилга байгууламжинд мөн үйлчлэхээр заасан.3 дугаар бүлэгт хэрэглэсэн "ялгаварлан гадуурхалт" гэдэг нь барьсан барилга, байгууламжин дахь архитектурын саадыг "зайлуулахгүй байгаа"-г хэлнэ хэмээн заажээ. 42 U.S.C. § 12182(b)(2)(A)(iv). Өөрөөр хэлбэл барилга байгууламжийг нийцүүлж өөрчлөх, засварлах, өргөтгөх нь энэ хуулийн дагуу үүрэг болгосон билээ. Хуулиар тогтоосон стандарт нь "саад бэрхшээлийг зайлуулах" товчхондоо Хөгжлийн бэрхшээлтэй америк хүний хүртээмжийн зааварчилгааны (ADAAG) дагуу "хялбар хэрэглэхүйц",,, тухайлан тодорхойлсоноор "...их хэмжээний хүндрэл, бэрхшээл эсхүл зардал гаргалгүйгээр хялбар байдлаар гүйцэтгэх". Хуулийн "хялбар хэрэглэхүйц байдал" гэдэг нь түүнийг засварлахад гарах зардал ба тухайн бизнес эрхлэгч эсхүл өмчлөгчийн амин зуулга хоёрыг харьцуулдаг.

Тиймээс "хялбар хэрэглэхүйц байдлыг" санхүүгийн чадвартай корпорацид боломжтой, харин жижиг, орон нутгийн бизнесийн хувьд боломж муутай байх магадлалтай. Тиймээс ч энэхүү бүлэгт дараахь тусгай зохицуулалтыг оруулжээ. хувийн клуб, шашны байгууллага нь энэхүү бүлгийн дагуу үүрэг хүлээхгүй. Түүхэн өмчид хамаарах жагсаалтанд багтах газар, байгууламжийн тухайд гуравдугаар бүлгээр зохицуулсан стандартыг байж болох боломжтой хувилбараар хангах үүрэг хүлээлгэсэн. Ингэхдээ "түүхэн ач холбогдолтой тухайн барилгын ирээдүйн нөхцөл байдлыг муутгахгүйгээр хамгаалах"-ын тулд "өөр хувилбарын стандарт"-ыг ашиглаж болно гэж зөвшөөрсөн. 2010 онд Хууль зүйн департамтын оруулсан нэмэлт өөрчлөлтөөр бассейн, спа, жакузи нь орц, гарц болон усан сан луу орох боломжтой байх ёстой гэсэн зохицуулалт оруулсан. Гэсэн хэдий ч "хялбар хэрэглэхүйц байдлыг" лифтийг засаж, тоноглосоноор ч орц, гарцыг дэмжиж байна гэж ойлгож болно гэж үзсэн. Бусад шаардлагын тухайд бассейны хэмжээнээс хамаарч орц, гарцыг байгуулна гэдгийг Section 242-ын дагуу бий болгохыг ойлгож байна. Тухайн үйлчилгээ эрхлэгч нь энэхүү журмыг хэрэглэхдээ бассейн нь шинэ хуучин эсэхээс үл хамааран хэрэгжүүлэх боломжийг сонгож болно. Өмнө барьсан байгууламжийн хувьд бүрэн гүйцэт стандартыг дагахыг шаардахгүй (Section 242 and 1009 of the 2010 Standards)

#### **IV дүгээр бүлэг—харилцаа холбоо**

Энэ хуулийн 4 дүгээр бүлэг нь 1934 оны харилцаа холбооны тухай хуулийн зохицуулалт дээр нэмж 47 U.S.C. § 225 -ийн зохицуулалт оруулсан. Энэхүү хэсэг нь АНУ дахь харилцаа холбооны компаниуд хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчид тохирох шаардлагатай чиг үүргийг нэвтрүүлэх үүрэгтэй, ялангуяа дүлий болон муу сонсдог, эсхүл хэл ярианы хөгжлийн бэрхшээлтэй хүний тухайд зориулахыг онцолдог. Нийтийн цахилгаан бичгийн машин (TTY), дүлийн хүнд зориулсан цахилгаан харилцаа холбооны бусад машиныг (TDD) суурилуулах зохицуулалт бүхий 4 дүгээр бүлэг нь 1990 оны эхээр хүчин төгөлдөр үйлчилж эхлэсэн. 50 муж улс болон Колумби дүүрэгт хоёр-шугам бүхий сателлит гэдгээрээ нэрлэгдсэн үйлчилгээг (TRS, STS) бий болгохоор үүрэг болгосон. Өнөөдөр телекоммуникацийн дамжуулалтын тухайд өргөн нэвтрүүлгийн шугамыг ашиглан интернэтээр дамжуулан хэрэглэгчид түлхүү болоод байна. Видео дамжуулалтын үйлчилгээ нь бичгийн хэлбэрээр бичвэрийг дамжуулдаг. Бусад боломж нь хэлмэрч туслаж дохионы буюу бичгийн хэл рүү орчуулдаг. 2006 онд Холбооны харилцаа холбооны комиссын мэдээгээр видео дамжуулалтын үйлчилгээг сард дунджаар 2 сая минут хэрэглэж байгаа ажээ.

#### **V дугаар бүлэг—бусад зохицуулалт 42 U.S.C. §§ 12201–12213**

5 дугаар бүлэг техникийн бусад зохицуулалтыг агуулдаг. Тухайлбал, 504 дэх хэсгийг нэмэлт өөрчлөлт хийх, хүчингүй болгохгүй байх, цуцлахгүй байхыг тусгасан. ХБИ-ий эсрэг албадлага хэрэглэх, хүч хэрэглэхийг мөн энэ хэсэгт зохицуулсан. III-3.6000 дахь заалтаар хөгжлийн бэрхшээлтэй хүн, түүнд тусалж буй бусад этгээдээс өөрсдийн эрхийг бүрэн эдлэх, ямар нэг албадлагаас ангид байх эрхтэй болохыг зааж, хувь хүн, хуулийн этгээдээс айлгах, заналхийлэх, бусдын хэрэгт оролцохыг хориглосон байна.

#### **2008 оны нэмэлт өөрчлөлт**

Хөдөлмөрлөх тэгш боломж хангах комиссоос 1990 оны хуулийн хөдөлмөр эрхлэхэд хамаарах хөгжлийн бэрхшээлийг тодорхойлох үүрэг хүлээсэн. Энэ дагуу комиссоос

амьдралын үйл ажиллагаанд "их эсхүл үлэмж хязгаарлагдсан" хувь хүний байдлыг зохицуулсан тайлбар гаргасан. Гэтэл хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр Хөдөлмөрлөх тэгш боломж хангах комиссыг "их эсхүл үлэмж хязгаарлагдсан" гэдгийн оронд "ихээхэн хязгаарлагдсан" хэмээх илүү амьдралд нийцэх стандартаар солихыг зааварчилсан. 2008 оны 9 дүгээр сарын 25-нд нэмэлт өөрчлөлтийг оруулсан. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь "хөгжлийн бэрхшээл" гэдгийг өргөжүүлсэн. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь энэ хуульд олон хүнийг хамааруулахаар өөрчлөлт болсоныг онцолсон. Энэ хууль нь "амьдралын гол үйлдэл", тодруулбал, өөрийгөө асрах, ердийн үйлдэл гүйцэтгэх, харах, сонсох, идэх, унтах, алхах, зогсох, өргөх, тонгойх, ярих, амьсгалах, сурах, унших, төвлөрөх, бодох, харилцах, болон ажиллах үйлдэл, мөн түүнчлэн биеийн үндсэн чиг үүргийг эрхтэн хамтран гүйцэтгэх зэрэг хамаарахыг ойлгох бөгөөд зөвхөн дээр дурьдсан үйлдээр хязгаарлагдахгүй болохыг тусгажээ. Энэхүү 1999 оны Холбооны дээд шүүхийн шийдвэрээр ажилтаны үйлдлийн хязгаарлалт нь хэрэв нэмэлт арга хэмжээ авсанаар залруулж болохоор бол түүнийг хөгжлийн бэрхшээлтэй гэж үзэхгүй, ийм ажилтаны хязгаарлалтын тухайд сайжруулах арга хэмжээг үл харгалзан тодорхойлох ёстой гэжээ. Энэхүү шүүхийн хязгаарлалтын гортиг нь ийм төрлийн амьдралын гол үйлдэл хязгаарлагдмал байгаа тохиолдолд тухайн ажилтныг хөгжлийн бэрхшээлтэй гэж болно гэдгийг харгалзсан. 2008 онд Боловсрол, Хөдөлмөрийн АНУ-ын комисс нь энэхүү нэмэлт өөрчлөлтийг хязгаарлалт нь хэрэв нэмэлт арга байгаа бөгөөд холбогдох хүмүүсийг хөгжлийн бэрхшээлийн улмаас ялгаварлагдахгүй хамгаалагдах боломжтой боллоо хэмээн тэмдэглэсэн байна. Ийнхүү дээрхи нэмэлт өөрчлөлт оруулсанаар хөгжлийн бэрхшээлтэй ажилтаныг илүү өргөн хүрээнд авч үзэхээр зохицуулжээ.

## **Шүүмжлэл дагуулсан сэдэв**

### **Хөдөлмөр эрхлэлт**

Энэ хууль гарсанаар хби-ийн хөдөлмөр эрхлэлт буурна, бизнес эрхлэгчдэд санхүүгийн нэмэлт дарамт үзүүлнэ, хуулийн эрсдэлтэй үр дагавар бий болгоно, тиймээс ихэнхи ажил олгогч чимээгүйгээр энэ хуулийг дагахгүй хэмээн үзэж байв. 1991-1995 оны хооронд хб-тэй эрэгтэй хүний хөдөлмөр эрхлэлт 7.8 хувь буурсан. 2003 онд цалин, хөдөлмөр эрхлэлтийн хувьд урт хугацаан эерэг үр дагавар харагдахгүй байсан бол 2005 оноос хби-ийн хөдөлмөр эрхлэлт 45 хувьд хүрчээ.

### **"Мэргэжлийн заргалдагч"**

Энэ хууль гарсанаар хөдөлмөр эрхлэлтийн салбарын шууд нэг хэсэг болсон. Хуулийн дагуу орц, гарцыг болон хүртээмжийг бий болгох үүргээ биелүүлээгүй эсхүл ажил олгогчийн хувьд үүргээ биелүүлээгүй аан-ийг хувь хүн шүүхэд өгөх эрхтэй, гэхдээ түүнд ямар ч санхүүгийн ашиг тус шууд очихгүй. 3 дугаар бүлэгт заасан өмгөөлөгчийн хөлс нөхөн олгогдох учир хуульчдын хувьд мэргэших нэг сэдэл болсон. Шүүхээс тэмдэглэсэнээр энэ хууль гарсанаар цөөн тоогоор нэхэмжлэгчдийн тоо нэмэгдсэн, гэхдээ энэ нь хуулийн хэрэгжилтийг хангуулахад чухал ач холбогдолтой билээ. 1998 оны сүүлээр гомдлын 86 хувь ажил олгогчид мөнгөн дарамт учруулахгүйгээр шийдвэрлэжээ.

## **“Хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсролын тухай хууль” 2006, (Individual Disability Education Act Improvement Act, IDEA)<sup>41</sup>**

АНУ-д хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын асуудлуудыг зохицуулсан гол хууль нь 2006 онд шинэчлэгдэн батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсролын тухай хууль” юм. Тус хуулинд хөгжлийн бэрхшээлтэй байж болзошгүй эрсдэлтэй хүүхдийг илрүүлэх, үнэлэх, оношлох, тодорхойлох, боловсролын үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой бүхий л зохицуулалтыг тусгаснаараа АНУ-ын гол эрхзүйн баримт бичиг болж байна. Энэ хуулийн гол үзэл санаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол үнэ төлбөргүй, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөнд (ГСТ) суурилан хүртээмжтэй хувилбараар, үүнийг хэрэгжүүлэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын суурь хөтөлбөрт аль болох олон талаараа оролцоотой байлгах зарчимд суурилсан байдаг. ГСТ нь тухайн хүүхдийн онцлог, тусгай хэрэгцээ нь ердийн сургалтын хөтөлбөрөөр суралцахад ямар хүндрэл учруулж байгааг тодорхойлон, ердийн хөтөлбөрийн дагуу суралцахад шат дараатай, хэмжигдэхүйц зорилтуудыг дэвшүүлэн, хүүхдэд гарч байгаа ахиц дэвшлийг тогтмол үнэлж байхаар боловсруулагддаг байна. Энэ хуулиар хөгжлийн бэрхшээлийг дараах 13 төрөлд ангилж үзжээ.

- Оюуны бэрхшээл
- Хараа, сонсголын эмгэг \*(хоёулаа нэг дор)
- Хэл ярианы бэрхшээл
- Харааны бэрхшээл
- Сэтгэлзүйн эмгэг/ Serious emotional impairment
- Суралцах бэрхшээл
- Хөгжлийн хоцрогдол
- Хавсарсан бэрхшээл
- Тулах эрхтний бэрхшээл/Orthopaedic
- Сонсголын эмгэг
- Тархины гэмтэл
- Аутизм
- Бусад эрүүл мэндийн эмгэгүүд

### **Үнэлгээний үе шат**

Боловсролын үнэлгээ нь дараах 4 үндсэн үе шаттайгаар хэрэгжиж байна:

- Тухайн хүүхдэд тусгай хэрэгцээт боловсролын (ТХБ) үйлчилгээ шаардлагатай эсэхийг тодорхойлох
- Тохирсон ГСТ боловсруулах
- ГСТ-ний явцыг үнэлэх

---

<sup>41</sup> Г.Жаргалмаа, Д.Одгэрэл, IRIM судалгааны төв, Боловсролын их сургууль, " Тэгш хамруулан сургах үзэл санааны хүрээнд боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдийг үнэлж буй олон улсын туршлага", 2018.07.03-ны онол, практикийн бага хурлын илтгэл

- 3 жил тутам тухайн хүүхдэд үргэлжлүүлэн ТХБ-ийн үйлчилгээ шаардлагатай эсэхийг давтан үнэлдэг.

**Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө:** ГСТ нь тухайн суралцагч, түүний эцэг эх, багш нар хамтран боловсролын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн жилийн сургалтын төлөвлөгөө, зорилго зорилтыг тодорхойлсон суралцах болон заах аргагүйн гол хэрэглэгдэхүүн юм. Эхний үнэлгээнээс гарсан бүх зөвлөмжийг ГСТ-д тусгах бөгөөд тус төлөвлөгөө нь цаашид үнэлгээг үргэлжлүүлэн хийх, сургалтын зорилго зорилтыг багшид таниулах гол зааварчилгаа болдог. ГСТ-г хүүхдийн хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалсан тусгай хэрэгцээтэй уялдуулж боловсруулдаг. Ихэнх улсад ГСТ боловсруулах аргыг өргөн ашиглаж байгаа бөгөөд дор дурдсан асуудлуудыг тус төлөвлөгөөнд зайлшгүй анхаарах шаардлагатай гэж үздэг:

- Тухайн хичээлийн жилийн зорилго (хэмжигдэхүйц)
- Тухайн хүүхдийг ердийн сургалтын хөтөлбөрт хамруулах стратеги
- Хүүхдийн хөгжлийн явцын тэмдэглэл
- Эцэг эхчүүдийн оролцооны талаарх зааварчилгаа
- Эцэг эхчүүдэд мэдээлэл хүргэх заавар (тухайлбал, тайлагнах карт ашиглах гэх мэт)
- Сургалтын төлөвлөгөөг жилийн турш үнэлэх, шинэчлэх заавар

Хүснэгт Боловсролын үнэлгээний үе шат, Боловсролын тэнхим, Массачусетс муж, АНУ

<b>ШААРДЛАГАТАЙ МЭДЭЭЛЛИЙГ ЦУГЛУУЛАХ</b>		
<ul style="list-style-type: none"> <li>• Сурагч, эцэг эх болон бусад мэргэжилтнүүдтэй зөвлөлдөх</li> <li>• Хэл, соёлын ялгаатай байдлыг нь харгалзаж авч үзэх</li> <li>• Сурагчийн хувийн хэрэгтэй нь танилцах</li> <li>• Сурагчийн сурлагын түүхтэй танилцах</li> <li>• Олон талын орчинд хүүхдийг ажиглах</li> <li>• Сургалтын хөтөлбөрийн дагуу сурагчийн гүйцэтгэлийг үнэлэх</li> <li>• Сурагчийн суралцах арга барил, онцлогийг тодорхойлох</li> </ul>		
<b>СУРАГЧИЙН ДАВУУ ТАЛ БОЛОН ХЭРЭГЦЭЭГ ТОДОРХОЙЛОХ</b>		
<b>ГСТ БОЛОВСРУУЛАХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ, ҮНЭЛЭХ</b>		
<ul style="list-style-type: none"> <li>• Сургалтын нэмэлт дэмжлэг, нэмэлт сургалтын хөтөлбөрүүдийг боловсруулан ашиглах</li> <li>• Сургалтын хөтөлбөрт хүүхдийн тусгай хэрэгцээнд нийцүүлсэн зохицуулалт, тохируулгуудыг хийх</li> <li>• Багшийн хүүхэдтэй ажиллах арга, сургалтын материал, сургалтын орчинд хүүхдийн тусгай хэрэгцээнд нийцүүлэн шаардлагатай өөрчлөлтүүдийг нэвтрүүлэх</li> </ul>		
4-6 долоо хоногийн дараа дээрх арга хэмжээний үр нөлөө, сурагчид гарч байгаа өөрчлөлтөд үнэлгээ хийнэ		
Асуудал шийдэгдсэн	Асуудал хэвээр байсаар байгаа буюу хүүхдэд өөрчлөлт гараагүй	Асуудал хэвээр байсаар байгаа бөгөөд хүүхдийг хөгжлийн ямар нэг бэрхшээлтэй гэж таамаглаж байгаа

	Сургалтын өөр бусад олон талт хувилбарыг нэвтрүүлэх эсвэл сургуулиас гадуурх интервенцийг үзүүлэх	Тусгай боловсролын мэргэжлийн үнэлгээний төвд хандах
--	---	--

Source: Massachusetts Department of Education, 2001

### Оролцогч талууд

Үнэлгээний багийг бүрдүүлэх гол зарчим нь хүүхдийн амьдралд хамгийн оролцоотой, хүүхдийн талаар хамгийн сайн мэдээлэлтэй байж болох талууд болон ТХХ-ийн үнэлгээний мэргэжилтэн гэсэн үндсэн 2 төрлийн хүмүүсээс бүрдүүлнэ. Нийтлэг туршлагаар үнэлгээ хийх багт ангийн багш, тусгай боловсролын багш, сургуулийн сэтгэл зүйч, хүүхдийн эмч, эцэг эх асран хамгаалагч, шаардлагатай гэж үзвэл тухайн хүүхэд, мөн түүнчлэн харъяа орон нутгийн нийгмийн ажилтан нараас бүрдсэн баг үнэлгээг хийж гүйцэтгэж байна. Үнэлгээний үйл явц дахь талуудын оролцоог авч үзвэл:

- Хамгийн анхан шатны илрүүлэлт, албан бус үнэлгээг хийх хүн нь ангийн багш, сургуулийн эмч, сэтгэл зүйч нар байна. Хүүхэдтэй ажиллах явцад хөгжлийн ямар нэг бэрхшээл, эрсдэл байна гэж үзвэл хүүхдийн хөгжил, зан үйлд албан ёсны ажиглалт (formal observation), анхан шатны сорил үнэлгээ хийх, нэмэлт даалгавар өгч ажиллуулах зэргээр хүүхдийн талаарх мэдээллийг цуглуулж, хүүхдийн хувийн мэдээллийн хавтас үүсгэнэ.
- Багш, сэтгэл зүйч, сургуулийн эмч нар анхан шатны үнэлгээний үр дүнг хүүхдийн эцэг эхэд мэдэгдэж цааш албан ёсны мэргэжлийн үнэлгээний багт хандах эсэх зөвшөөрөл авна.
- Эцэг эхийн зөвшөөрөлтэйгөөр мэргэжлийн үнэлгээний багт хүсэлт гаргах ба хүсэлтийг хуулийн дагуу 60 хоногийн хугацаанд шийдвэрлэх үүрэгтэй.
- Мэргэжлийн үнэлгээний баг хүүхдийн хавтаст хэрэг, сургууль, гэр бүл, анги хамт олон зэрэг нийгмийн бүхий л орчны хүчин зүйлийг харгалзан, хүчин төгөлдөр, стандарчилагдсан аргачлалуудын дагуу үнэлгээг хийж эхэлнэ. Боловсролын үнэлгээг хичээлийн анги танхим, хичээлээс гадуурх үйл ажиллагаа, олон нийтийн дундахь амьдрал зэрэг хүүхдийн бүхий л орчинг харгалзаж хамгийн бодитой, үндэслэлтэй мэдээлэл цуглуулахыг зорьдог. Хүүхдийн насны онцлог, үе тэнгийнхэн, гэр бүлийн нөхцөл байдал, нийгэм орчны нөлөөлөл зэргээс шалтгаалж хүүхдийн хөгжил, төлөвшил тогтмол өөрчлөгдөж байдаг тул дээрх гадны хүчин зүйлсийг үнэлгээнд зайлшгүй харгалзах шаардлагатай гэж үздэг байна.

Үнэлгээ нь нэг удаагийн эсвэл нэг аргачлалын дагуу тодорхойлогдох үйл явц биш бөгөөд тодорхой хугацаа, хүчин чармайлт, санхүүгийн тодорхой нөөц, мэргэжлийн хүмүүсийн оролцоо шаарддаг үйл явц болох нь дээрх процессоос харагдаж байна.

### Үнэлгээний аргачлал

Бүх нийтэд боловсролыг хүртээмжтэй олгох олон улсын чиг хандлагатай холбоотойгоор үнэлгээний хандлагууд сүүлийн жилүүдэд багагүй өөрчлөгдөж байгаа. Уламжлалт үнэлгээний чиг хандлага нь тодорхой хэм хэмжээ гарган тухайн шаардлагад ТХХ хүрэх эсэх ганцхан шалгуураар үнэлдэг байсан бол шинэ хандлагаар үнэлгээ хийхдээ хүүхдийн талаарх олон талт эх сурвалжуудаас цуглуулсан мэдээлэлд үндэслэн давуу болон сул

талыг нь харгалзан үзэх болжээ. Хүүхдийн хөгжлийг үнэлэхдээ хүүхдийн нөхцөл байдалд үндэслэн байж болзошгүй гэж үзэж байгаа хөгжлийн бүхий л хүрээг хамран, олон талын эх сурвалжийн мэдээллийг ашиглан хүчин төгөлдөр, найдвартай үнэлгээний хэрэглэгдэхүүнийг ашиглан мэргэшсэн боловсон хүчний удирдлага дор төрөлх хэл дээр зохион байгуулна. (Salvia et.al., 2010)

Үнэлгээний баг хүүхдийн талаарх мэдээллийг цуглуулахдаа асуумж (questionnaire), шалгах хуудас (checklist), хөгжлийн үнэлгээний сорил (test), ажиглалт (formal observation), ярилцлага (interview) хийх, хүүхэд өөрийнхөө нөхцөл байдлыг үнэлэх (self-assessment) зэрэг тоон болон чанарын олон аргуудаас нэг удаад гурваас дээш, хүчин төгөлдөр үнэлгээний хэрэглэгдэхүүнийг ашиглахыг зөвлөдөг.

Үнэлгээнд ашиглаж буй зарим аргачлалуудаас танилцуулбал:

- **Оюун ухааны тест:**

- Векслерийн Хүүхдийн Оюун хөгжлийн түвшинг тодорхойлох тест (Wechsler Intelligence Scale for Children, WISC) Ихэнх тохиолдолд сургуулийн сэтгэл зүйчид тус аргачлалыг ашиглан үнэлгээ хийдэг бөгөөд хүүхдийн оюун ухааны хөгжлийн түвшинг өргөн хүрээнд үнэлж тогтоодог. Тус аргачлал нь хүүхдийн нас, суралцаж буй түвшинд үндэслэн хүүхдийн гүйцэтгэл, оюуны чадамжийг үнэлдэг стандарт норматив (norm-based) аргачлал.
- Stanford Binet Intelligence Scale: (Binet Simon-ий тестээс гарган авсан) Сургуулийн сэтгэл зүйч эсвэл тусгай боловсролын баг энэхүү аргачлалыг ашиглан үнэлгээ хийнэ. Векслерийн аргачлалтай мөн ижил стандартад суурилсан. Тус аргачлалыг танин мэдэхүйн буюу оюун ухааны бэрхшээлээс шалтгаалан үе тэнгийнхнээсээ сурлагын хувьд хоцрогдож байгаа сурагчдыг таних, үнэлэх зорилгоор ашиглаж байна.
- **Бүлгийн оюун ухааны тест** (Group Intelligence test): Тус аргачлал нь ерөнхий боловсролын сургуулийн ердийн ангийн нийт сурагчдын түвшинг тогтоох зорилгоор ашиглаж буй бүлгийн аргачлал. Тус аргачлалаар суралцах бэрхшээлтэй хүүхдүүдийг анхан шатны түвшинд илрүүлэх боломжтой ба хүүхдийн танин мэдэхүйн чадвар болон академик ур чадварыг таних зорилгоор ашиглаж байна.
- **Ур чадварын үнэлгээ:** Мэргэшсэн паталогич, хүүхдийн хариуцсан эмч зэрэг мэргэжлийн хүмүүс хүүхдийн биеийн ерөнхий хөдөлгөөний үйл ажиллагаа нарийн булчингийн үйл ажиллагаа, сонсох, ярих, хэлний ур чадваруудыг оношлох зорилгоор тусгай аргуудыг ашигладаг. Тус үнэлгээний үр дүн нь хүүхдийн онцлогт нийцүүлэн боловсролын орчинд байх шаардлагатай тохируулгуудыг ГСТ-г төлөвлөхөд чухал ач холбогдолтой.
- **Амьдралын түүх судлал:** Тус үнэлгээг ярилцлагын аргаар хийж гүйцэтгэх бөгөөд ангийн багш, эцэг эх, сэтгэл зүйч, хүүхдийн эмч зэрэг хүүхэдтэй ойр ажиллах мэргэжилтнүүд хариуцан зохион байгуулдаг. Хүүхдийн давуу болон сул тал, хөгжлийн ямар нэг хоцрогдол байсан эсэх, хүүхдийн хөгжилд нөлөөлөхүйц өмнөх туршлага, эрүүл мэндийн түүх, хөгжлийн milestone, генетикийн хүчин зүйл, гэр бүл найз нөхдийн харилцаа, хобби, зан авирын асуудлууд, сурлагын амжилтууд зэрэг хүүхдийн өнгөрсөн амьдралтай холбоотой бүхий л мэдээлэлд үнэлгээ хийдэг.
- **Ажиглалт** (Formal Observation Records): Тухайн хүүхэдтэй ажиллаж буй хэн ч хүүхдийн сурлагын үзүүлэлт болон зан авирын онцлогийн талаарх ажиглалтын үр



дүнгээ тэмдэглүүлж болно. Нэг болон түүнээс дээш сарын ажиглалтын үр дүн нь хүүхдийн нөхцөл байдлын талаарх урьдач таамаг, ерөнхий дүр зургийг багшид олгох боломжтой. Ялангуяа ангийн багш нар нь тухайн насны хүүхдүүдийн хөгжил, гүйцэтгэлийн талаар хамгийн сайн мэдээлэлтэй байдаг тул хөгжлийн хувьд ямар нэг хоцрогдол, сурлагын бэрхшээлтэй байгаа хүүхдийг таниж илрүүлэх хамгийн боломжтой тал гэж үздэг. Ингэхдээ багшийн өгсөн даалгаврыг хэрхэн гүйцэтгэж байгаа байдал, үзүүлж байгаа хариу үйлдэл, гүйцэтгэл зэрэг тодорхой ажиглагдсан үр дүнгүүдийг баримтжуулан тэмдэглэж явна.

Дээрх аргачлалуудад үндэслэн үнэлгээний баг хүүхдийн бэрхшээл, тусгай хэрэгцээг тодорхойлвол ганцаарчилсан хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж эхэлнэ. Эцэг эх, асран хамгаалагч нь ГСТ хүлээн зөвшөөрвөл хүүхэд өөрийн тусгай хэрэгцээнд нийцсэн боловсролын үйлчилгээг хүртэж эхэлдэг байна. (J. Ysseldyke, 2010).

**Дүгнэлт:** Энэ хууль гарсанаар хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн харилцаанд оролцоход ялгаварлан гадуурхахгүй байх нөхцлийг тодорхойлон заасан хувьдаа дэлхийн бусад улсад ихээхэн нөлөө үзүүлжээ. Монгол Улсын хувьд авч үзвэл зохих туршлагын тухайд Америкийн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн зохицуулалтаас **1./15-аас** дээш ажилтантай аж ахуйн нэгжүүд нь тухайн хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулж ажил гүйцэтгэх нэмэлт тоноглолоор хангах үүрэг хүлээх хэдий ч ажил олгогчид энэ нь ихээхэн хүндрэлтэй бий болгох, эсхүл маш их зардлаар бий болгохоор тусгай тоноглол хэрэгтэй бол түүнийг ажил олгогч заавал хангах үүрэг хүлээхгүй байх хувилбарыг зохицуулсан байна. **2./**Нийтийн байгууламжинд нэвтрэх стандартыг энэ хууль батлагдахаас өмнө баригдсан барилга байгууламжинд мөн үйлчлэхээр заасан. Өөрөөр хэлбэл барилга байгууламж "хялбар хэрэглэхүйц" буюу "их хэмжээний хүндрэл, бэрхшээл эсхүл зардал гаргалгүйгээр хялбар байдлаар гүйцэтгэх" боломжтой бол өмнө баригдсан барилга, байгууламж мөн хөгжлийн бэрхшээлтэй хүний нэвтрэх орц, гарц, хүртээмжийг бий болгох үүрэг хүлээнэ. Ингэхдэ бүх барилгыг өөрчлөх боломжтой эсэхийг бодит байдал дээр авч үзэхийн тулд "хялбар хэрэглэхүйц байдал" гэдэг нь түүнийг засварлахад гарах зардал ба тухайн бизнес эрхлэгч эсхүл өмчлөгчийн амин зуулга хоёрыг харьцуулан үзнэ хэмээн уян хатан байдлаар зохицуулсан нь практик хэрэглээний хувьд ач холбогдолтой байна. **3./** Харилцаа холбооны олон янз хэлбэрийг өргөн ашиглахаар заасан нь хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах, дамжуулах, хөгжих боломжийг олгоход шаардлагатай зохицуулалт ажээ. Америкийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсролын тухай хуулиас **4./** Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үр дүнтэйгээр ердийн сургуульд тэгш хамруулан сургахад олон талын оролцоо, хичээл зүтгэл шаардлагатай бөгөөд хүүхдийг боловсролд хамруулах процесс нь бүхэлдээ сайтар төлөвлөгдсөн, зохион байгуулттай байж мөн түүндээ зарцуулагдах тодорхой төсөвтэй байх ёстой болохыг дээрх орнуудын туршлагаас харж болохоор байна. Үүний тулд хамгийн суурь нь нэгдмэлээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн болон боловсролын хэрэгцээ шаардлагыг нь багш, эцэг, эх суралцагчид хамтран тусгайлан үнэлгээний загвараар тодорхойлж, түүнд нийцсэн сургалтын хөтөлбөрийг боловсруулан шаардлагатай туслах хэрэгсэл, дэмжлэгээр хангах явдал байна.

#### **4.2. Болгар улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд татан оролцуулах тухай хууль**

Болгар улс нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд татан оролцуулах тухай хуулийг 2004 онд баталж, 2005 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж байна. Энэхүү хууль нь 6 бүлэг, 55 зүйлтэй, мөн нэмэлт зүйлтэй.

## **1 дүгээр бүлэг- Нийтлэг үндэслэл (1-4 дүгээр зүйл)**

Энэ хуулийн 2 дугаар зүйлд хуулийн зорилтыг дараахь байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэгш эрх;
2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгмийн харилцаанд нэгдэн оролцох, эрхээ эдлэх;
3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдгээрийн гэр бүлд дэмжлэг үзүүлэх;
4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөдөлмөрийн орчинд нэгтгэн оролцуулах орчин нөхцөл, баталгааг бүрдүүлж өгөхөд оршино. Энэ хуулийн 4 дүгээр зүйлд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг оролцох нийгмийн харилцааг дараахь 7 салбараар тодорхойлжээ.

1. Эрүүл мэндийн болон нийгэмшүүлэх сэргээн засалт;
2. Боловсрол, техник мэргэжлийн сургалт;
3. Хөдөлмөр эрхлэлт;
4. Ахуйн болон архитектурын саадгүй хүртээмжтэй орчин;
5. Нийгмийн үйлчилгээ;
6. Нийгэм-эдийн засгийн халамж, хамгаалалт;
7. Хүртээмжтэй мэдээлэл

## **2 дугаар бүлэг- Удирдах байгууллага (5-9 дүгээр зүйл)**

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд нэгтгэн оролцуулахтай холбоотой төрийн бодлогыг Сайд нарын зөвлөл тодорхойлно. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд нэгтгэн оролцуулах чиглэлээр хамтарч бодлого боловсруулж, хэрэгжүүлэх үүрэг бүхий Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд нэгтгэн оролцуулах Үндэсний зөвлөлийг Сайд нарын зөвлөлийн дэргэд байгуулна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой эрхзүйн актыг Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд нэгтгэн оролцуулах Үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлж, урьдчилсан санал авсны дараагаар батална. Сайд нарын зөвлөл нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд нэгтгэн оролцуулах Үндэсний зөвлөлийн Үйл ажиллагааны журмыг баталж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөх байгууллагуудын үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийг тодорхойлно. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал эрхэлсэн газар нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд нэгтгэн оролцуулах төрийн бодлогыг хэрэгжүүлэх зорилготой байна. Тус газар нь Софи хотод төвтэй, төсөвт хөрөнгөтэй хуулийн этгээд, хоёрдугаар түвшний захиран зарцуулах эрхтэй нэгж байх бөгөөд Хөдөлмөр, нийгмийн бодлогын сайдын гүйцэтгэгч агентлагийн статустай байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал эрхэлсэн газрын үйл ажиллагаа, бүтэц, орон тоог Хөдөлмөр, нийгмийн бодлогын сайдын саналыг үндэслэн Сайд нарын зөвлөлөөс батласан Үйл ажиллагааны журмаар зохицуулна.

8 дугаар зүйлд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал эрхэлсэн газрын үүргийг зааснаар нь

1. Туслах хэрэгсэл, хэрэглэгдэхүүн, байгууламжийн үйлдвэрлэл, импорт, борлуулалт, засвар үйлчилгээний стандарт, шалгуурыг батлах, туслах хэрэгслийн хангалт батласан шалгуур, стандартад нийцэж буй эсэхэд хяналт тавих;
2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэргэшсэн үйлдвэр, хоршоодын бүртгэлийг хөтлөх;
3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой хуулийн төсөл боловсруулахад оролцох, санал оруулах;

4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бизнес санаачилга, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тустай бизнесийн санаачилгыг хөхиүлэн дэмжих хөтөлбөр боловсруулж, төслүүдийг санхүүжүүлэх;
5. Сайд нарын зөвлөлөөс даалгасан нэмэлт ажил үүргийг гүйцэтгэх.

9 дүгээр зүйлд мэдээллийн сан бүрдүүлэх асуудлыг дэлгэрэнгүй зохицуулжээ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал эрхэлсэн газар нь байнгын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх мэдээллийн сан бүрдүүлнэ. Энэхүү мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсрол, эрүүл мэндийн болон нийгмийн нөхөн заслын зайлшгүй шаардлагатай холбоотой төлөвлөлтийн үйл ажиллагаанд зориулан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоог гаргах, тэдгээрийн нийгэм-эдийн засгийн байдалд дүн шинжилгээ хийхэд ашиглана. Эмч нарын үндэсний мэргэжилтнүүдийн зөвлөл, эмч нарын бүсийн мэргэжилтнүүдийн зөвлөл, Үндэсний нийгмийн хамгааллын хүрээлэн, Үндэсний статистикийн хүрээлэн, Эрүүл мэндийн мэдээллийн Үндэсний төв, Хүүхэд хамгаалах байгууллага, хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой чиглэлээр ажилладаг бусад байгууллагууд тус энэ хуульд заасан мэдээллийн санг бүрдүүлэхэд шаардлагатай мэдээллийг гарган өгнө. Хувь хүний мэдээллийг хамгаалах тухай хуулийн дагуу дээрх санд мэдээлэл нь орсон хувь хүн өөрийн мэдээллийг ил болгохыг зөвшөөрөөгүй тохиолдолд хувь хүний хувийн мэдээллийг ил болгохыг хориглоно. Мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх журмыг энэхүү хуулийг хэрэгжүүлэх тухай журмаар зохицуулна.

### **3 дугаар бүлэг - хөгжлийн бэрхшээл ба нийгмийн харилцаанд оролцогчдын чадварын үнэлгээ (10-13 дугаар зүйл)**

Хөгжлийн бэрхшээлийг эмнэлгийн магадлагаа болон нийгэмшлийн үнэлгээгээр тогтоон үнэлнэ. Эмнэлгийн магадлагааг үндэслэн нийгэмшлийн үнэлгээг хийх ба нийгэмшлийн үнэлгээгээр дараахь асуудлыг тодорхойлно. Үүнд:

1. Нөхөн засал хийх зайлшгүй шаардлага;
2. Мэргэжлийн түвшинд гүйцэтгэх чадвар;
3. Нийгмийн харилцаанд нэгдэн оролцох чадвар.

Нийгэмшлийн үнэлгээг:

1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний;
2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эцэг эх (өргөж авсан эцэг эх), асран хамгаалагч, итгэмжлэгдсэн төлөөлөгчийн;
3. Хүүхэд хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн гэр бүл, хамаатан садан, ойрын хамаатан эсхүл өргөж авсан гэр бүлийн

хүсэлтээр хийнэ. Нийгэмшлийн үнэлгээнд тулгуурлан нийгмийн харилцаанд нэгтгэн оролцуулах тусгайлсан төлөвлөгөөг боловсруулна.

Нийгэмшлийн үнэлгээнд дараахь асуудлыг багтаана. Үүнд:

1. Нөхцөл байдлын үнэлгээ;
2. Нийгмийн харилцаанд хамруулахад шаардлагатай арга хэмжээний зөвлөмж;
3. Тэтгэмж өгөх шаардлагатай нь тогтоогдсон тохиолдолд хууль заасан нийгмийн харилцаанд нэгтгэн оролцуулахад сар бүр тэтгэмж олгохыг дэмжсэн санал.

Дээр дурьдсан нийгэмшлийн үнэлгээг Нийгмийн тусламж үйлчилгээний газрын Нийгмийн тусламж үйлчилгээний захиргааны зөвлөлдөх хороо гүйцэтгэнэ. Энэхүү хорооны бүрэлдэхүүнийг Нийгмийн тусламж үйлчилгээний захиргааны даргын тушаалаар батлах ба бүрэлдэхүүнд дараах этгээд багтана. Үүнд:

1. Нийгмийн тусламж үйлчилгээний захиргааны даргын томилсон Нийгмийн тусламж үйлчилгээний газрын Нийгмийн тусламж үйлчилгээний захиргааны мэргэжилтнүүд;
2. Хотын дарга нарын томилсон хотын захиргааны төлөөллүүд;
3. Үндэсний хөдөлмөр эрхлэлтийн газрын Хөдөлмөрийн газрын захиргааны даргын томилсон Хөдөлмөрийн газрын захиргааны мэргэжилтэн;
4. Шаардлагатай тохмолдолд бусад мэргэжилтнүүдийг нэмж оролцуулна.

Нийгмийн тусламж үйлчилгээний захиргааны зөвлөлдөх хорооны үйл ажиллагаа, ажиллах зарчим, нийгэмшлийн үнэлгээний хүчин төгөлдөр үйлчлэх хугацааг энэхүү хуулийг хэрэгжүүлэх тухай журмаар тогтооно.

#### **4 дүгээр бүлэг - нэгтгэн оролцуулах салбарууд (14-48 дугаар зүйл)**

Энэ бүлэг нь дотроо таван хэсэгтэй: Хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх, сэргээн засах, Боловсрол ба мэргэжлийн сургалт, Хөдөлмөр эрхлэлт ба ажлын байр, Амьдрах болон архитектурын саадгүй хүртээмжтэй орчны нөхцөлийг тогтоох, Нийгэм-эдийн засгийн хамгаалал.

**Нэгдүгээр хэсэг- Хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх, сэргээн засах салбарт** Сайд нарын зөвлөл нь хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх нэн тэргүүний зорилго, арга хэмжээ, урьдчилан сэргийлэх арга хэрэгслүүдийг тодорхойлсон урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүдийг батална. Нутгийн өөрөө удирдах байгууллагууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг төлөөлөх үндэсний байгууллагууд, ажил олгогчдыг төлөөлөх үндэсний байгууллагууд болон хөдөлмөр эрхлэгчдийг төлөөлөх үндэсний байгууллагууд нь дараах замаар хөгжлийн бэрхшээлээс сэргийлэхэд туслалцаа үзүүлнэ. Үүнд:

1. Амьдралын хэв маяг, амьдрах орчинтой холбоотой эрсдэлийн хүчин зүйлсийг хязгаарлах эрүүл мэндийн болон экологийн боловсрол олгох;
2. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг хийх;
3. Ажлын байран дээр хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах.

Эмнэлгийн сэргээн засал гэдэг нь Эрүүл мэндийн байгууллагын тухай болон Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан олон талын мэргэшил бүхий багийн хэрэгжүүлэх эрүүл мэндийн үйл ажиллагаа бөгөөд үүнд доорхыг хамруулна. Тухайлбал:

1. Эмийн эмчилгээ;
2. Физик эмчилгээ;
3. Хэл яриа, хараа засал;
4. Кинезитерапи (булчингийн тогтолцооны эмчилгээ);
5. Хөдөлгөөн засал (эрготерапи);
6. Сэтгэл засал;
7. Хөдөлмөр засал;
8. Туслах хэрэгсэл, хэрэглэгдэхүүний жор бичих.

Эмнэлгийн үйл явцад зайлшгүй шаардлагатай тохиолдолд хөгжлийн байнгын бэрхшээлтэй иргэдийн гэр бүл эмнэлгийн засал, эмчилгээнд оролцоно. Нийгэмшлийн сэргээн засал гэдэгт харах, сонсох, ярих, хөдлөх чадварыг сэргээн засах замаар бие даан

амьдрах чадвартай болгох, сэтгэл зүйн туслалцаа, нийгмийн үйлчилгээ үзүүлэх болон бусад үйл ажиллагааг хамруулна.

**Хоёрдугаар хэсэг- Боловсрол ба мэргэжлийн сургалтын салбарт** хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хүмүүжил, боловсролын цогц үнэлгээг Боловсрол, шинжлэх ухааны яамны бүсийн зааварлагчдаас бүрдсэн баг тогтооно. Боловсрол, шинжлэх ухааны яамны дор хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн нэгдсэн боловсролыг дэмжих нэгдсэн боловсролын нөөцийн төвүүдийг байгуулна. Боловсрол, шинжлэх ухааны яам нь доорхыг ханган ажиллана. Үүнд:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг зохих насанд нь Бүх нийтийн боловсролын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 1 дүгээр хэсгийн 1-10-т заасан сургууль болон мөн хуулийн 18 дугаар зүйлд заасан сургуулийн өмнөх боловсролд хамруулах;
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нэгдсэн боловсролыг дэмжсэн орчин нөхцөлийг бүрдүүлэх;
3. Хараагүй, сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдийг сонсгол-яриа, хэл-яриа, сэтгэл заслын сэргээн засах эмчилгээнд эрт хамруулах;
4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд дунд боловсролын хөтөлбөрийг дүүргэтэл эсхүл 18 нас хүртэл нь сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн, орчин үеийн технологи, техник хэрэгслээр хангах;
5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг мэргэжлийн сургалтад хамруулах.

Боловсрол, шинжлэх ухааны яам нь боловсролын ердийн орчинд нэгдэн орох чадваргүй, боловсролын тусгай хэрэгцээ бүхий хүүхдүүдийг сурч боловсрох боломж, нөхцөлөөр хангана. Хөгжлийн бэрхшээл 16 наснаас нь хойш илэрсэн иргэд ерөнхий болон мэргэжлийн боловсрол, насанд хүрэгсдийн боловсрол болон үндсэн ур чадвар олгох тусгай хөтөлбөрийн анхны сэргээн заслын зэрэг нэмэлт хөтөлбөрүүдэд үнэ төлбөргүй хамрагдах эрхтэй байна.

Ахлах сургуулиуд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсрол, үнэлгээний үйл явцад дэмжлэг болох үүднээс тэдгээрийг дэмжсэн орчин, тусгай байгууламж, сургалтын тохиромжтой материал, нэмэлт багш нарыг бүрдүүлсэн байх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй ажиллах мэргэжилтнүүдийг сургах нөхцлийг хангана. Дараах этгээд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд мэргэжлийн боловсрол олгоно. Үүнд:

1. Үндэсний хөдөлмөр эхлэлтийн газар;
2. Ажил олгогч нар болон томилогч байгууллагууд;
3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдүүд болон Худалдааны тухай хуулийн заалтын дагуу бүртгүүлсэн хувь хүмүүс;
4. Мэргэшсэн үйлдвэр, хоршоод.

**Гуравдугаар хэсэг - Хөдөлмөр эрхлэлт ба ажлын байрны салбарт** тусгайлсан, нэгдсэн орчинд хөгжлийн бэрхшээлтэй иргэдээр ажил, хөдөлмөр эрхлүүлнэ. Хөдөлмөр, нийгмийн бодлогын яам, Үндэсний хөдөлмөр эрхлэлтийн газар нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөдөлмөрийн зах зээлд ижил тэгш оролцох боломжоор хангасан хөдөлмөр эрхлэлтийг хөхиүлэн дэмжих үндэсний хөтөлбөр, арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлнэ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангаж, хөдөлмөр эрхлүүлж буй ажил олгогч нарыг дэмжих хөрөнгийг баталсан хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд олгоно. Ажил олгогч, ялангуяа томилогч этгээд нь ажилтан томилогдсон даруйд, эсхүл томилогдсоноос хойш хөгжлийн бэрхшээлтэй болсон бөгөөд ажлын байр тохижуулахад шаардагдах зардал нь хэт өндөр биш, ажил олгогчид их хэмжээний дарамт учруулахуйц бус бол ажлын байрыг

хөгжлийн бэрхшээлтэй иргэний хэрэгцээ шаардлагад нийцүүлэн тохируулах үүрэгтэй байна. Ажил олгогч, ялангуяа томилогч этгээд нь:

1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ажлын байрандаа саадгүй нэвтрэх боломж бүрдүүлж өгөх;
2. Ажлын байрыг нь хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлогт тохируулж өгөх;
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний ажлын байранд тоног төхөөрөмж байрлуулж өгөх зорилгоор тэтгэлэг хүсч төслөө Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал эрхэлсэн газарт хүргүүлж болно. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал эрхэлсэн газар нь жил бүр ажил олгогчдын ирүүлсэн төслийг санхүүжүүлэхэд зарцуулах хөгжлийн байнгын бэрхшээлтэй иргэнийг 3 жилээс доошгүй хугацаагаар ажлын байраар хангана. Хэрэв ажлын байраар хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хангаагүй бол хүлээн авсан мөнгөн дүнг хүүгийн хамт буцааж төлөх үүрэг хүлээнэ.

Ажил олгогч нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн заалт ёсоор аливаа хөнгөлөлт урамшуулал эдлээгүй бол дараах хөнгөлөлт урамшууллыг эдэлнэ. Үүнд:

1. Энэхүү хуулийг хэрэгжүүлэх тухай журамд заасны дагуу ажил олгогчийн зүгээс хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудын нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал, тэтгэвэрийн нэмэлт даатгалд төлсөн шимтгэлийн 30 хувийг төсвөөс санхүүжүүлнэ.
2. Энэ хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зорилгоор зарцуулсан хөрөнгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу дансанд бүртгэх ба татварыг Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуулийн нийтлэг үндэслэлийн дагуу тооцно. Ажил олгогч нь хөгжлийн байнгын бэрхшээлтэй иргэдэд Хөдөлмөрийн тухай хуулийн 315 дугаар зүйлийн 1 дүгээр хэсэгт заасан ерөнхий тооны ажлын байрны  $\frac{1}{2}$ -ээс багагүй тооны ажлын байр гаргаж өгнө. Ажил олгогч нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан зориулалтын ажлын байрны талаар Үндэсний хөдөлмөр эрхлэлтийн газрын харъяа нэгжид мэдэгдэж, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан сул чөлөөтэй ажлын байрны зарыг 14 хоногийн дотор зарлах үүрэгтэй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэргэшсэн үйлдвэр, хоршоод гэж дараах шаардлагыг хангасан үйлдвэр, хоршоодыг ойлгоно. Үүнд:

1. Худалдааны тухай хууль эсхүл Хоршооны тухай хуулийн дагуу бүртгүүлсэн;
2. Бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг эсхүл үйлчилгээ үзүүлдэг;
3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эзлэх хувь хэмжээ дараах байдалтай байна. Үүнд:
  - a. Хараагүй, харааны бэрхшээлтэй иргэдийн мэргэшсэн үйлдвэр, хоршоодын нийт ажилтны 20-оос доошгүй хувь;
  - b. Дүлий, сонсголын бэрхшээлтэй иргэдийн мэргэшсэн үйлдвэр, хоршоодын нийт ажилтны 30-аас доошгүй хувь;
  - c. Хөгжлийн бусад бэрхшээлтэй иргэдийн мэргэшсэн үйлдвэр, хоршоодын нийт ажилтны 50-аас доошгүй хувь.

4. Энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасан бүртгэлд хамрагдсан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэргэшсэн үйлдвэр, хоршоодыг энэхүү хуулийг хэрэгжүүлэх тухай журамд заасан зориулалтын төсөл, хөтөлбөрүүдээр дамжуулан Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал эрхэлсэн газраас санхүүжүүлнэ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэргэшсэн үйлдвэр, хоршоод нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал эрхэлсэн газрын бүртгэлд бүртгүүлнэ. Сайд нарын зөвлөл нь

хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэргэшсэн үйлдвэр, хоршоодын үйлдвэрлэх бараа бүтээгдэхүүн, үзүүлэх үйлчилгээг төрийн худалдан авах ажиллагааны тухай хуульд заасан журмын дагуу тодорхойлно.

**Дөрөвдүгээр хэсэг-Амьдрах болон архитектурын саадгүй хүртээмжтэй орчны нөхцөлийг тогтоох салбарт** төрийн байгууллагууд, нутгийн өөрөө удирдах байгууллагууд нь Газар нутгийн зохион байгуулалтын тухай хуульд тодорхойлсон нөхцөл, шаардлагын дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг багтаасан хүн амд зориулан хотын байгууламжуудыг бүтээн байгуулж, барих ажлыг зохион байгуулна. Бүсийн хөгжил, нийтийн аж ахуйн ажил үйлчилгээ хариуцсан яам нь доорх асуудлаар эрхзүйн акт, дүрэм журам, норм, стандартыг боловсруулах замаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчин, архитектурын саадгүй хүртээмжтэй орчныг бий болгох нөхцөл шаардлагыг тогтооно. Үүнд:

1. хотын газар нутаг, түүний элементүүд;
2. барилга, байгууламж, тэдгээрийн элементүүд;
3. одоогийн барилга байгууламж, хүрээлэн буй орчныг олон нийтийн хэрэгцээнд нийцүүлэн тохируулах элементүүд.

Тээвэр, харилцаа холбооны яам нь доорх асуудлаар эрхзүйн акт, стандарт боловсруулах замаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тээврийн үйлчилгээг хүртээмжтэй болгох нөхцөл шаардлагыг тогтооно. Үүнд:

1. Нийтийн хэрэгцээнд саадгүй, хүртээмжтэй тээврийн хэрэгслээр үйлчлэх;
2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийтийн тээврээр саадгүй зорчуулах зорилгоор нийтийн амьдрал, нийтийн тээвэрт техникийн байгууламжуудыг шинээр нэвтрүүлэх;
3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн жолоодож буй эсхүл хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн тээвэрлэлт, зогсолт, зогсоолын тусгай нөхцөл шаардлагыг хангах;
4. Хөтөч нохойтой яваа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тээвэрлэх нийтийн тээврийн хэрэгслийн саадгүй орц, гарцыг хангах.

Хөдөлмөр, нийгмийн бодлогын сайд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан туслах хэрэгсэл, байгууламж, хэрэглэгдэхүүний үйлдвэрлэл, импорт, борлуулалт, засвар үйлчилгээний нөхцөл шаардлагыг тогтоосон тушаал батална. Туслах хэрэгсэл, тэдгээрийг үйлдвэрлэх болон засч сэлбэх материалыг импортын болон нэмүү өртгийн татвараас чөлөөлнө. Хөдөлмөр, нийгмийн бодлогын сайд жил бүр тушаал гаргаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан туслах хэрэгсэл, байгууламж, хэрэглэгдэхүүний жагсаалтыг батална. Залуучууд, спортын яам болон Боловсрол, шинжлэх ухааны яам нь хотын захиргаа, биеийн тамирын клубууд болон спортын холбоодтой хамтран дараах байдлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд нэгтгэн оруулах нөхцөлийг хангана. Үүнд:

1. Биеийн тамирын талбай, төхөөрөмж хэрэгслүүдийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ашиглуулах зорилгоор байрлуулж, тохируулах;
2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан спортын арга хэмжээг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах;
3. Биеийн тамир, спортын арга хэмжээнд оролцох хөгжлийн бэрхшээлтэй тамирчдад туслалцаа үзүүлэх;
4. Хүүхдүүдэд сургуулиас гадуурх үйл ажиллагаанд нь туслалцаа үзүүлэх.

Соёлын яам нь хотын захиргаатай хамтран дараах байдлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд нэгтгэн оруулах нөхцөлийг хангана. Үүнд:

1. Үйлчилгээ, замын чиглэл, архитектур-тээврийн болон соёл, амралтын зориулалттай нийтийн талбайд байрлах бусад байгууламжуудын талаар тусгайлсан мэдээллээр хангах;
2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бүтээлч үйл ажиллагааг хөхиүлэн дэмжих, авъяас чадварыг хөгжүүлэх.

Хотын захиргаад нь өөрийн эрх мэдлийн хүрээнд доорхыг хангана. Үүнд:

1. Цэцэрлэг, сургуулиудад саадгүй хүртээмжтэй архитектурын орчныг бүтээн байгуулах;
2. Одоогийн тээврийн хэрэгслийг нийтийн тээвэрт тохируулан өөрчлөх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тээвэрлэх техникийн хувьд өөрчлөн тохируулсан тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх зэргээр нийтийн тээврийг хүртээмжтэй саадгүй болгох;
3. Хөтөч нохойгоор замчлуулсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг олон нийтийн газар саадгүй нэвтрүүлэх;
4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тээврийн тусгай үйлчилгээ үзүүлэх;
5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд оруулахад шаардлагатай материаллаг нөхцөл, хэрэгслээр хангах.

Болгарын үндэсний телевиз, Болгарын үндэсний радио, Болгарын шуудангийн газар нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлаар мэдээллийг хүргэнэ. Эдгээр байгууллагууд хөтөлбөртөө хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай хөтөлбөрүүдийг оруулна.

**Тавдугаар хэсэг- Нийгэм-эдийн засгийн хамгаалал салбарт** мэргэшсэн үйлдвэр, хөдөлмөр-эрүүл мэндийн байгууллагатай хөдөлмөрийн гэрээ байгуулсан ажилтнууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хоршоо, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг төлөөлөх үндэсний байгууллагууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөх үндэсний байгууллагуудын гишүүдийн нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал, тэтгэвэрийн нэмэлт даатгалын шимтгэлд ажил олгогчийн зүгээс төлсөн 30 хувийг санхүүжүүлэх хөрөнгийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөрөнгө оруулалт, сэргээн засал, нийгмийн харилцаанд нэгдэн оролцох үйл ажиллагаанд зарцуулна. Хөгжлийн байнгын бэрхшээлтэй иргэд хөгжлийн бэрхшээлийн төрөл, зэрэг, хувийн хэрэгцээ шаардлагаас хамаарч нийгмийн харилцаанд нэгдэн ороход зориулсан сар бүрийн тэтгэмж авах эрхтэй байна. Дээрхи тэтгэмж нь хувь хүний орлогод нэмэлт байдлаар, ялгаатай олгогдох санхүүгийн хэрэгсэл байх ба дараах нэмэлт зардлыг хамарна. Үүнд:

1. Тээврийн үйлчилгээ;
2. Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээ;
3. Боловсрол;
4. Рашаан сувилал, сэргээн заслын үйлчилгээ;
5. Эрүүл хооллолтын дэглэм, эм тариа;
6. Хүртээмжтэй мэдээлэл;
7. Бусад үндсэн хэрэгцээг хангах.

Сар бүр олгох тэтгэмжийн нийт дүн нь 2 дахь хэсэгт заасан хэрэгслийн нийт дүн болно. Тэтгэмжийг энэ хуулийн комиссийн саналыг үндэслэн нийгэмшлийн үнэлгээнд тулгуурлан олгоно. Нийгэмшлийн үнэлгээнд тусгасан бүхий л нөхцөл байдлыг шалган судласны дараа Нийгмийн тусламж үйлчилгээний захиргааны дарга эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөл болох этгээд нь тэтгэмж олгохыг зөвшөөрсөн тушаал гаргана. Нийгмийн харилцаанд нэгдэн ороход зориулсан тэтгэмж олгохоос татгалзсан шалтгааныг заавал тайлбарлана. Энэхүү



заасан шийдвэрийг Захиргааны хэргийг хянан шийдвэрлэх тухай хуулийн нөхцөл, шаардлагын дагуу Нийгмийн тусламж үйлчилгээний бүсийн захиргааны даргад хандан давж заалдаж болно. Төрийн эсхүл хотын захиргаанаас бүтэн тусламж авч эрүүл мэндийн байгууллага, мэргэшсэн байгууллагад нэг сараас дээш хугацаагаар байгаа хөгжлийн байнгын бэрхшээлтэй иргэд нь дээр дурдсан байгууллагуудад байрлаж байх хугацаандаа тэтгэмжийг авах эрхгүй болно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд 18 нас хүртэл болон дунд сургуулиа төгсөх хүртэл буюу 20 нас хүрэхээс өмнө хүртэл олгох амьжиргааны баталжгаажих доод түвшний 70 хувьтай тэнцэх хэмжээний сар тутмын тэтгэмжийг хууль ёсны төлөөлөгч этгээд авах эрхтэй байна.

Хөгжлийн байнгын бэрхшээлтэй иргэд зайлшгүй шаардлагаасаа хамаарч зохих тэтгэмж авч, дараах хөнгөлөлтийг эдлэх эрхтэй байна. Үүнд:

1. Хувийн тээврийн хэрэгсэл худалдан авах, хэрэгцээндээ нийцүүлэн тохируулах, зогсоолын талбайгаа тохируулан өөрчлөх;
2. Хувийн тээврийн хэрэгсэл импортлох;
3. Гэрээ дахин засварлах;
4. Харааны бэрхшээлтэй, хөдөлгөөний бэрхшээлтэй иргэд хажуудаа хүнтэй явах, сонсголын бэрхшээлтэй иргэд дохионы хэлмэрчтэй байх.

Хөгжлийн байнгын бэрхшээлтэй иргэдийн импортлох Болгар ливээр илэрхийлэгдэх үнэ бүхий хувийн тээврийн хэрэгслийн хүчин чадал, мотор нь Сайд нарын зөвлөлөөс тогтоосон тодорхой үзүүлэлтэд нийцсэн байх ба тэдгээр нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн дагуу нэмэгдсэн өртгийн албан татвар, гаалийн татвараас чөлөөлөгдөнө. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд өөрийн хэрэгцээ шаардлагын дагуу зохих хэмжээний тэтгэмж авах, техникийн туслах хэрэгсэл, хөгжлийн бэрхшээлийг хөнгөвчлөх хэрэглэгдэхүүн, төхөөрөмжөө худалдан авах, засуулахад Хөдөлмөр, нийгмийн бодлогын сайдын жил бүр батлан гаргадаг жагсаалтын дагуу хөнгөлөлт эдлэнэ. Зохих хэмжээний тэтгэмж, хөнгөлөлт, тэдгээрийг олгох нөхцөл, шаардлагыг энэхүү хуулийг хэрэгжүүлэх тухай журмаар тодорхойлно. Тэтгэмж, тусламжаас татвар, шимтгэл авахгүй. Харин хууль бусаар авсан их хэмжээний тэтгэмж, тусламжийг төрийн өмчийг хураан авах журмын дагуу хүүгийн хамт эргүүлэн төлүүлнэ. Улмаар уг этгээдийн тэтгэмж, тусламж авах эрхийг нэг жилийн хугацаатай түдгэлзүүлнэ. Хөгжлийн байнгын бэрхшээлтэй хүнийг асарч байсан, нийгмийн баталгаагүй болсон этгээдэд Нийгмийн халамжийн хуулийн нөхцөл, шаардлагын дагуу тэтгэвэрт гарах үед нь даатгуулаагүй хугацааг нөхөн тооцно. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу тухайн хугацааны эрүүл мэндийн даатгалыг төлөгдсөнд тооцно. Хөгжлийн байнгын бэрхшээлтэй оюутнууд, хөгжлийн байнгын бэрхшээлтэй эцэг, эхтэй хүүхдүүдэд Ерөнхий боловсролын тухай хууль болон Дээд боловсролын тухай хуулийн дагуу тэтгэлэг болон бусад хөнгөлөлт олгоно. Хотын өмчийн тухай хуулийн дагуу хотын захиргаад нь хөгжлийн байнгын бэрхшээлтэй иргэдийг хотын орон сууцжуулалтын сангаас орон байраар хангана.

## **5 дугаар бүлэг - Санхүүжилт**

Энэ хуулийн хүрээнд хийгдэх санхүүжилтийг дараах эх үүсвэрээс хийнэ. Үүнд:

1. Улсын төсөв;
2. Хотын төсөв;
3. Үндэсний болон олон улсын хөтөлбөрүүд;
4. Дотоодын болон гадаадын хувь хүн, байгууллагын хандив;
5. Бусад эх үүсвэр.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн болон тэдгээрийн төлөөх тэдгээрийг төлөөлөх байгууллагууд нь энэхүү хуулийг хэрэгжүүлэх тухай журамд тодорхойлсон нөхцөл, шаардлагын дагуу улсын төсвөөс тэтгэлэг авах эрхтэй байна.

## **6 дугаар бүлэг - Захиргааны хариуцлага тооцох**

Энэ хуулийн хүрээнд захиргааны зөрчлийг магадлан тогтоох албан тушаалтнуудыг дараах байгууллагаас томилно. Үүнд:

1. Төрийн санхүүгийн дотоод хяналтын газрын дарга – санхүүгийн зөрчлүүдэд;
2. Хөдөлмөрийн ерөнхий захиргаа – Гүйцэтгэгч агентлаг – хөдөлмөр эхлэлт, ажлын байртай холбоотой зөрчлүүдэд;
3. Боловсрол, шинжлэх ухааны сайд – боловсролтой холбоотой зөрчлүүдэд;
4. Үндэсний барилгын хяналт шалгалтын захиргааны дарга – архитектурын саадгүй хүртээмжтэй орчинтой холбоотой зөрчлүүдэд;
5. Автомашины захиргаа – Гүйцэтгэгч агентлагийн дарга, ялангуяа Төмөр замын захиргаа-Гүйцэтгэгч агентлагын дарга – саадгүй хүртээмжтэй тээвэртэй холбоотой зөрчлүүдэд;
6. Нийгмийн тусламж үйлчилгээний газар-нийгмийн тусламж үйлчилгээтэй холбоотой зөрчлүүдэд.

Торгууль, шийтгэлийг хуулиар олгогдсон эрх бүхий байгууллага, Сайд нарын зөвлөлөөс гаргасан актын дагуу ногдуулна. Энэхүү хуулийн дагуу ногдуулсан торгуулийн 50 хувь нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал эрхэлсэн газрын орлого болно. Энэхүү зүйлд заасан байгууллагууд нь жил бүр 12 дугаар сарын 31-нийг хүртэл хийсэн хяналт шалгалт, ногдуулсан торгууль шийтгэлийн талаарх мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал эрхэлсэн газарт хүргүүлнэ.

Болгар улс 2004 онд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд татан оролцуулах тухай хуулийг баталсаны дараагийн алхамыг Европын хүний эрхийн комиссоос<sup>42</sup> 2016 онд дүгнэсэнээр оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхэм чанарыг хүлээн зөвшөөрч, өмнөөс нь бусад этгээд бүх шийдвэр гаргадаг албадмал тогтолцоог өөрчилж, Европын социал харта, Европын хүний эрхийн шүүхийн шийдвэр болон бусад олон улсын гэрээ, хэлэлцээрт нийцүүлсэн шинэ, дэвшилттэй хуулийн төсөл батлах юм. Энэхүү хуулийн төслөөр оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүний бүрэн болон цагаар харгалзан дэмжигчтэй байсныг халж, түүний оронд эрхээ хэрэгжүүлэх бүх талын дэмжлэг, арга хэмжээгээр хангах үүрэг хүлээлгэнэ. Хэрэв энэ үүргээ биелүүлэхгүй байгаа тохиолдолд шүүхэд хандан энэхүү үүргийн хэрэгжилтийг шалгуулах эрхийг нээх юм. Өмнө нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг эрх зүйн чадамжгүй хэмээн үзэж, хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалуулах, боловсрох, өмчтэй байх, эдийн засгийн эрхтэй байх, гэр бүлтэйгээ хамт байх бүх эрхийг нь хасаж, нийтийн асрах газарт байлгадаг байсныг дуусгавар болгох хуулийн төсөл боловсруулагдан хэлэлцэгдэж байна.

**Дүгнэлт:** Болгар улсын дээрхи хуульд 1./ Зорилтыг тодорхойлохдоо хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдгээрийн гэр бүлд дэмжлэг үзүүлэх хэмээн заасан нь дэвшилттэй, өөрөөр хэлбэл хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өөрсдийн эрхийн хангах, баталгааг бүрдүүлэхээс гадна гэр бүлд үзүүлэх дэмжлэг зайлшгүй чухал билээ. 2./ Хэрэгжүүлэх байгууллагын чиг үүргийн

<sup>42</sup> <https://www.coe.int/en/web/commissioner/-/steps-forward-in-protecting-persons-with-disabilities-in-bulgaria?desktop=true>

хувьд Монгол улстай тун төстэй Сайдын зөвлөл, Үндэсний зөвлөл, салбар яамд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал эрхэлсэн газар хэмээх нэгжүүд бодлого, хөтөлбөр, хэрэгжилтийн хариуцахаар заасан. Гэвч, тухайлбал, "Төрийн байгууллагууд болон нутгийн өөрөө удирдах байгууллагууд нь өөрийн эрх мэдлийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд нэгтгэн оролцуулахтай холбоотой эрхзүйн акт, стратеги, хөтөлбөр, стандарт болон бусад баримт бичгийг боловсруулан батална." гэдэг заалт хэт ерөнхий заалт болжээ. Иймэрхүү хэт ерөнхий заалт, байгууллага хоорондын дунд ойлгомжгүй орхих нь хуулийн хэрэгжилтэнд сөргөөр нөлөөлдөг болохыг бид үр дагаврын үнэлгээнээс ажигласан.

3./ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал эрхэлсэн газрын хэрэгжүүлэхээр заасан А.Туслах хэрэгсэл, хэрэглэгдэхүүн, байгууламжийн үйлдвэрлэл, импорт, борлуулалт, засвар үйлчилгээний стандарт, шалгуурыг батлах, туслах хэрэгслийн хангалт батласан шалгуур, стандартад нийцэж буй эсэхэд хяналт тавих; Б.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэргэшсэн үйлдвэр, хоршоодын бүртгэлийг хөтлөх; В.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой хуулийн төсөл боловсруулахад оролцох, санал оруулах; Г.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бизнес санаачилга, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тустай бизнесийн санаачилгыг хөхиүлэн дэмжих хөтөлбөр боловсруулж, төслүүдийг санхүүжүүлэх; Д.Сайд нарын зөвлөлөөс даалгасан нэмэлт ажил үүргийг гүйцэтгэх болон хөгжлийн байнгын бэрхшээлтэй иргэдийн талаарх мэдээллийн сан бүрдүүлэх чиг үүргийг Монгол Улс харгалзан үзэх боломжтой.

4./ Хөгжлийн бэрхшээлийг эмнэлгийн магадлагаа, нийгэмшлийн үнэлгээгээр тогтоон үнэлэх туршлага нь хамаарах оролцогчдыг бүрэн хамааруулсан, цаашид авах арга хэмжээ, тусламж хүртэх эсэхийг тодорхойлдог ач холбогдолтой байна.

5./ Хөгжлийн бэрхшээл 16 наснаас нь хойш илэрсэн иргэд ерөнхий болон мэргэжлийн боловсрол, насанд хүрэгсдийн боловсрол болон үндсэн ур чадвар олгох тусгай хөтөлбөрийн анхны сэргээн заслын зэрэг нэмэлт хөтөлбөрүүдэд үнэ төлбөргүй хамрагдах эрх олгосон нь дэвшилттэй зохицуулалт гэж үзэж байна.

6./ Ажил олгогч, ялангуяа томилогч этгээд нь ажилтан томилогдсон даруйд, эсхүл томилогдсоноос хойш хөгжлийн бэрхшээлтэй болсон бөгөөд ажлын байр тохижуулахад шаардагдах зардал нь хэт өндөр биш, ажил олгогчид их хэмжээний дарамт учруулахуйц бус бол ажлын байрыг хөгжлийн бэрхшээлтэй иргэний хэрэгцээ шаардлагад нийцүүлэн тохируулах үүрэг хүлээхээр уян хатан байдлаар зохицуулжээ. Сайд нарын зөвлөл нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэргэшсэн үйлдвэр, хоршоодын үйлдвэрлэх бараа бүтээгдэхүүн, үзүүлэх үйлчилгээг төрийн худалдан авах ажиллагааны тухай хуульд заасан журмын дагуу тодорхойлох нь тухайн бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг иргэдэд давуу тал бий болгох боломжтой. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал эрхэлсэн газрын дарга нь энэхүү хуулийг хэрэгжүүлэх тухай журамд заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бие даасан бизнесийн үйл ажиллагааг санаачлан хөгжүүлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдийг батлахаар мөн тусгагдсан байна.

7./ Амьдрах болон архитектурын саадгүй хүртээмжтэй орчны нөхцөлийг тогтоохдоо одоогийн барилга байгууламж, хүрээлэн буй орчныг олон нийтийн хэрэгцээнд нийцүүлэн тохируулах элементүүдийг чиглэлийн яам тогтоохоор заажээ.

8./ Хөгжлийн байнгын бэрхшээлтэй хүнийг асарч байсан, нийгмийн баталгаагүй болсон этгээдэд Нийгмийн халамжийн хуулийн нөхцөл, шаардлагын дагуу тэтгэвэрт гарах үед нь даатгуулаагүй хугацааг нөхөн тооцно. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу тухайн хугацааны эрүүл мэндийн даатгалыг төлөгдсөнд тооцохоор оруулсан нь тун ач холбогдолтой заалт гэж үзэж байна.

9./ Энэхүү хуулийн дагуу ногдуулсан торгуулийн 50 хувь нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал эрхэлсэн газрын орлого болохоор заасан нь эргээд хөгжлийн бэрхшээлтэй газрын санхүүжилтийн эх үүсвэр болох хувьдаа тодорхой ажээ.

#### **4.3. Япон улсын хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаархи хууль тогтоомж**

Япон улс нь нэгдмэл нэг хуулиар бус салбар, субъект, харилцаагаар ялгаатай нарийвчилсан хуулиудаар хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх зүйн байдлыг зохицуулдаг байна. Үүнд: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тухай хууль (1970), Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ерөнхий хууль (2011), Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн халамжийн хууль (2013), Бие махбодын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн халамжийн хууль (1949), Оюуны хөгжлийн бэрхшээлтэй иргэний халамжийн хууль (1960), Сэтгэцийн эрүүл мэнд, сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй иргэний халамжийн хууль (1995), Хүүхдийн халамжийн хууль (1949), Нийгмийн халамжийн үйл ажиллагааны хууль (2000), Бие махбодын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хариуцах үндсэн хууль (1993), Хөгжлийн бэрхшээлтэй иргэний бие даахыг дэмжих хууль (2006), Биемахбодын хөгжлийн бэрхшээлтэй иргэний дэмжих нохойны тухай хууль (2002), Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ерөнхий тусламж үзүүлэх тухай хууль (2006), Хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй зүй бусаар харьцахаас сэргийлэх хууль (2012), Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль (2013), Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ялгаварлан гадуурхалтын эсрэг хууль (2016) гэсэн нарийвчилсан хуулиуд, улмаар дагалдах журмууд.<sup>43</sup>

Эдгээр хуулийг бүрэн эхээр нь үзэх эх сурвалж, хэлний бэрхшээл байсан тул зөвхөн Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих Жайка олон улсын хамтын ажиллагааны байгууллагын төслийн гаргасан гарын авлагаас Монгол улсад туршлага болох боломжтой дараахь зохицуулалтыг онцолж байна.

1. Хөгжлийн бэрхшээлийн халамжийн бодлогын замналын хувьд 2006 оноос Хөгжлийн бэрхшээлтэй иргэний бие даахын дэмжих хууль хэрэгжиж эхлэсэн бөгөөд хэрэглэгчийн дарамтыг хөнгөлөх, компаниудад онц хөнгөлөлт үзүүлэх, шилжилтийн үеийн зохицуулалтыг хамаарчээ. 2007 онд тус хуулийн агуулгын тухайд шилжилтийн үеийн зохицуулалт өнгөрч харин асрамжийн байгууллагын дэд бүтцийг дэмжих арга хэмжээ нэмэгджээ. 2011 онд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зүй зохисгүй хандахаас урьдчилан сэргийлэх хууль, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамгаалж асарч буй иргэдэд шаардлагатай дэмжлэгийг үзүүлэх хууль батлагдсан. 2012 онд Орон нутгийн нийгэмд энгийн иргэдтэй хамт амьдрах нөхцлийг хэрэгжүүлэхэд шинээр Хөгжлийн эрүүл мэндийн бодлогыг гаргаж ирэхэд шаардлагатай хууль зүйн акын талаархи хууль, болон Улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асрамжийн газраас бараа бүтээгдэхүүн худалдан авахыг дэмжихтэй холбоотой хууль батласан. 2013 онд Хөгжлийн бэрхшээлийн улмаас ялгаварлан гадуурхахыг хориглох хууль батлагдаж, 2016 оноос хүчин төгөлдөр үйлчилж эхлэсэн.

2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажилд авахыг дэмжих тухай хуулиар тогтоосон хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулах квот нь ердийн 56-аас дээш хүнтэй аж ахуйн нэгж 2.0, бусад 50-аас дээш хүнтэй аж ахуйн нэгж 2.3 хувь хэмээн хувиар тодорхойлсон байна. Хэрэв хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажилд аваагүй бол 50 000 иен сар бүр төлбөр төлөхөөс гадна ажилд авах үүргээс давуулан хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажилд авсан бол хүн тус бүрийн тоогоор сар бүр 27 000 иен олгохоор заажээ.

3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролыг тусгай дэмжлэг бүхий боловсролоор дамжуулан олгодог. Энэ нь тусгай дэмжлэг үзүүлдэг анги, тусгай дэмжлэг үзүүлдэг

<sup>43</sup> Японы хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан бодлогын гарын авлага, Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих төсөл, 2018 он

сургууль, бага болон дунд сургуульд тусгай дэмжлэг бүхий боловсролын ахиц дэвшил, тусгай дэмжлэг үзүүлдэг багшийн мэргэжлийн лиценз гэсэн салбарлаж хэрэгждэг байна. Сургууль бүр олон төрлийн байгууллагатай сүлжээ үүсгэн, хүүхдийн хөгжилд нийцсэн уялдаа холбоо бүхий дэмжлэг үзүүлдэг байна.

4.Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх үйлчилгээнд хамрагдах төлөвлөгөөг тухайн иргэн, гэр бүлийнхэнтэй ярилцан амьдралын бүх нөхцлийг тухайлбал, гэр бүлийн бүтэц, сэтгэцийн нөхцөл байдал, амьдралын хэв маягийг харгалзан тухайн хүнийг тухайн орон нутагтаа бие даан амьдарахад нь тусалж дэмжихээр боловсруулдаг төлөвлөгөө байна. Харин хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн халамжийн үйлчилгээний зэрэглэл нь хөгжлийн бэрхшээлийн онцлог, бие сэтгэл санааны байдалд нийцэх халамж, асаргааны хэмжээг илэрхийлсэн зэрэглэл байдаг. Үнэлгээний дагуу аль халамжийн арга хэмжээнд хамрагдах болохыг шийдвэрлэдэг ажээ.

5.Хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран харилцан зан чанар, хувь хүний онцлогийг хүндэтгэсэнээр хамт амьдрах нийгмийг бодит болгоно хэмээн Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ялгаварлан гадуурхахыг хориглох тухай хуулинд зорилгоо тодорхойлжээ. Энэхүү хуулиар ялгаварлан гадуурхалтын хэлбэрийг тодорхойлж, зөвхөн төрийн байгууллага төдийгүй хувийн байгууллага, олон нийтэд үүрэг хүлээлгэсэн тогтолцоо бүрдүүлж ажиллахаар заасан бөгөөд эцэстээ татан оролцуулсан хамтран амьдрах нийгмийг бий болгохыг зорихоор тусгажээ. Хэрэв хуульд үүрэг хүлээлгэсэн субъектүүд биелүүлэхгүй бол хариуцлага хүлээнэ.

6.Хөдөлмөрлөх чадваргүй хүмүүст нийгмийн халамжийн үйлчилгээг хүргэхдээ бие эрхтэн, сэтгэцийн хүндрэлтэй, оюун ухааны хомсдолтой, хөгжлийн бэрхшээлтэй гэж 4 ангилж ялгавартай ханддаг. Бие эрхтний хүндрэлтэй ХБ-тэй иргэд нийт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ихэнх хувийг эзлэх бөгөөд тэдэнд үзүүлэх үйлчилгээг нийгэм хамт олонд түшиглэсэн мэргэжлийн байгууллагын төрөлжсөн гэж ангилдаг. Төрөлжсөн байгууллагын үйлчилгээ: хараа, сонсгол, оюун ухаан, хөдлөх эрхтний хүндрэлийг багасгах сэргээн засах үйлчилгээг мэргэжлийн түвшинд төрөлжсөн үйлчилгээний байгууллагаар дамжуулан үзүүлэх нь ХБ-тэй хүмүүсийн халамжийн үйлчилгээний нэг хэсэг болдог. Төрөлжсөн байгууллагын үйлчилгээнд хөдөлмөрийн чадвараа алдсан хүмүүсийн онцлог нь тохирсон ажил хийлгэх, ярилцлага, семинарт, оруулах ажлын арга барил эзэмшүүлэх, түр хугацааны хөдөлмөр эрхлүүлэх зэрэг ажил хийдэг.

**Дүгнэлт:** Япон улс хууль зүйн системийн хувьд төрөлжүүлэн нарийвчилсан олон хуулиар уг харилцааг зохицуулдаг онцлогтой тул холбогдох харилцааг маш сайн дэлгэрэнгүй, ихээхэн тодорхой зохицуулдаг онцлогтой ажээ. Дээр хэсэгт онцолсон 6 асуудлыг Монгол улс салбарын хуульдаа жишиг болгон харгалзах боломжтой гэж үзэв.

## **V. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ДАВХАРДАЛ, ЗӨРЧИЛ, ХИЙДЭЛ**

**Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуультай шууд холбоотой эрх зүйн акт:**

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхтэй холбоотой Монгол Улсын олон улсын гэрээ конвенц-21

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуультай холбоотой эрх зүйн бусад актыг тогтоон цуглуулах:

- УИХ-ын тогтоол-4
- Засгийн газрын тогтоол-10
- Сайдын тушаал-5

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг ХЗДХ-ийн сайдын 2010 оны 84 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, тэдгээрийн уялдаа, холбоог сайжруулах аргачлал”-ын дагуу шалгасан.

### 5.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн давхардал

Тухайн хуульд байгаа зохицуулалтыг уг хуульд болон бусад хуульд бичвэрийн эсхүл агуулгын хувьд хуулбарлан хуульчилсан эсэх

Д/д	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /2016 он/	Бага дунд боловсролын тухай хууль /2002 он/
1.	<p>14.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүн бусад иргэний хамт сурч боловсрох, мэргэжил эзэмших эрхтэй бөгөөд энэхүү эрхийг нь хангах чиглэлээр төрөөс дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:</p> <p>14.1.3.бүх шатны боловсролын тогтолцоонд хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох, мэргэжил эзэмших нөхцөлийг бүрдүүлэх, тохирох хэрэглэгдэхүүнээр хангаж, дэмжлэг тусалцаа үзүүлэх;</p>	<p>13.3.Ерөнхий боловсролын бусад сургууль нь <b>хөгжлийн</b> бэрхшээлтэй хүүхдэд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй.</p> <p><u>/Энэ хэсгийг 2006 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/</u></p>
<p><b>Дүгнэлт:</b> Дээрх хоёр хуулийн зохицуулалт агуулгын хувьд давхардаж байна.</p> <p><b>Санал:</b> Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 14.1.3 дахь хэсгийг хүчингүй болгох.Учир нь, бага, дунд боловсролын харилцааг Бага дунд боловсролын тухай хуулиар зохицуулна.</p>		

Д/д	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /2016 он/	Бага дунд боловсролын тухай хууль /2002 он/
2.	<p><b>16 дугаар зүйл. Багшийн мэргэжил</b></p> <p>16.2.Бүх шатны боловсрол олгох сургалтын байгууллагын багш, нийгмийн ажилтан нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлог хэрэгцээ, шаардлагад нийцсэн заах арга зүй, арга барилыг эзэмшсэн байна.</p>	<p>13.12.<b>Хөгжлийн</b> бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш, нийгмийн ажилтан нь <b>хөгжлийн</b> бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирсон заах арга эзэмшсэн байна.</p>
<p><b>Дүгнэлт:</b> Дээрх хоёр хуулийн зохицуулалт агуулгын хувьд давхардаж байна.</p> <p><b>Санал:</b> Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 16.2 дахь хэсгийг хүчингүй болгох. Учир нь, бага, дунд боловсролын харилцааг Бага дунд боловсролын тухай хуулиар зохицуулна.</p>		

Д/д	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /2016 он/	Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль /2002 он/
3.	16 дугаар зүйл. Багшийн мэргэжил 16.2.Бүх шатны боловсрол олгох сургалтын байгууллагын багш, нийгмийн ажилтан нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлог хэрэгцээ, шаардлагад нийцсэн заах арга зүй, арга барилыг эзэмшсэн байна.	9.12.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш, нийгмийн ажилтан нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирсон заах арга барилыг эзэмшсэн байна..
<p><b>Дүгнэлт:</b> Дээрх хоёр хуулийн зохицуулалт агуулгын хувьд давхардаж байна.</p> <p><b>Санал:</b> Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 16.2 дахь хэсгийг хүчингүй болгох. Учир нь, сургуулийн өмнөх боловсролын харилцааг Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулиар зохицуулна.</p>		

Д/д	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /2016 он/	Сонгуулийн тухай хууль /2015 он/
4.	30.1.Бүх шатны сонгуульд хөгжлийн бэрхшээлтэй хүн саналаа бие даан, чөлөөтэй, нууцаар өгөх нөхцөлийг бүрдүүлсэн байна.	87.5.Санал авах байранд сонгогчдоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хангасан, хэсэг дэх сонгогчдын тооноос хамааран хоёроос доошгүй тооны санал бэлтгэх бүхээг байх бөгөөд санал авах байр бүрд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлтгэсэн байна.  89.4.Гарын хурууны хээ шалгах автомат төхөөрөмж ажиллахгүй буюу ажиллах боломжгүй болсон, түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй сонгогчийн тухайд иргэний үнэмлэхийн мэдээллийг сонгогчдын нэрийн жагсаалттай тулган шалгаж сонгогчийн бүртгэлийн хуудас олгож болно
<p><b>Дүгнэлт:</b> Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 30.1 дэх хэсгийн зохицуулалт нь агуулгын хувьд Сонгуулийн тухай хуульд дэлгэрэнгүй тусгагдсан байна.</p>		

Д/д	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /2016 он/	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль /1994 он/
5.	37.2.Хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг дараахь комисс /цаашид “Комисс” гэх/ тогтооно: 37.2.1. 0-16 насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс;	8 дугаар зүйл. Тахир дутуу болсныг тогтоох 1. Тахир дутуу болсныг хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан, хагас /хэсэгчлэн/ алдсан гэж ангилна. 2. Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, түүний хугацааг эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс тогтооно.

	<p><b>37.2.2.</b> 16 ба түүнээс дээш насны хүний хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс;</p> <p><b>37.2.3.</b> хөгжлийн бэрхшээлтэй болсон шалтгаан, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс.</p>	<p>3. Тахир дутуу болсныг тогтооход баримтлах өвчний жагсаалтыг эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага батална.</p> <p><b>Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /1994 он/</b></p> <p><b>5 дугаар зүйл. Тахир дутуугийн тэтгэвэр авах эрх</b></p> <p>1. Даатгуулагч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа удаан хугацаагаар буюу байнга алдаж тахир дутуу болсон бол тахир дутуугийн тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй.</p> <p>2. Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс тогтооно.</p>
<p><b>Дүгнэлт:</b> Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд 16 ба түүнээс дээш насны хүний хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг ЭХМК тогтооно гэжээ. Энэ зохицуулалт нь Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйл, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 5 дугаар зүйл дэх зохицуулалттай агуулгын хувьд ижил байна.</p>		

Д/д	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /2016 он/	Боловсролын тухай хууль /2002 он/
6.	<p><b>14 дүгээр зүйл. Сурч боловсрох эрх</b></p> <p><b>14.1.</b> Хөгжлийн бэрхшээлтэй хүн бусад иргэний хамт сурч боловсрох, мэргэжил эзэмших эрхтэй бөгөөд энэхүү эрхийг нь хангах чиглэлээр төрөөс дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:</p> <p><b>14.1.1.</b> хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлогт нийцүүлэн авьяас билэг, бүтээлч чанар, оюуны болон бие бялдарын чадварыг хөгжүүлэх сургалтын хөтөлбөр, орчныг бий болгох;</p>	<p><b>5 дугаар зүйл. Боловсролын үндсэн зарчим</b></p> <p>5.1.4. иргэнийг сурч боловсроход үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, <b>хөгжлийн</b> онцлог, эрүүл мэнд, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхахгүй байх, эх хэлээрээ сурч боловсрох тэгш боломж, нөхцөлөөр хангана;</p> <p><u>/Энэ заалтад 2006 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/</u></p> <p><b>42 дугаар зүйл. Боловсролын байгууллагын сургалтын орчин</b></p> <p>42.1. Боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь багш, ажилтан, суралцагчийн хөдөлмөрийн онцлогт тохирсон, <b>хөгжлийн</b> бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна.</p> <p><u>/Энэ хэсэгт 2006 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/</u></p> <p>10 дугаар зүйл. Боловсролын хөтөлбөр, агуулга</p>



		<p>/Энэ зүйлийн гарчигт 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/  10.1.Боловсролын агуулга нь суралцагчийн нас, бие, сэтгэхүйн онцлог, авьяас, сонирхол, хувийн болон нийгмийн хэрэгцээ, үндэсний өв, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн хандлагад нийцүүлэн боловсролын зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэнэ.</p> <p><b>43.2.</b> Суралцагч нийгмийн дараахь баталгаагаар хангагдана:  43.2.7.суралцагчийн онцгой авьяас, чадварыг нээн илрүүлж хөгжүүлэх, урамшуулан дэмжих, өнчин, амьжиргааны түвшин доогуур, <b>хөгжлийн</b> бэрхшээлтэй суралцагчийг сурах нөхцөл бололцоогоор төрөөс хангах;  44.2.Багш дараахь үүрэгтэй:  44.2.8.<b>хөгжлийн</b> бэрхшээлтэй суралцагчийн бие эрхтэн, <b>хөгжлийн</b> онцлогийг хүндэтгэн үзэж, <b>хөгжлийн</b> бэрхшээлтэй суралцагч бусдын адил тэгш байх нөхцөлийг бүрдүүлэх.</p>
<p><b>Дүгнэлт:</b> Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд сурч боловсрох эрхийг төрөөс хангах чиглэлийг заасан бөгөөд энэ нь агуулгын хувьд Боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчим, 42 дугаар зүйл, 43, 44 дүгээр зүйлтэй агуулгын хувьд ижил бөгөөд Боловсролын тухай хуульд хэрэгжүүлэх этгээдийг тодорхой заасан байна. Харин Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд төрөөс гэж оруулсан нь хэрэгжүүлэх этгээд нь ойлгомжгүй байна. .</p>		

Д/д	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /2016 он/	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /2016 он/
7.	<p><b>14.1.</b>Хөгжлийн бэрхшээлтэй хүн бусад иргэний хамт сурч боловсрох, мэргэжил эзэмших эрхтэй бөгөөд энэхүү эрхийг нь хангах чиглэлээр төрөөс дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:  <b>14.1.3.</b>бүх шатны боловсролын тогтолцоонд хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох, мэргэжил эзэмших нөхцөлийг бүрдүүлэх, тохирох хэрэглэгдэхүүнээр хангаж, дэмжлэг туслалцаа үзүүлэх;  <b>14.1.4.</b>хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээ, шаардлагад нийцсэн сургалтын хөтөлбөр, стандартыг боловсруулах.</p>	<p>15.1.Бүх шатны сургалтын байгууллага болон мэргэжил олгох төв нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид амьдрах ухаан, мэргэжлийн ур чадварыг үр дүнтэй эзэмшүүлэх бөгөөд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:  15.1.1.тухайн суралцагчийн онцлогт тохирсон хамгийн зохистой арга хэлбэрээр боловсрол олгох;  15.1.2.хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг онцлог хэрэгцээнд нь тохирох ном, сурах бичиг, гарын авлага, материал, тусгай хэрэглээний сургалтын тоног төхөөрөмж, хэрэгслээр хангах;  15.1.3.сургалтын тусгай хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу сургалтыг явуулах;</p>
<p><b>Дүгнэлт:</b> Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 14 дүгээр зүйл дэх зохицуулалт нь агуулгын хувьд 15 дугаар зүйлтэй давхардаж байгаа бөгөөд 15 дугаар зүйлд хэрэгжүүлэх этгээдийг тодорхой заасан байна.</p>		

Д/д	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /2016 он/	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль /2008 он/
8.	17.3.Төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээд нь хөгжлийн бэрхшээлтэй хүний бие эрхтэн, хөгжлийн онцлогт нийцсэн ажлын байрыг Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу бий болгож ажиллуулах үүрэгтэй.	<b>16 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлд тавигдах шаардлага</b> 16.1.Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрны нөхцөл нь тэдний хөдөлмөрлөх чадварт нь тохирсон байна. 16.2.Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байр нь түүнийг орж, гарахад нь саад болохооргүй байдлаар тоноглогдсон байна.
<b>Дүгнэлт:</b> Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 17.3 дахь хэсгийн зохицуулалтын ажлын байранд тавигдах шаардлагыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд нарийвчлан зохицуулсан байна. 17.3 дахь хэсэгт ажлын байрыг Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу бий болгох үүрэгтэй гэсэн атал Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1 дэх хэсэгт “25, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулна”, 111.2-т “Аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 111.1-д заасан хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүн ажиллуулаагүй бол ажиллуулбал зохих орон тоо тутамд сар бүр төлбөр төлнө” гэж сонголтот зохицуулалтыг заасан. Гэтэл Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 17.3 дахь хэсэгт ажлын байр бий болгох үүрэгтэй гэж заасан нь Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1-111.2 дахь хэсэгтэй зөрчилдөж байна.		

Д/д	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /2016 он/	Биеийн тамир, спортын тухай хууль /2017 он/
9.	33.3.2.биеийн тамир, спортын байгууламж нь хөгжлийн бэрхшээлтэй хүн тэмцээн уралдаан, нийтийн биеийн тамирын арга хэмжээнд оролцох, бэлтгэл сургуулилт хийхэд тохиромжтой заал, талбай болон тохирох хэрэглэгдэхүүнээр тоноглогдсон байх;	26.3.Биеийн тамир, спортын барилга байгууламж, заал, талбай нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний хэрэгцээ, техникийн шаардлагыг хангасан байна.
<b>Дүгнэлт:</b> Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 33.3.2 дахь хэсэг нь агуулгын хувьд Биеийн тамир, спортын тухай хуули йн 26.3 дахь хэсэгтэй давхардаж байна.		

Д/д	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /2016 он/	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль /2008 он/
10.	<b>43 дугаар зүйл. Хуулийн этгээдийн нийтлэг эрх, үүрэг</b> 43.1.Хуулийн этгээд нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр дараахь нийтлэг эрх, үүрэгтэй:  43.1.1.хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээ шаардлагад нийцсэн ажиллах орчныг бүрдүүлэх;	16.1.Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрны нөхцөл нь тэдний хөдөлмөрлөх чадварт нь тохирсон байна. 16.2.Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байр нь түүнийг орж, гарахад нь саад болохооргүй байдлаар тоноглогдсон байна.

43.1.9.хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны стандартыг хангаж ажиллах;	7.2.Аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэлийн орчин нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, шаардлага хангасан байна.
<b>Дүгнэлт:</b> Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 43.1.1, 43.1.9 дэх заалт нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 16.1-16.2, 7.2 дахь хэсэгтэй агуулгын хувьд ижил байна.	

Д/д	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /2016 он/	Хөдөлмөрийн тухай хууль /1999 он/
11.	<p><b>43 дугаар зүйл. Хуулийн этгээдийн нийтлэг эрх, үүрэг</b></p> <p>43.1.Хуулийн этгээд нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр дараахь нийтлэг эрх, үүрэгтэй:</p> <p>43.1.5.хөгжлийн бэрхшээлтэй болсон хүнд түүнийг ажиллуулж байсан байгууллагын хувьд тусламж, дэмжлэг үзүүлэх;</p> <p>43.1.6.өөрчлөн зохион байгуулагдсан буюу татан буугдсан бол түүний эрх, үүргийг хүлээж авсан этгээд энэ хуулийн 43.1.5-д заасан эрх, үүргийг хэрэгжүүлэх;</p> <p>43.1.8.ажилтан тухайн байгууллагын буруутай үйл ажиллагааны улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон нь шүүхээр тогтоогдсон бол хохирлыг нөхөн төлөх;</p>	<p>5.2.Ажил олгогч нь ажилтныг ажлаар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад тохирсон нөхцөлөөр хангах, хөдөлмөрийн үр дүнд нь тохирсон цалин хөлс олгох, энэ хууль болон хөдөлмөрийн ба хамтын гэрээ, хэлэлцээр, хөдөлмөрийн дотоод журамд заасан үүргээ биелүүлэх үүрэгтэй.</p> <p><i>/Энэ хэсэгт 2008 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</i></p> <p>40.4.Аж ахуйн нэгж, байгууллагын харьяалал, өмчлөгч өөрчлөгдсөн нь хөдөлмөрийн гэрээ цуцлах үндэслэл болохгүй.</p> <p><b>97 дугаар зүйл.Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний хохирлыг нөхөн төлөх</b></p>
<b>Дүгнэлт:</b> Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 43.1.5-43.1.6, 43.1.8 дахь заалт нь Хөдөлмөрийн тухай хуулийн 5.2, 40.4, 97 дугаар зүйлтэй агуулгын хувьд ижил байна.		

## 5.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн зөрчил

1.Хуульд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн болон бусад хуулийн нэр томъёотой зөрчилдөж байгаа эсэх

Д/д	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /2016 он/	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /2016 он/
1.	4.1.1. “хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдэгт бие махбодь, оюун санаа,	<b>37 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоох</b>

	сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг;	37.1.Хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг дараахь шалгуураар тогтооно: 37.1.1.эрхтэн тогтолцооны бүтцийн алдагдал, ангилал, хугацаа; 37.1.2.биеийн үйлдэл, үйл ажиллагааны олон улсын ангилал.
<b>Дүгнэлт:</b> Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 37.1 дүгээр хэсэг дэх зохицуулалт нь агуулгын хувьд 4.1.1 дэх заалттай зөрчилтэй байгаа тул 37.1-д 4.1.1-ийг иш татах.		

Д/д	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /2016 он/	Нийгмийн халамжийн тухай хууль /2012 он/
2.	25.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүн хоол хүнс, хувцас, орон байр, эмчилгээ сувилгаа, нийгэм ахуйн зайлшгүй шаардлагатай үйлчилгээг оролцуулаад өөрийн болон гэр бүлийнхээ эрүүл мэнд, аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрхтэй бөгөөд энэхүү эрхийг хангах зорилгоор төрөөс дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:  25.1.2.хөгжлийн бэрхшээлтэй эцэг, эх хүүхдээ өсгөн хүмүүжүүлэхэд нь шаардлагатай дэмжлэг үзүүлж, туслах үйлчилгээ авах боломжоор хангах;	19.2.Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд дараах иргэнийг хамруулна:  19.2.3.хүнд нөхцөлд байгаа, Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон байнгын асрамжид байдаг хөгжлийн бэрхшээлтэй 18 хүртэлх насны хүүхэд;
<b>Дүгнэлт:</b> Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан туслах үйлчилгээ авах гэдэг нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 19.2 дахь хэсэгт заасан төрөлжсөн асрамжийн үйлчилгээгээр дамжин хэрэгжинэ. <b>Санал:</b> Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 25.1.2 дахь заалтыг “хөгжлийн бэрхшээлтэй эцэг, эх хүүхдээ өсгөн хүмүүжүүлэхэд нь шаардлагатай төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдах” гэж өөрчлөх		

Д/д	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /2016 он/	Гамшгаас хамгаалах тухай хууль /2017 он/
3.	<b>36 дугаар зүйл. Онцгой байдлын үед авах арга хэмжээ</b> 36.1.Хүний амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдалд шууд аюул учруулсан буюу учруулахуйц байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул, нийтийн эмх замбараагүй байдал, дайн бүхий байдал зэрэг онцгой байдал бий	4.1.1.“гамшиг” гэж аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд улс болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн дотоод нөөц, боломжоос давсан хохирол учрахыг;  4.1.2.“аюулт үзэгдэл” гэж хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, аянга, газар

	<p>болох үед хөгжлийн бэрхшээлтэй хүнд энэ тухай хүртээмжтэйгээр мэдээлэх, тухайн үед амь нас, эрүүл мэндийг нь онцгой байдлын нөхцөлтэй уялдуулан хамгаалах үүргийг төрийн холбогдох байгууллага хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлнэ.</p>	<p>хөдлөлт, гал түймэр, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин гарах, хортон шавж, мэрэгч тархах зэргийг;</p> <p>4.1.3.“осол” гэж үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс тоног төхөөрөмж, барилга байгууламж ноцтой эвдрэх, нурах, тээврийн хэрэгсэл осолдох, сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах, дэлбэрэлт болох зэргийг;</p>
<p><b>Дүгнэлт:</b> Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн агуулга нь гамшиг, аюулт үзэгдэл, осол гарсан үед хөгжлийн бэрхшээлтэй хүнд мэдээлэл хэрхэн хүргэх, хамгаалах талаар зохицуулсан бөгөөд зүйлийн нэр нь онцгой байдлын үед гэсэн нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.1-4.1.3 дахь заалттай нийцэхгүй байна.</p> <p><b>Санал:</b> Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн нэрийг гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед авах арга хэмжээ гэж өөрчлөх.</p>		

## 2.Тухайн хуулийн зүйл, заалт өөр хуулийн заалттай зөрчилдөж буй эсэх

Д/д	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /2016 он/	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль /2011 он/
1.	<p>2.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль, тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.</p>	<p>3.1.7.“ажил олоход хүндрэлтэй иргэн” гэж хөдөлмөр эрхлэлтийн нэмэлт үйлчилгээ, нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэн болон <b>Хөгжлийн</b> бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 3.1-д заасан иргэн, хорих ангиас суллагдсан болон хөдөлмөрийн насанд хүрээд асрамжийн газраас гарсан иргэн, 6 сараас дээш хугацаагаар ажил олж чадахгүй байгаа иргэнийг;</p>
<p><b>Дүгнэлт:</b> Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд заасан Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын хууль нь 2016.02.05-д хүчингүй болсон. Гэтэл дээрх хуульд ишлэж оруулжээ.</p> <p><b>Санал:</b> Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.7 дахь заалтын “...Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4.1.1..” гэж өөрчлөх</p>		

Д/д	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /2016 он/	Нийгмийн халамжийн тухай хууль /2012 он/
2.	<p>2.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль, тогтоомжийн бусад актаас бүрдэнэ</p>	<p>3.1.5.“<b>хөгжлийн</b> бэрхшээлтэй иргэн” гэж <b>Хөгжлийн</b> бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан хүнийг;</p>
<p><b>Дүгнэлт:</b> Нийгмийн халамжийн тухай хуульд заасан Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын хууль нь 2016.02.05-д хүчингүй болсон. Гэтэл дээрх хуульд эшлэж оруулжээ.</p>		

**Санал:** Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.5 дахь заалтын “...Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4.1.1..” гэж өөрчлөх

Д/д	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /2016 он/	Гэр бүлийн тухай хууль /1999 он/
3.	28.8.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй гэрлэгчид гэрлэлтээ цуцлуулсан тохиолдолд тэтгэлэг төлөгч нь холбогдох хууль тогтоомжинд заасны дагуу нэмэлт тэтгэлэг төлнө.	38.2.Эцэг, эх харилцан тохиролцож гэрээ байгуулан тэтгэлэг тогтоож болно. 38.3.Эцэг, эх харилцан тохиролцож гэрээ байгуулаагүй бол тэтгэлгийг шүүх тогтооно. <b>40 дүгээр зүйл. Тэтгэлгийн хэмжээ</b> 40.1.Хүүхдэд олгох тэтгэлгийг түүний насны байдлыг харгалзан сард нэг хүүхдэд дараах хэмжээгээр тогтооно: 40.1.1. 11 хүртэлх насны хүүхдэд тухайн бүс нутагт тогтоогдсон амьжиргааны доод түвшингийн 50 хувиар; 40.1.2. 11-16 нас /суралцаж байгаа бол 18 нас/-тай болон насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдэд амьжиргааны доод түвшингийн хэмжээгээр. 40.2.Зөвхөн цалин хөлснөөс өөр орлогогүй хариуцагчаас гаргуулах хүүхдийн тэтгэлгийн хэмжээ нь түүний сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын 50 хувиас хэтэрч болохгүй.
<b>Дүгнэлт:</b> Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нэмэлт тэтгэлгийг хуульд заасны дагуу төлнө гэж заасан. Гэтэл тэтгэлгийг Гэр бүлийн тухай хуулийн 38, 40 дүгээр зүйлд заасан бөгөөд энд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд нэмэлт тэтгэлэг олгох талаар зохицуулалт байхгүй		

Д/д	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /2016 он/	Нийгмийн халамжийн тухай хууль /2012 он/
4.	4.1.5.“хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээ” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүнд нийгмийн амьдралд тэгш оролцох боломжийг бүрдүүлж, гэр бүл, хамт олны дунд эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгэм-сэтгэл зүйн үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэхийг;	3.1.10.“олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ” гэж иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоотойгоор өрх, иргэнд дэмжлэг туслалцаа, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг.
5.	22.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээг дараах чиглэлээр үзүүлнэ: 22.1.1.өвчин, эмгэг, гэмтэл, бэртлийн улмаас үүссэн үр дагаврыг арилган хэвийн байдалд оруулахад чиглэсэн эрүүл мэндийн чиглэл; 22.1.2.хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын адил боловсрол, мэргэжил	8.1.Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ нь дараах төрөлтэй байна: 18.1.1.амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах; 18.1.2.зөвлөгөө өгөх; 18.1.3.сэргээн засах үйлчилгээнд хамруулах;



	<p>эзэмшихийг дэмжих боловсролын чиглэл;  <b>22.1.3.</b>хөгжлийн бэрхшээлтэй хүн гэр бүл, хамт олондоо эдийн засгийн хувьд хувь нэмрээ оруулахыг дэмжих хөдөлмөрийн чиглэл;  <b>22.1.4.</b>хөгжлийн бэрхшээлтэй хүн, гэр бүл, хамт олны дунд бусдын адил үүрэг хариуцлага хүлээсэн, идэвхтэй, бие даасан гишүүн болохыг дэмжих нийгмийн чиглэл;  <b>22.1.5.</b>хөгжлийн бэрхшээлтэй хүн нийгмийн бүхий л харилцаанд оролцохыг дэмжих дэд бүтэц, зам тээвэр, мэдээллийн технологийн хүртээмжийн.</p>	<p>18.1.4.түр байрлуулан асрамжлах, хүчирхийлэлд өртсөн хүнийг түр хамгаалан байрлуулах;  <u>/Энэ заалтад 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/</u>  18.1.5.өдрийн үйлчилгээнд хамруулах;  18.1.6.гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах;  18.1.7.иргэн, түүний гэр бүлийн хэрэгцээнд тулгуурласан нийгмийн халамжийн бусад үйлчилгээ үзүүлэх;  18.1.8.гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах;  18.1.9.нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай энэ хуулийн 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах.  18.1.10.гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд хамруулах.</p>
6.		<p>18.2.Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд дараах өрх, иргэн хамрагдана:  18.2.2.хөгжлийн бэрхшээлтэй иргэн;</p>
7.	<p><b>23 дугаар зүйл. Хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээ эрхлэх</b>  23.1.Энэ хуулийн <b>22.1</b>-д заасан үйлчилгээг өмчийн бүх хэлбэрийн байгууллага үзүүлнэ.  23.2.Хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий тусгай зөвшөөрөлтэй төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх тохиолдолд зардлыг бүрэн болон хэсэгчлэн тухайн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвөөс санхүүжүүлнэ.  23.3.Энэ хуулийн <b>22.1</b>-д заасан үйлчилгээний стандартыг тухайн асуудлыг эрхэлсэн төрийн</p>	<p>18.3.Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд шаардагдах хөрөнгийг сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөлийн саналыг үндэслэн аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага тооцож нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.  18.4.Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь улсын хэмжээнд дүнг нэгтгэн жил бүрийн төсвийн төсөлд тусгана.  18.5.Аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь энэ хуулийн 17.1-д заасан үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.  18.6.Энэ хуулийн 18.5-д заасан иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг сонгон</p>

<p>захиргааны төв байгууллага, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулж, стандартчиллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.</p> <p>23.4.Энэ хуулийн 22.1-д заасан үйлчилгээг эрхлэх байгууллагад тавигдах шаардлагыг тухайн асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран боловсруулж батална.</p>	<p>шалгаруулах ажлыг аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага гүйцэтгэнэ.</p> <p>18.7.Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагатай хийх гэрээний загвар болон үйлчилгээнд хамрагдах иргэний тоо, шаардагдах хөрөнгийн хэмжээг тодорхойлох аргачлал, зааврыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.</p> <p>18.8.Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний чанарт тавигдах шалгуур, журмыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p> <p>18.9.Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг энэ хуулийн 18.8-д заасны дагуу магадлан итгэмжлэх журмыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p>
<p><b>Дүгнэлт:</b> Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан хамт олонд түшиглэн хамруулах үйлчилгээ гэсэн зохицуулалт нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан олон нийтийн оролцоонд түшиглэсэн үйлчилгээтэй агуулгын хувьд ижил байна. Мөн Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.2.2 дахь заалтад олон нийтийн оролцоонд түшиглэсэн 10 төрлийн үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүн авах боломжтой гэж зохицуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 22 дугаар зүйлд хамт олонд түшиглэсэн үйлчилгээний чиглэлийг ерөнхийд зааснаас төрлийг заагаагүй байгаа нь энэ зохицуулалт хэрэгжих боломжгүй байна. Харин Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлд олон нийтийн оролцоонд түшиглэсэн үйлчилгээний төрлийг заасан. Эндээс дээрх хоёр хуульд байгаа <b>хамт олонд түшиглэн хамруулах үйлчилгээ-олон нийтийн оролцоонд түшиглэсэн үйлчилгээ</b> нь агуулгын хувьд ижил боловч хуулиудад хоёр өөр нэр томъёогоор оруулсан байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 23.2 дахь хэсэгт “Хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий тусгай зөвшөөрөлтэй төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх тохиолдолд зардлыг бүрэн болон хэсэгчлэн тухайн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвөөс санхүүжүүлнэ” гэсэн бол Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.5 дахь хэсэгт “Аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь энэ хуулийн 17.1-д заасан үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно” гэж заасан нь агуулгын хувьд давхардсан зохицуулалт байна. Үүнээс гадна Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 23.4 дэх хэсэгт “Энэ хуулийн 22.1-д заасан үйлчилгээг эрхлэх байгууллагад тавигдах шаардлагыг тухайн асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран боловсруулж батална” гэж заасан бөгөөд энэ зохицуулалтын “... тухайн асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүн...”гэдэг нь хэнтэй хамтарч батлахыг тодорхойгүй заажээ. Энэ зохицуулалтаас харвал “... үйлчилгээг эрхлэх байгууллагад тавигдах шаардлагыг тухайн асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран боловсруулж батална”. Гэтэл Нийгмийн</p>	



халамжийн тухай хуулийн 18.7-18.9 дэх хэсэгт нийгмийн халамжийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн батлахаар заасан нь зөрчилдөж байна.

**Санал:** Хамт олонд түшиглэсэн үйлчилгээ нь Нийгмийн халамжийн сангаас санхүүжнэ, улмаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд хамт олонд түшиглэсэн үйлчилгээ гэдгийн зөвхөн чиглэлийг зааснаас төрөл, хэлбэр, хамрагдах боломжийг нарийвчлан заагаагүй, өөр нэр томъёо хэрэглэсэн нь Нийгмийн халамжийн тухай хуулийн зохицуулалттай зөрчилдөж байгаа тул Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль дахь хамт олонд түшиглэсэн үйлчилгээний зохицуулалтыг хүчингүй болгож Нийгмийн халамжийн тухай хуулиар зохицуулах боломжтой. Учир нь, Нийгмийн халамжийн тухай хууль нь нийгмийн даатгалд хамрагдаж үйлчилгээ авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үйлчилнэ.

Д/д	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /2016 он/	Нийгмийн халамжийн тухай хууль /2012 он/
8.	<p>24.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхдийг энэ хуулийн 37.8-д заасан дүгнэлтийн дагуу хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээнд заавал хамруулах үүрэгтэй.</p> <p>37.8.Комисс өөрийн эрх хэмжээний хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхтэн тогтолцооны бүтцийн алдагдал, хугацаа, ангилалыг тогтоож, дүгнэлт гаргана.</p> <p>37.9.Энэ хуулийн 37.2.2-т заасан комиссоос гаргасан дүгнэлт нь хөгжлийн бэрхшээлтэй хүний хамт олонд түшиглэн хөгжүүлэх үйлчилгээнд хамрагдах үндсэн баримт бичиг болно.</p>	<p>27.1.Энэ хуулийн 3.1.2, 3.1.5, 18.2.4-т зааснаас бусад иргэнийг нийгмийн халамжийн үйл ажиллагаанд хамруулах эсэх талаар шийдвэр гаргах, халамжийн үйл ажиллагаатай холбогдсон гомдлыг хүлээн авч шийдвэрлэх үүрэг бүхий Амьжиргааг дэмжих орон тооны бус зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ сум, хороонд ажиллана.</p>

**Дүгнэлт:** Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 24.2 дахь хэсэгт зааснаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг заавал хамт олонд түшиглэсэн үйлчилгээнд хамруулах үүрэгтэй, гэхдээ ийнхүү хамруулах үндэслэл нь комиссын дүгнэлт байхаар заасан нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 27.1 дэх хэсэгтэй зөрчилдөж байна. Учир нь, Нийгмийн халамжийн тухай хуулийн 27.1 дэх хэсэгт зааснаар олон нийтийн оролцоонд түшиглэсэн үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хамруулах эсэхийг Амьжиргаа дэмжих зөвлөл шийдвэрлэхээр заасан.

Д/д	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /2016 он/	Нийгмийн халамжийн тухай хууль /2012 он/
9.	<p><b>32 дугаар зүйл. Бие даан амьдрах эрх</b></p> <p>32.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүн бие даан амьдрах эрхтэй.</p> <p>32.2.Хувийн туслах үйлчилгээ, <b>зөвлөлдөх бүлэг буюу харилцан</b></p>	<p><b>18 дугаар зүйл.Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ</b></p> <p>18.1.Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ нь дараах төрөлтэй байна:</p> <p>18.1.1.амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох,</p>

<p><b>суралцах, зөвлөгөө өгөх үйлчилгээгээр</b> хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрах эрх нь хангагдана.</p> <p>32.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүн бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журам, төрөл, хэлбэр, үйлчилгээ үзүүлэх байгууллагад тавигдах шаардлагыг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p> <p>32.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүн бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээг иргэн, хуулийн этгээд үзүүлж болно.</p>	<p>авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах;</p> <p>18.1.2.зөвлөгөө өгөх;</p> <p>18.1.4.түр байрлуулан асрамжлах, хүчирхийлэлд өртсөн хүнийг түр хамгаалан байрлуулах;</p> <p><u>/Энэ заалтад 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/</u></p> <p>18.1.5.өдрийн үйлчилгээнд хамруулах;</p> <p>18.1.6.гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах;</p>
<p><b>Дүгнэлт:</b> Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 32.2 дахь хэсэгт бие даан амьдрах эрх нь хувийн туслах үйлчилгээ, зөвлөлдөх, суралцах, зөвлөгөө өгөх хэлбэрээр дамжин хэрэгжинэ гэжээ. Энэ нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1, 18.1.2 дахь хэсэгтэй агуулгын хувьд ижил байгаа боловч Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд олон нийтийн оролцоонд түшиглэсэн үйлчилгээг бие даан амьдрах эрх гэж өөр хэлбэрээр оруулсан нь ойлгомжгүй байна.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журмыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/184 дүгээр тоот тушаалаар баталсан бөгөөд уг журамд:</p> <p>2.1.1. <i>“Хувийн туслагч” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх ур чадвар бүхий, асаргаа үйлчилгээ, туслахын сургалтад хамрагдсан гэрчилгээтэй, насанд хүрсэн хүнийг;</i></p> <p>2.1.2. <i>“Харилцан суралцах, зөвлөгөө (бүлгийн болон ганцаарчилсан)” гэж хувь хүний өөрийгөө үнэлэх үнэлэмж, амьдрах итгэлийг нэмэгдүүлэх зорилгоор ижил нөхцөлд байгаа хүмүүс харилцан мэдээлэл солилцох, туршлагаа хуваалцах, бие биенээ дэмжих үйл ажиллагааг;</i></p> <p>2.1.3. <i>“Түр байрлуулах” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүнийг амьдралын итгэл үнэмшил олгох, бие даан амьдрах мэдлэг чадварт сургах зорилгоор өөртэйгээ ижил бэрхшээлтэй хүмүүсийн дунд түр байрлуулан сургалт, үйлчилгээнд хамруулах; гэж тодорхойлжээ.</i></p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 32.4-д “Хөгжлийн бэрхшээлтэй хүн бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээг иргэн, хуулийн этгээд үзүүлж болно” гэж заасан нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.5-д “Аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь энэ хуулийн 17.1-д заасан үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно”, 18.6-д “Энэ хуулийн 18.5-д заасан иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах ажлыг аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага гүйцэтгэнэ” зэргээр зохицуулсан байгаа нь агуулгын хувьд давхардаж байна.</p> <p>Мөн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 32.2-д “Хувийн туслах үйлчилгээ, зөвлөлдөх бүлэг буюу харилцан суралцах, зөвлөгөө өгөх үйлчилгээгээр хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрах эрх нь хангагдана” гэсэн бол өгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журмын 2.1.3-д түр байрлуулах гэдэг</p>	

ойлголт оруулсан нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 32.2 дахь хэсэгтэй зөрчилдөж байна.

Д/д	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /2016 он/	Нийгмийн халамжийн тухай хууль /2012 он/
10.	17.6.Холбогдох хуульд заасан шалгуурыг ханган, нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авах эрх үүссэн хөгжлийн бэрхшээлтэй хүний халамжийн тэтгэврийг Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу зохицуулна.	<b>12 дугаар зүйл.Нийгмийн халамжийн тэтгэвэр</b> 12.1.Нийгмийн халамжийн тэтгэвэр /цаашид “тэтгэвэр” гэх/-ийг нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасны дагуу бүрэн болон хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэвэр авах эрх үүсээгүй дараах иргэнд сар бүр олгоно:

**Дүгнэлт:** Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 17.6 дахь хэсэгт нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авах эрх үүссэн хүний харилцааг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиар зохицуулахаас Нийгмийн халамжийн тухай хуулиар зохицуулахгүй гэдгийг Нийгмийн халамжийн тухай хуулийн 12.1 дэх хэсэгт заасан. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 17.6 дахь хэсэг нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 12.1 дэх хэсэгтэй зөрчилдөж байна. Мөн өндөр насны тэтгэврийг нийгмийн даатгалын сангаас авах эрх үүссэн бол халамжийн сангаас олгох тэтгэвэр авах боломжгүй.

Д/д	Боловсролын тухай хууль /2002 он/
11.	43.1.8.ерөнхий боловсролын сургуулийн эмч, бага ангийн багшид <b>Хөгжлийн</b> бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 7.8-д заасан нэмэгдлийг <b>хөгжлийн</b> бэрхшээлтэй хүүхдийн тооноос хамаарч сар бүр олгох;

**Дүгнэлт:** Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйл нь хөгжлийн бэрхшээлийн талаар мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх гэсэн нэртэй, 3 хэсэгтэй болно. Өөрөөр хэлбэл, 7 дугаар зүйлд 8 дахь хэсэг байхгүй.

Д/д	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /2016 он/	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /2016 он/
12.	<b>25 дугаар зүйл. Нийгмийн хамгаалал хүртэх эрх</b> 25.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүн хоол хүнс, хувцас, орон байр, эмчилгээ сувилгаа, нийгэм ахуйн зайлшгүй шаардлагатай үйлчилгээг оролцуулаад өөрийн болон гэр бүлийнхээ эрүүл мэнд, аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрхтэй бөгөөд энэхүү эрхийг хангах зорилгоор төрөөс дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:  25.1.1.хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээнд тохирсон тусгай хэрэглээний протез, ортопед, ариун цэвэр-эрүүл ахуйн материал, асаргаа	<b>26 дугаар зүйл. Нийгмийн халамжийн сангаас хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх тусламж, хөнгөлөлт</b> 26.1.Энэ хуулийн 3.1-д заасан хүнд нийгмийн халамжийн сангаас доор дурдсан тусламж, хөнгөлөлт үзүүлнэ:

<p>сувилгааны болон бусад туслах хэрэгслээр хангах;</p> <p>25.1.2.хөгжлийн бэрхшээлтэй эцэг, эх хүүхдээ өсгөн хүмүүжүүлэхэд нь шаардлагатай дэмжлэг үзүүлж, туслах үйлчилгээ авах боломжоор хангах;</p> <p>25.1.3.хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгмийн хамгааллын болон нийгмийн халамжийн хөтөлбөрт хамруулах.</p> <p>25.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг халамжийн, түрээсийн, ипотекийн зээлд хөнгөлөлттэй нөхцөлөөр хамруулах орон сууцны хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний болон аймаг, нийслэлийн Засаг даргын жил бүрийн төсөвт тусгана.</p> <p>25.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт, нийгмийн даатгалд хамруулах асуудлыг Монгол Улсын хууль тогтоомжоор зохицуулна.</p>	
--	--

**Дүгнэлт:** Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 25 дугаар зүйлд нийгмийн хамгаалалд хамрагдах боломжийг төрөөс хангах чиглэлийг заасан. Харин 26 дугаар зүйлд төрөөс үзүүлэх үйлчилгээний төрлийг тогтоосон. Иймд, агуулгын хувьд 25 дугаар зүйл дэх чиглэлийг 26 дугаар зүйлд нарийвчлан зохицуулсан байна. 25 дугаар зүйл нь чиглэлийг зааснаас ямар этгээд хэрэгжүүлэх, хэлбэр нь ямар байх нь тодорхойгүй байна.

Д/д	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /2016 он/	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль /2017 он/
13.	29.1.4.гэрч, хохирогчийг хамгаалах байр нь хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог, хэрэгцээ шаардлагад нийцсэн байх.	35.10.Түр хамгаалах байрны стандартыг стандартчилал ,техникийн зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, түр хамгаалах байрны үйлчилгээ үзүүлэх журмыг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тус тус батална. /Энэ хэсгийн 2017 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

**Дүгнэлт:** Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 29.1.4 дэх зохицуулалт нийтлэг зохицуулалт байх бөгөөд үүнийг нарийвчилсан журам, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 35 дугаар зүйлээр зохицуулна. Хууль зүйн сайдын 2014 оны А/114 дүгээр тушаалын хавсралтаар “Гэрч, хохирогчийг аюулгүй газарт түр байрлуулах, аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журмыг баталсан ба уг журамд:

1.4.Гэрч, хохирогчийг түр байрлуулах хамгаалалтын байр нь MNS 6040:2009 Монгол Улсын стандартаар тавигдах шаардлагыг хангасан байна.

1.5.Тусгай хамгаалах болон хамгаалах байр нь эрэгтэй, эмэгтэй, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй, гэр бүлийн хүмүүс байрлах тусгай өрөөнүүдтэй байна зэргээр зохицуулсан.

### 5.3. Хуулийн зүйл, заалт, зохицуулалт нь хэл зүйн найруулгын хувьд салаа утгатай эсэх

Д/д	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /2016 он/
1.	17.5.Цалин хөлс олгож байгаа шалтгаанаар хөдөлмөр эрхэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн халамжийн болон нийгмийн даатгалын аливаа тэтгэвэр, тэтгэмжийг зогсоохыг хориглоно.
<p><b>Дүгнэлт:</b> Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 17.5 дахь хэсэгт “нийгмийн халамжийн болон нийгмийн даатгалын аливаа тэтгэвэр, тэтгэмжийг зогсоохыг хориглоно” гэж заасан бөгөөд энэ нь хэн зогсоохыг тодорхойлоогүй, мөн ийнхүү зогсоох боломжгүй билээ. Учир нь, цалин хөлс авч байгаа бол Нийгмийн даатгалын тухай хуулийн 2<sup>1</sup> дугаар зүйлийн 2.1.1-д заасан даатгуулагч болно. Хэрэв даатгуулагч бол Нийгмийн даатгалын тухай хуулийн 6.1 дэх хэсэгт зааснаар нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан болзол журмын дагуу шимтгэл төлж нийгмийн даатгалд даатгуулсан иргэн хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж авах эрх үүсэх бөгөөд үүнийг зогсоох боломжгүй.</p>	

### 5.4. Хуулийн зүйлийн нэр тухайн зүйлд байгаа хэсэг, заалтын агуулгын нийлбэртэй нийцэж байгаа эсэх

Д/д	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /2016 он/
1.	<p><b>29 дүгээр зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эрх</b></p> <p>29.1.Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн тэгш эрхийг боловсрол, хөдөлмөр, нийгэм, эдийн засгийн салбарт хангах зорилгоор төрөөс дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:</p> <p>29.1.1.хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудал, хэрэгцээг үнэлж, тэдгээрийн онцлогт тохирсон үйлчилгээ үзүүлэх;</p> <p>29.1.2.хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, дарамтанд өртөх, гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үр дүнтэй арга хэмжээ авах;</p> <p>29.1.3.гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, гэмт хэрэгт өртсөн хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд үзүүлэх эрүүл мэнд, хууль зүйн, сэтгэл зүйн болон бусад шаардлагатай үйлчилгээг тэдгээрийн сэтгэл зүй, нас бие, сэтгэхүйн онцлогт нийцүүлэн мэргэшлийн түвшинд чанартай үзүүлэх;</p> <p>29.1.4.гэрч, хохирогчийг хамгаалах байр нь хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог, хэрэгцээ шаардлагад нийцсэн байх.</p>
<p><b>Дүгнэлт:</b> Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эрхийн талаар заасан боловч агуулга нь гэр бүлийн хүчирхийлэлд өртөх магадлалтай өртсөн эмэгтэйчүүдэд үзүүлэх тусламжийн талаар заасан нь зүйлийн нэр нь агуулгатай нийцэхгүй байна. 29.1 дэх хэсэгт “Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн тэгш эрхийг боловсрол, хөдөлмөр, нийгэм, эдийн засгийн салбарт хангах зорилгоор төрөөс дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ” гэж заагаад харин агуулга нь зөвхөн хүчирхийллээс хамгаалах талаар заасан байна. Хуулийн 29.1.1-29.1.4 дэх заалтад заасан арга хэмжээг хэн хэрэгжүүлэх нь тодорхойгүй байна.</p>	

Харин Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 20 дугаар зүйлд хамтарсан багийн талаар зохицуулж, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 29.1.2-29.1.3 дахь заалтад заасан үүргийг хамтарсан баг хэрэгжүүлэхээр зохицуулсан.

Д/д	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /2016 он/
2.	<p><b>43 дугаар зүйл. Хуулийн этгээдийн нийтлэг эрх, үүрэг</b>            43.1.Хуулийн этгээд нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр дараахь нийтлэг эрх, үүрэгтэй:</p> <p><b>43.1.1.хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээ шаардлагад нийцсэн ажиллах орчныг бүрдүүлэх;</b></p> <p>43.1.2.хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй орчин бүрдүүлэхдээ олон улсын чиг хандлагын дагуу түгээмэл загвар хэрэглэхийг эрхэмлэх;</p> <p>43.1.3.нийтийн зориулалттай үйлчилгээний болон бусад байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүнд дараалал харгалзахгүй үйлчлэх;</p> <p>43.1.4.хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн амьдралын идэвхтэй оролцоо, түүний амжилт, бүтээлийг хамт олонд нь сурталчлах, урамшуулах;</p> <p><b>43.1.5.хөгжлийн бэрхшээлтэй болсон хүнд түүнийг ажиллуулж байсан байгууллагын хувьд тусламж, дэмжлэг үзүүлэх;</b></p> <p><b>43.1.6.өөрчлөн зохион байгуулагдсан буюу татан буугдсан бол түүний эрх, үүргийг хүлээж авсан этгээд энэ хуулийн 43.1.5-д заасан эрх, үүргийг хэрэгжүүлэх;</b></p> <p>43.1.7.хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй зүй бусаар харилцах, эрх, эрх чөлөөг нь аливаа хэлбэрээр зөрчихийг үл тэвчих;</p> <p><b>43.1.8.ажилтан тухайн байгууллагын буруутай үйл ажиллагааны улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон нь шүүхээр тогтоогдсон бол хохирлыг нөхөн төлөх;</b></p> <p><b>43.1.9.хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны стандартыг хангаж ажиллах;</b></p> <p>43.1.10.хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.</p>
	<p><b>Дүгнэлт:</b> Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 43 дугаар зүйлд хуулийн этгээдийн хүлээх нийтлэг үүрэг гэсэн боловч зүйлийн агуулга нь ажил олгогчийн нийтлэг үүргийг заажээ. Уг зүйлийн 43.1.1, 43.1.5, 43.1.6, 43.1.8, 43.1.9 дэх заалт нь ажил олгогчид хамаарах зохицуулалт байна.</p>

### 5.5. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хийдэл

1. Тухайн хуульд тодорхой харилцааны нарийвчилсан зохицуулалтыг батлах эрхийг төрийн бусад байгууллагад шилжүүлсэн бол уг нарийвчилсан зохицуулалт батлагдсан эсэх

Д/д	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /2016 он/	Батлагдсан эсэх
1.	8.2.Нийтийн тээвэр, харилцаа холбоо, нийтийн үйлчилгээ, барилга байгууламжийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй болгох, хиймэл эрхтэн, туслах болон	

	асаргаа сувилгаа, ариун цэвэр-эрүүл ахуйн материал, хэрэгсэл, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлж байгаа иргэн, хуулийн этгээдийг дэмжих хөтөлбөрийг Засгийн газар батална.	
2	9.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцсэн авто болон явган хүний зам, замын байгууламжийн заавал дагаж мөрдөх үндэсний стандартыг барилга, зам, тээвэр, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн стандартчиллын байгууллага батална.	“Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам.Техникийн шаардлага” MNS 5682:2006  “Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар” MNS 6056:2009
3	9.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй буюу түүний хэрэгцээ, шаардлагад нийцсэн нийгмийн дэд бүтэц, орон сууц, олон нийтийн барилга байгууламжийн орчны болон дотоод зохион байгуулалтын заавал дагаж мөрдөх үндэсний стандартыг барилгын болон хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн стандартчиллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.	Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин.Үндсэн шаардлага” MNS 6055:2009
4	10.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээнд нийцсэн нийтийн тээврийн хэрэгсэл, зогсоол, үйлчилгээний заавал мөрдөх үндэсний стандартыг тээвэр, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн стандартчиллын байгууллага батална.	“Нийтийн тээвэр Замналын зогсоол. Ангилал. Техникийн шаардлага” MNS 5879-2012  “Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолын төлөвлөлт” БД 32-101-17
5	12.2.Монгол дохионы хэлний хэлмэрч, орчуулгын үйл ажиллагаа эрхлэх, үйлчилгээ үзүүлэх журмыг боловсролын болон хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.	--
6	13.2.Брайль үсгийн стандартыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын	-

	саналыг үндэслэн стандартчиллын төв байгууллага батална.	
7	14.5.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургах, хөгжүүлэх, бүх шатны боловсрол олгох үндэсний хөтөлбөр, төлөвлөгөөг Засгийн газар батална.	
8	<p>15.2.Бүх шатны сургалтын байгууллагын хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирох хэрэглэгдэхүүн, сургалтын орчныг бүрдүүлэх журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.</p> <p>15.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол олгох сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.</p> <p>15.4.Хавсарсан хөгжлийн бэрхшээлтэй болон байнгын асаргаа шаардлагатай хүүхдийн ганцаарчилсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг тухайн сургалтын байгууллагын мэргэжил арга зүйн зөвлөл, эцэг эхийн оролцоотойгоор боловсруулж батална</p>	<p>Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2013 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн “Сургалтын төлөвлөгөө, хичээлийн жилийн бүтцийг шинэчлэн батлах тухай” А/311 дүгээр тушаалын дөрөвдүгээр хавсралтаар “Оюуны бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн сургалтын төлөвлөгөө”, тавдугаар хавсралтаар “Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн сургалтын төлөвлөгөө”, зургаадугаар хавсралтаар “Харааны бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн сургалтын төлөвлөгөө”-г тус тус баталсан.</p> <p>15.4 батлагдаагүй</p>
9	<p>15.8.Энэ хуулийн 15.6-д заасан сургалтын зардлын хэмжээ, олгох журмыг Засгийн газар батална.</p> <p>15.9.Энэ хуулийн 15.7-д заасан ном, сурах бичиг, тусгай хэрэглээний сургалтын тоног төхөөрөмж, хэрэгслийн жагсаалт, зардлын хэмжээ, олгох журмыг боловсрол болон хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.</p> <p>15.12.Ерөнхий боловсролын тусгай сургуулийн суралцагчийн үдийн хоолны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж, үдийн хоолоор үйлчлэх журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.</p>	
10	18.1.5.мэргэжлийн ур чадварын олон улсын тэмцээнд амжилттай оролцсон хөгжлийн бэрхшээлтэй	“Мэргэжлийн ур чадварын олон улсын тэмцээнд амжилттай оролцсон хөгжлийн бэрхшээлтэй хүнд урамшуулал олгох ба урамшуулал олгох журам”



	хүнд урамшуулал олгох ба урамшуулал олгох журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлах;	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/212 дугаар тушаал
11	<p>23.3.Энэ хуулийн 22.1-д заасан үйлчилгээний стандартыг тухайн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулж, стандартчиллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.</p> <p>23.4.Энэ хуулийн 22.1-д заасан үйлчилгээг эрхлэх байгууллагад тавигдах шаардлагыг тухайн асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран боловсруулж батална.</p>	
12	26.4.Энэ хуулийн 26.1.1, 26.1.2, 26.1.3, 26.1.4, 26.1.5, 26.1.6-д заасан тусламж, хөнгөлөлтийн хэмжээ, олгох журам, жишиг үнийг Засгийн газар батална.	Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам” Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоол
13	<p>32.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүн бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журам, төрөл, хэлбэр, үйлчилгээ үзүүлэх байгууллагад тавигдах шаардлагыг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p> <p>32.7.Төрөөс хараагүй хүнийг тухайн орчинд зөв чиг баримжаатай, саадгүй, аюулгүй зорчиход нь туслах хөтөч нохойг тусгайлан сургаж бэлтгэх ба дотоодод сургаж бэлтгэсэн хөтөч нохойны үнийг есөн жилд нэг удаа олгоно. Хөтөч нохойг сургах, түүнийг хэрэглэх журмыг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хөдөө аж ахуйн асуудал</p>	<p>“Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журам” Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/184 дүгээр тоот тушаал</p> <p>“Хөтөч нохойг сургах, ашиглах журам”-ыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2017 оны А/213, А/166 дугаар хамтарсан тушаал</p>

	эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.	
14	<p>37.5.Энэ хуулийн 37.2.1-37.2.3-т заасан комиссын дүрмийг Засгийн газар батална.</p> <p>37.6.Энэ хуулийн 37.2.1-д заасан хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тодорхойлох, хүүхдийн хөгжлийн цогц хөтөлбөрийг боловсруулах аргачлалыг эрүүл мэнд, боловсрол, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.</p> <p>37.7.Энэ хуулийн 37.2.2-т заасан хүний хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тодорхойлох аргачлалыг эрүүл мэнд, хөдөлмөр, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.</p>	<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрэм” Засгийн газрын 2016 оны 200 дугаар тогтоол</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам” Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоол</p>
15	38.4.Энэ хуулийн 38.1-д заасан үнэмлэхийн загвар, түүнийг олгох журмыг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	“Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үнэмлэх олгох журам, үнэмлэхийн загвар” Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/109 дүгээр тушаал
16	<p>39.1.Засгийн газар хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>39.1.3.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах талаар үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө баталж, хэрэгжүүлэх;</p>	Засгийн газрын 2017 оны 321 дүгээр тогтоолын хавсралт “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, Хөгжлийг дэмжих үндэсний Хөтөлбөр”
17	41.2.Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Засгийн газар батална.	-
<b>Дүгнэлт:</b> Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд зааснаар нийтээр дагаж мөрдөх нийт 25 журам, стандарт батлагдахаас 15 журам, стандарт батлагдсан байна.		

2. Хуульд заасан хориглосон зохицуулалт нь түүнийг зөрчигсдөд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх

Д/д	<b>Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /2016 он/</b>
-----	--

1.	9.5.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагыг хангаагүй барилга байгууламжийг улсын комисс хүлээж авахыг хориглоно.
<b>Дүгнэлт:</b> Дээрх хориглосон зохицуулалтад хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хуулийн 12.1 дэх хэсэгт тусгаагүй байна.	

<b>Д/д</b>	<b>Авто тээврийн тухай хууль /1999 он/</b>
2.	10.2.8. “20-иос дээш тооны тээврийн хэрэгсэл бүхий аж ахуйн нэгж нь тээврийн хэрэгслийнхээ 10 хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай төхөөрөмж суурилуулсан байх”
<b>Дүгнэлт:</b> Хуульд заасан хувь хэмжээнд хүргээгүй тохиолдолд торгууль ноогдуулна гэсэн заалттай ч торгуулийн хэмжээг заагаагүй байна. Зөрчлийн тухай хуульд энэ талаар заагаагүй байна.	

<b>Д/д</b>	<b>Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /2016 он/</b>	<b>Хариуцлага тодорхой эсэх</b>
3	6.1.Хүн бүр хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран хууль, шүүхийн өмнө эрх тэгш байж, үндсэн эрх, эрх чөлөөгөө эдлэн, нийгмийн баялгаас адил хүртэх эрхтэй. Хүнийг хөгжлийн бэрхшээл болон эрүүл мэндийн байдлаар нь ялгаварлан гадуурхахыг <b>хориглоно</b>	
4	9.5.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагыг хангаагүй барилга байгууламжийг улсын комисс хүлээж авахыг <b>хориглоно</b> .	-
5	7.5.Цалин хөлс олгож байгаа шалтгаанаар хөдөлмөр эрхэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн халамжийн болон нийгмийн даатгалын аливаа тэтгэвэр, тэтгэмжийг зогсоохыг <b>хориглоно</b> .	<b>10.16 дугаар зүйл.Хөдөлмөрийн тухай хууль зөрчих</b> 1.Хуульд заасны дагуу ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд <b>хөгжлийн</b> бэрхшээлтэй, эсхүл одой хүнийг ажиллуулах үүрэгтэй аж ахуйн нэгж, байгууллага сар бүр төлбөр төлөх үүргээ биелүүлээгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
6	28.7.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үүргийг тэдний эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хүлээх бөгөөд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид нь хөгжлийн бэрхшээлтэй	-

	хүүхдээ асран хамгаалах, тэжээн тэтгэх хуулиар хүлээлгэсэн үүргээ биелүүлэхээс зайлсхийхийг <b>хориглоно</b> .	
7	31.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчилгээ үзүүлж байгаа аливаа этгээд хөгжлийн бэрхшээлтэй хүний нууцыг задруулахыг <b>хориглоно</b> .	-
<p><b>Дүгнэлт:</b> Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд хориглосон 5 зохицуулалт байгаа бөгөөд Зөрчлийн тухай хуульд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хориглосон зохицуулалтад шууд хамаарах 1 зохицуулалт байгаа бөгөөд харин Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиар шууд хориглоогүй дараахь зохицуулалтад Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэхээр байна.</p> <p><u>6.20 дугаар зүйл.Хүүхдийн эрхийг зөрчих</u></p> <p>1.Хүүхдийн эрхийг зөрчиж:</p> <p>8.Хүүхдийг хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан ялгаварлан гадуурхсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p><u>12.5 дугаар зүйл.Хот байгуулалтын тухай хууль зөрчих</u></p> <p>2.Хот байгуулалтын тухай хуульд заасан:</p> <p>2.2.хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтэц бий болгох журам зөрчсөн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p>		

### 3. Тодорхой эрх, үүргийг хэрэгжүүлэх субъект нь тодорхой эсэх

Д/д	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /2016 он/	
1.	28.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг нийгмийн хамгааллын болон нийгмийн халамжийн тусламж, үйлчилгээнд хамруулна.	
<p><b>Дүгнэлт:</b> ...нийгмийн хамгааллын болон нийгмийн халамжийн тусламж, үйлчилгээнд хамруулна... гэж заасан бөгөөд ямар этгээд хамруулах нь тодорхой биш байна. Нийгмийн хамгаалал гэдэгт нийгмийн даатгал, нийгмийн халамжийн үйл ажиллагаа хамаарах бөгөөд 28.3 дахь хэсэгт заасан үндэслэлд нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээнд хамрагдах эрх үүснэ.</p> <p><b>Санал:</b> 28.3 дахь хэсгийн нийгмийн хамгааллын гэдгийг хасах.</p>		

Хуулийн төсөлд заагдсан нийт субъектүүдийн жагсаавал давхардсан тоогоор 47 өөр субъектүүд заагдсан байх бөгөөд нэг субъектыг өөрөөр нэрлэсэн, эсхүл тухайн субъект хэн болох нь тодорхойгүй байдлыг залруулах шаардлагатай байна. Мөн түүнчлэн аж ахуйн нэгж, хувийн хуулийн этгээдийг үүрэгжүүлсэн заалт 15 зүйлд байна. Энэ хуульд заасан үүргийг хүлээн авч хэрэгжүүлэхэд ойлгомжтой бус, хэрэв үүрэг хэрэгжүүлсэний төлөө төрөөс үзүүлэх дэмжлэг нь татварын, урамшууллын байдлаар шууд илрэх үр нөлөө нь тодорхойгүй байна. Мөн “холбогдох байгууллага”, “эрх бүхий байгууллага” гэдэг нь хариуцах этгээдийг бүрхэг болгосон томъёолол байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллага гэдэг нэр томъёог тодорхой болгох шаардлагатай, хуульд ийм төрлийн төрийн бус байгууллагад санхүүжилтээр тодорхой чиг

үүрэг гүйцэтгэхээр заасан байгаа тул энэ ойлголт, шалгуурыг нэгдмэлээр тодорхойлсон байх ёстой.

Хуульд заасан субъектүүдийн жагсаалт:

1. Төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээд 7.1.1, 17.3, 17.4, төрийн байгууллага 8.3, төрөөс иргэн, хуулийн этгээдтэй хамтран 9.1, 11.2.1, 11.4, 19.1, 19.3, 14.1, 14.3, төрөөс 18.1,18.1.1,18.1.2,18.1.4,18.1.6, 20.1, 22.2, 25.1,27.2, 28.1, 28.2,28.3) 28.6, 29.1 (29.1.1-29.1.4) 33.2, 33.3, 33.4, 34.1, өмчийн бүх хэлбэрийн байгууллага 23.1, аж ахуйн нэгж, байгууллага 34.2, Төрийн холбогдох байгууллага -36,
2. иргэн, хуулийн этгээд 32.4, хуулийн этгээд -43
3. МҮОНТВ – 7.1.2
4. Бүх шатны боловсролын байгууллага – 7.1.3, 14.2, 14.3.1,
5. БСШУСЯам 7.1.5, 14.3.2, 15.2, 15.3, 15.7,
6. ХБИ, тэдний эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага - 7.2,32.6,
7. Засгийн газар -8.2, 14.5,15.8, 26.4, 33.5,37.5, 38.4, 39
8. БХБЯ, ЗТЯ, МХЕГ, ЭМЯ, ХНХЯ, аймаг, нийслэл, дүүрэг – 8.4,
9. БСШУСЯ, ХНХЯ хамтран 12.2, 15.9, 15.11, 15.12, 35.2,
10. СХЗТ – 9.2, БСШУСЯ-ны саналыг үндэслэн 9.3, 10.2, 13.2, салбарын яамд, ХНХЯ-тай хамтран 23.3
11. БХБЯ, НЕТГ – 9.4,
12. ХХМТГ, ХХЗХ, мэдээллээр үйлчилдэг хуулийн этгээд – 11.1, 11.2.1-11.2.6, ХХМТГ - 11.3,
13. Нийтийн тээврийн байгууллага – 10.1, Нийслэл, аймгийн төвийн нийтийн тээврийн хэрэгсэл 32.8
14. Бүх шатны боловсролын байгууллага болон мэргэжил олгох төв 15.1 15.1.1-15.1.8
15. Эцэг эх, харгалзан дэмжигч, боловсролын байгууллагын ажилтан болон нийгмийн ажилтан– 14.4, эцэг, эх, харгалзан дэмжигч -24.2, 28.7,
16. Сургалтын байгууллагын мэргэжил арга зүйн зөвлөл -15.4
17. Сургууль, цэцэрлэгийн удирдлага -15.5
18. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга – 15.10, 42
19. Багш бэлтгэдэг их, дээд сургууль, коллеж – 16.1
20. Төрийн сан – 16.4
21. ХЭДС -18.1.3
22. ХНХЯ -18.1.5, 40,
23. Эрүүл мэндийн байгууллага - 20.1,
24. ЭМЯ - 20.2
25. Салбарын сайд ХНХсайдтай хамтран -23.4,
26. Тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага - 23.2,
27. Хамт олонд түшиглэсэн үйлчилгээ үзүүлэх байгууллага – 24.1
28. ХНХсайдын болон аймаг, нийслэлийн Засаг дарга 25.2,
29. ХНХсайд 32.3,
30. Нийгмийн халамжийн сан - 26.1.1-26.1.16,
31. Шүүх, прокурор, хууль хяналтын байгууллага – 27.1,27.3,27.4
32. Боловсролын болон төрийн эрх бүхий холбогдох байгууллага – 28.4,
33. Тэтгэвэр төлөгч -28.8

34. Сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигч – 30.2,
35. Улс төрийн нам, эвсэл, төрийн байгууллагууд 30.3 , улс төрийн нам эвсэл 30.4
36. Нийслэл, аймгийн ХХҮХ – 32.5
37. ХНХЯ, ХХАХҮЯ хамтран - 32.7
38. Биеийн тамир, спортын байгууламж бүхий этгээд -33.3.2
39. Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс -37.2.1
40. Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс -37.2.2,37.2.3, 37.8, 37.9,
41. ЭМЯ, ХНХсайд хамтран -37.7
42. Аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ -38.1, 38.3,
43. ҮСХ, ХНХЯ хамтран - 38.5
44. Үндэсний зөвлөл – 41
45. Төлөөлөгч – 44.2

### 5.6. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой батласан эрх зүйн актын уялдаа

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг УИХ-аас 2016 онд батлагдан хэрэгжиж эхэлснээс хойш уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд зааснаар нийтээр дагаж мөрдөх нийт 25 журам, стандарт батлагдахаас 15 журам, стандарт батлагдсан байна. Гэтэл эдгээр холбогдох зарим хууль, журамтай зөрчилдөж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн дагуу батлагдах хэм хэмжээний актыг дараах байдлаар ангилж болно:



Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль дахь нийтээр дагаж мөрдөх актыг дараах байдлаар бүлэглэж болно:

- Нийгмийн халамжтай холбоотой-5 (23.3-23.4, 26.4, 32.3, 32.7 )
- Боловсролын харилцааг зохицуулсан-8 (12.2, 13.2, 14.5, 15.2-15.3, 15.8, 15.9, 15.12)
- Эрүүл мэндийн харилцааг зохицуулсан-4 (37.5-37.7, 38.4)
- Амьдрах орчин нөхцлийг зохицуулсан- 4 (8.2, 9.2-9.3, 10.2)

#### Нийгмийн халамжтай холбоотой журам:

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн гол чиглэл нь хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн хамгаалал буюу халамжийн харилцааг түлхүү зохицуулсан байгаа бөгөөд энэ харилцааг зохицуулсан зохицуулалт нь Нийгмийн халамжийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарсан эрх зүйн баримт бичигтэй зөрчилдөх тохиолдол байна. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2012 оны А/87 тоот тушаалаар батлагдсан Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа ахмад настан, 18 ба түүнээс дээш

насны хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тэтгэвэр олгох журмыг баталсан. Энэ нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 19.5 дахь хэсэгт заасан зардлыг төрөөс гаргуулахад баримтлах нөхцлийг тогтоож өгсөн. Гэтэл үүнийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 26.1.15-26.1.16 дахь заалтад тусламж, хөнгөлөлтөд хамааруулсан байгаа нь ойлгомжгүй юм. Учир нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан төрөлжсөн асрамжийн үйлчилгээ авах эрх нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хамаарахын заасан, үүнийг тэтгэвэр хэлбэрээр олгохоор журамласан атал, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нарийвчлан зохицуулсантай зөрчилдөж байна. Иймд, дээрх журмаас хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэдгийг хүчингүй болгох шаардлагатай.

Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газрын даргын 2012 оны 162 тоот тушаалаар баталсан Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээний журам үйлчилж байна. Энэ журам нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хамаарна. Энэ журам нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.1.6, 13.2 дахь хэсэгт заасан зохицуулалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарсан. Нэгэнт хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн халамжид хамруулах талаар Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.2, 18.1.6 дахь заалтад заасан атал үүнийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 25.1.2 дахь заалтад нийтлэг байдлаар оруулах нь ойлгомжгүй юм.

№	Нийгмийн халамжийн тухай хууль	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль	Асаргаа, сувилгааны болон асрамжлах үйлчилгээний ур чадвар эзэмшүүлэх сургалт зохион байгуулах журам
1	<p>13.2.Асаргааны тэтгэмжийг дараах иргэнд олгоно:</p> <p>13.2.3.тэжээн тэтгэх хүүхэдгүй, ганц бие ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй ганц бие иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа;</p> <p>13.2.4.эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнийг асарч байгаа.</p> <p>13.9.Энэ хуулийн 13.2-т заасан иргэнийг асаргаа, сувилгааны болон асрамжлах үйлчилгээний ур чадвар эзэмшүүлэх сургалтад хамруулах бөгөөд уг сургалтын зардлыг нийгмийн үйлчилгээний сангаас санхүүжүүлнэ.</p> <p>13.10.Энэ хуулийн 13.9-д заасан сургалтыг зохион</p>	<p><b>25 дугаар зүйл. Нийгмийн хамгаалал хүртэх эрх</b></p> <p>25.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүн хоол хүнс, хувцас, орон байр, эмчилгээ сувилгаа, нийгэм ахуйн зайлшгүй шаардлагатай үйлчилгээг оролцуулаад өөрийн болон гэр бүлийнхээ эрүүл мэнд, аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрхтэй бөгөөд энэхүү эрхийг хангах зорилгоор төрөөс дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:</p> <p>25.1.2. хөгжлийн бэрхшээлтэй эцэг, эх хүүхдээ өсгөн хүмүүжүүлэхэд нь шаардлагатай дэмжлэг үзүүлж, туслах үйлчилгээ авах боломжоор хангах;</p>	<p>Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын даргын 2012 оны 165 дугаар тушаал</p>

байгуулах журам болон сургалтын хөтөлбөрийг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.		
Нийгмийн халамжийн тухай хуульд зааснаар асаргаа, сувилгаа, асрамжийн үйлчилгээний ур чадвар эзэмшүүлэх сургалтад хамруулах ёстой. Уг сургалт нь Асаргаа, сувилгааны болон асрамжлах үйлчилгээний ур чадвар эзэмшүүлэх сургалт зохион байгуулах журмаар зохицуулагдана. Нийгмийн халамжийн тухай хуульд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 25.1.2 дахь заалтыг нарийвчлан зохицуулж, улмаар журамласан.		

Амьдрах орчин нөхцлийг зохицуулсан журам:

№	<b>Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журам. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/184 дүгээр тоот тушаал</b>	<b>Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2012 оны А/91 тоот тушаалаар батлагдсан Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх журам</b>
1	<p>1.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-32.6-д заасан бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээ, түүнийг хэрэгжүүлэх байгууллагад тавих шаардлагыг энэхүү журмаар зохицуулна.</p> <p>1.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан нийгмийн амьдралд бусадтай адил тэгш оролцох боломжийг олгоход энэ журмын зорилго оршино.</p>	<p>1.1. Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.2-т заасан өрх, иргэнд тус хуулийн 18.1, 22.2.2-т заасан үйлчилгээ (цаашид “үйлчилгээ” гэх)-г иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллага (цаашид “үйлчилгээ үзүүлэгч байгууллага” гэх)-ын оролцоотойгоор үзүүлэхэд энэхүү журмыг баримтална.</p>
<p><b>Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын 2017 оны А/184 тоот тушаалаар</b> Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2012 оны А/91 тоот тушаалаар батлагдсан Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх журмыг хэрэгжүүлэх аргачлалыг баталсан. Дээрх хоёр журмын зохицуулалтын агуулга нь ижил үйлчилгээг зорилтот бүлэгт хүргэхэд чиглэх бөгөөд нэг нь зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэж хязгаарласан бол нөгөө журамд нь зорилтот бүлэг бүгд хамаарахаар байна.</p>		

Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журмыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/184 дүгээр тоот тушаалаар баталсан бөгөөд уг журамд:

2.1.1. “Хувийн туслагч” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх ур чадвар бүхий, асаргаа үйлчилгээ, туслахын сургалтад хамрагдсан гэрчилгээтэй, насанд хүрсэн хүнийг;

2.1.2. “Харилцан суралцах, зөвлөгөө (бүлгийн болон ганцаарчилсан)” гэж хувь хүний өөрийгөө үнэлэх үнэлэмж, амьдрах итгэлийг нэмэгдүүлэх зорилгоор ижил нөхцөлд байгаа хүмүүс харилцан мэдээлэл солилцох, туршлагаа хуваалцах, бие биенээ дэмжих үйл ажиллагааг;

2.1.3. “Түр байрлуулах” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүнийг амьдралын итгэл үнэмшил олгох, бие даан амьдрах мэдлэг чадварт сургах зорилгоор өөртэйгээ ижил бэрхшээлтэй



хүмүүсийн дунд түр байрлуулан сургалт, үйлчилгээнд хамруулах; гэж тодорхойлжээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 32.4-д “Хөгжлийн бэрхшээлтэй хүн бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээг иргэн, хуулийн этгээд үзүүлж болно” гэж заасан нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.5-д “Аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь энэ хуулийн 17.1-д заасан үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно”, 18.6-д “Энэ хуулийн 18.5-д заасан иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах ажлыг аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага гүйцэтгэнэ” зэргээр зохицуулсан байгаа нь агуулгын хувьд давхардаж байгаа. Мөн Хөгжлийн хүний эрхийн тухай хуулийн 32.2 дахь хэсэгт зааснаар Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журмыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/184 дүгээр тоот тушаалаар баталсан. Гэтэл энэ харилцааг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2012 оны А/91 тоот тушаалаар батлагдсан Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх журмаар зохицуулдаг. Уг журмаар хөгжлийн бэрхшээлтэй иргэн Нийгмийн халамжийн тухай хуульд заасан олон нийтийн оролцоонд түшиглэсэн үйлчилгээ авах боломжтой юм.

*Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль дахь нийгмийн халамжийн зохицуулалтад анхаарах зүйл:*

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 25 дугаар зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх дэмжлэгийг нийтлэг заасан бөгөөд энэ нь ойлгомжгүй бол үүнийг Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд төрөлжсөн асрамжийн үйлчилгээ гэж тогтоосон. Мөн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4.1.5 дахь заалтад заасан хамт олонд түшиглэсэн хамруулах үйлчилгээ нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.10 дахь заалтад заасан олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний шинжийг агуулж байна. Гэтэл энэ харилцааг зохицуулсан Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу гарсан Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2012 оны А/91 тоот тушаалаар батлагдсан Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх журмаар зохицуулдаг атал тухайн харилцааг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн дагуу гаргасан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/184 дүгээр тоот тушаалаар батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журмаар зохицуулж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 24.2 дахь хэсэгт зааснаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг заавал хамт олонд түшиглэсэн үйлчилгээнд хамруулах үүрэгтэй, гэхдээ ийнхүү хамруулах үндэслэл нь комиссын дүгнэлт байхаар заасан нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 27.1 дэх хэсэгтэй зөрчилдөж байна. Учир нь, Нийгмийн халамжийн тухай хуулийн 27.1 дэх хэсэгт зааснаар олон нийтийн оролцоонд түшиглэсэн үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хамруулах эсэхийг АДЗ шийдвэрлэхээр заасан.

Мөн үүнээс гадна Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль дахь зохицуулалтын нэр томъёог бусад хуультай уялдуулах шаардлага байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 17.6 дахь хэсэгт нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авах эрх үүссэн хүний харилцааг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиар зохицуулахаас Нийгмийн халамжийн тухай хуулиар зохицуулахгүй гэдгийг Нийгмийн халамжийн тухай хуулийн 12.1 дэх хэсэгт заасан. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 17.6 дахь хэсэг нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 12.1 дэх хэсэгтэй зөрчилдөж байна. Мөн өндөр насны тэтгэврийг

нийгмийн даатгалын сангаас авах эрх үүссэн бол халамжийн сангаас олгох тэтгэвэр авах боломжгүй.

*Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль дахь боловсролын зохицуулалтад анхаарах зүйл:*

Бага дунд боловсролын тухай хуулийн 13.3, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 9.12, Боловсролын тухай хуулийн 5, 42 дугаар зүйлд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд боловсрол хэрхэн олгох талаар нарийвчлан зохицуулсныг агуулгын хувьд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд төрөөс баримтлах бодлого хэлбэрээр тусгасан нь ойлгомжгүй байна.

*Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль зарим зохицуулалтад анхаарах зүйл:* Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 9.5 дахь хэсэгт “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагыг хангаагүй барилга байгууламжийг улсын комисс хүлээж авахыг хориглоно” гэсэн атал хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хуулийн 12.1 дэх хэсэгт тусгаагүй байна. Мөн Авто тээврийн тухай хуулийн 10.2.8. “20-иос дээш тооны тээврийн хэрэгсэл бүхий аж ахуйн нэгж нь тээврийн хэрэгслийнхээ 10 хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай төхөөрөмж суурилуулсан байх” гэж заасан бөгөөд хэрэв хуульд заасан хувь хэмжээнд хүргээгүй тохиолдолд торгууль ноогдуулна гэсэн заалттай ч торгуулийн хэмжээг заагаагүй байна. Зөрчлийн тухай хуульд энэ талаар заагаагүй байна.

## **VI. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

Монгол Улсын 2016 оны Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль нь нийт 12 бүлэг, 45 зүйлтэй. Энэхүү хуулийн хэрэгжилтийн хувьд үнэлэх шаардлагатай хэмээн үзсэн 38 хэсгийн зохицуулалтын тодорхой заалтыг үр дагаврыг үнэлэхээр түүвэрлэж, хэрэгжилтийг үнэллээ. Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын хэрэгжилтийн байдлыг харахад тус хуулийн зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй хүний оролцоог хангах, эрхийг хамгаалахад чиглэсэн Олон улсын конвенци, баримт бичигт нийцсэн үзэл баримтлалд суурилсан болохыг сайшаан тэмдэглэх нь зүйтэй. Сонгон авсан хуулийн зүйлийн бодит амьдралд ойлгож хэрэглэж буй байдал, уг харилцаанд оролцогч талуудад үүсэн эерэг ба сөрөг үр нөлөөг харьцуулан үзэхэд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд өмнө байсанаас эрхийг нь дээрдүүлж хамгаалж чадахгүй, амьдралд шууд хэрэгжихгүй байна гэдэг дүгнэлт хийхээр байна. Өөрөөр хэлбэл хуулийн зүйл, заалт шууд зорилгодоо хүрч чадаагүй, талууд хэрэглээний хувьд нэгдмэл болгон төлөвшүүлээгүй, улмаар шаардлагатай нөөцийн асуудлыг шилжилтийн бэлтгэл үе байх хугацаагүйгээр хууль үйлчилж эхлэсэнтэй холбоотой хуулийг хэрэгжүүлэх механизм, хоорондын уялдаа холбоо сул, төрийн байгууллагуудын үүрэг зарим талаар хэт ерөнхий, мөн хуулийг хэрэглэж байгаа албан хаагчдын хандлага, мэдлэг, туршлагатай холбоотой гэж дүгнэж болно. Тиймээс Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг илүү сайжруулж, өмнөх дутагдлыг сайжруулахын тулд дараахь арга хэмжээг зөвлөнө. Үүнд:

### **1.Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах.**

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн зохицуулалтыг нийгмийн халамж, боловсрол, эрүүл мэнд, амьдрах орчин гэж бүлэглэж болох юм. Энэ хууль нь процессын зохицуулалтаас илүүтэй материаллаг эрхийг тогтоожээ.

Хуулийн зохицуулалтын давхардал, хийдэл, зөрчлийг тогтоосон байдлаас үзэхэд давхардал 24,4 хувь, зөрчил 35,5 хувь, хийдэл 13,3 хувийг тус тус эзэлж байна.

Давхардлаас үзэхэд нийт давхардлын 61 орчим хувь нь нийгмийн халамжтай, 34 орчим хувь нь боловсролтой холбоотой, 5 орчим хувь нь бусад харилцаатай холбоотой байна.

Харин уг хуулийн дагуу гарах журмын хувьд нийт 25 журам батлагдахаас 15 журам батлагдсан байна. Гэхдээ уг хуультай холбоотой харилцааг Нийгмийн халамжийн хуультай холбоотой гаргасан журмуудаар зохицуулах нь түлхүү байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нийгмийн халамжийн бодлогыг зохицуулахдаа тусламж дэмжлэг хэлбэрээр тусгах нь илүү байх бөгөөд энэ нь Нийгмийн халамжийн тухай хуулийн үйлчилгээтэй агуулгын хувьд ижил байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх халамжийн бодлого нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг үндэслэхээс илүү Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу батлагдаж хэрэгждэг. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль батлагдсанаас хойш суурь баримтлах журмыг Засгийн газраас 2017 онд 197 тоот тогтоолын хавсралтаар баталсан Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих журам, Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам хамаарч байна. Харин хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд заасан амьдрах орчин, нийгмийн хамгаалалтай холбоотой харилцааг хууль батлагдахаас өмнө батлагдсан журмуудаар зохицуулж байна.

Улмаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд заасан нийгмийн халамж, боловсрол, эрүүл мэндийн зохицуулалт нь салбарын бусад хуулиар нарийвчлан зохицуулагддаг харилцаа болно. Иймээс Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн гол үзэл баримтлалаа эрхийн хууль байх уу, процессын харилцааг зохицуулах уу гэдгээ тогтоох хэрэгтэй. Учир нь, одоогийн хууль нь эрхийг зохицуулсан боловч журамласан харилцааг зохицуулсан, энэ нь Нийгмийн халамжийн тухай хууль болон Боловсролын тухай хуулиар зохицуулагдаж байгаа нь процессын харилцааг зохицуулах шинжийг агуулжээ. Хэрэв эрхийг зохицуулах бол эрхийг бүлэглэж тогтоох, тухайн эрхийг хэрхэн эдлэх харилцааг зохицуулсан салбар хуулийг нэрлэж оруулах хэлбэрээр зохицуулалтыг оновчтой болгох хэрэгтэй. Мөн хуулийн бүтцийн хувьд нийгмийн халамж, боловсрол, амьдрах орчны зохицуулалт нь давхардсан, логик уялдаагүй байна. Жишээ нь, хуулийн 7 ба 8 дугаар бүлэг нь нийгмийн халамжийн бодлогыг зохицуулсан атал тус тусдаа бүлэг болсон, 9 дүгээр бүлэгт бусад эрхийг заахдаа хүүхдийн эрх, эмэгтэйчүүдийн эрхийг оруулсан нь өмнөх салбар эрхүүд нь хүүхэд, эмэгтэйчүүдэд хамаагүй мэт логикийн хувьд ойлгомжгүй байна. Хуулийн давхардал 11, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль хоорондын зөрчил 3, бусад хуультай зөрчил 13, хэл, найруулгын томъёолол тодорхой бус 1, журмын зохицуулалтын хийдэл 10, хариуцлагын талаар заагаагүй 7, хэрэгжүүлэх субъект тодорхойгүй 1 байгааг тайлангийн 5 дугаар хэсэгт хуулийн зүйл, заалт тус бүрээр тодорхойлсон болно.

***2.Гадаад улсын адил харилцааг зохицуулсан хуулиас боломжит сайн жишгийг нутагшуулах боломжийг судлах.***

Монгол Улсын хувьд авч үзвэл зохих туршлагын тухайд Америкийн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн зохицуулалтаас дөрөв, Болгар улсын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд татан оролцуулах тухай хуулийн зохицуулалтаас ес, Япон улсын салбарын хууль тогтоомжоос зургаан асуудлыг энэхүү тайлангийн 4 дүгээр хэсэгт нэрлэсэн бөгөөд эдгээрийг Монгол Улсын хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нэмэлт өөрчлөлтөөр оруулах нь хуулийн зорилгод хүрэх, практикт нийцэх, талуудаас хүлээн зөвшөөрөх байдлыг нэмэгдүүлэх ач холбогдолтой гэж үзэж байна.

### **3. Оролцогчдод сөрөг үр дагавар үүсч буй хуулийн зүйл, хэсэг, заалтад зохих нэмэлт өөрчлөлтийг оруулах.**

Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгаж, хууль хоорондын нийцлийг хангахдаа Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хэлзүй, найруулгад тавих нийтлэг шаардлагыг хангасан байдлаар 24.2-ийн дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг материаллаг эрхийг тогтоосон суурь хууль болгон, процедурын харилцааг холбогдох салбарын хуулиудаар (Нийгмийн хамгааллын тухай, Эрүүл мэндийн тухай, Боловсролын тухай г.м) тодорхойлох нь зүйтэй гэж үзэж байна. Мөн түүнчлэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхий тухай хуулийн 40.4-т заасан “Энэ хуульд заасан төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагын зарим чиг үүргийг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, зардлыг гэрээний үндсэн дээр санхүүжүүлж болно.” зэрэг эрх хэмжээний хүрээнд сонголтоор олгосон, заавал биелүүлэх албагүй заалтын шалгуурыг тодорхой болгох шаардлагатай байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр 304 төрийн бус байгууллага ажиллахаар бүртгүүлснээс 80 гаруй нь тогтмол үйл ажиллагаа явуулж байна гэдэг статистикийн мэдээлэл байна. Нийт 35 хуульд хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой зөвлөл, байгууллага, оролцооны талаар заасан байгаа боловч ямар шалгуураар сонгож, хэрхэн хамтран ажиллах процедур ойлгомжгүй хэвээр байна.

### **4. Хэрэгжиж эхлээгүй буюу журам, стандарт нь батлагдаагүй, 2016 оноос хойш хэрэгжүүлээгүй хуулийн зохицуулалтын мөрөөр ХНХЯ-аас бодлогын хэрэгжилтийг уялдуулах, улмаар холбогдох төрийн байгууллагуудад хэрэгжүүлэх талаар зөвлөмж илгээх.**

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг УИХ-аас 2016 онд батлагдан хэрэгжиж эхэлснээс хойш уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд зааснаар нийтээр дагаж мөрдөх нийт 25 журам, стандарт батлагдахаас 15 журам, стандарт батлагдсан байна. Эдгээр зарим журам нь 2016 оны хууль батлагдахаас өмнө батлагдсан хэвээр үйлчилж байгаа, эсхүл холбогдох зарим хууль, бусад журамтай зөрчил байсаар байна. Иймээс нэгэнт хууль тогтоомжийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах, биелэлтэнд хяналт тавих, улмаар төрийн болон төрийн бус байгууллагыг мэргэжил, аргазүйн удирдлагаар хангах, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүргийг Хөгжлийн бэрхшээлтэй хуулийн 40 дүгээр зүйлийн дагуу салбарын төрийн захиргааны төв байгууллага болох Хүн ам, хөдөлмөрийн яам хүлээж байгаа тул энэ үүргийг хэрэгжүүлэхдээ тодорхой үе шатаар, хугацаатай, салбарын бодлогын дагуу төлөвлөгөөтэй ажилах нь зүйтэй байна. Тухайлбал, салбарын яамны асуудал гэж орхилгүйгээр үйл ажиллагааг ХНХЯ-аас уялдуулах, зохион байгуулах, хуульд заасан статистик мэдээллийн бааз үүсгэх г.м

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн зохицуулалтаар үүрэг хүлээж буй байгууллага, институт хоорондын чиг үүргийг тодорхой уялдуулахын тулд Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийг дэмжих агентлагийн чиг үүргийг хуульд тусгайлсан зүйлээр заах. Мөн ТББ-аас тогтмол хугацаатай мониторинг хийх, улмаар тайлангийн мөрөөр эргэх холбоо үүсэх зохицуулалтыг нэмэх боломжтой.

### **5. Санхүүгийн нөөцийг зөв хувиарлах, тодорхой байлгах талаар Сангийн яам, бусад төрийн бодлого тодорхойлогч, хэрэгжүүлэгч нартай байр суурийг нэгтгэх.**

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн дагуу батлуулах, зарцуулах ёстой төсвийн талаар уг хууль хэрэгжиж эхэлсэнээс хойш 2.5 жилийн хугацаанд тодорхой тоо, хувь хэмжээгээр илэрхийлэх боломжгүй байдалд дүгнэлт хийж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг Сангийн яамтай хамт Засгийн газрын түвшинд тодорхойлох шаардлагатай. Зүй нь хуулийн чиг үүргийн дагуу Сангийн яам салбар бүрээр батлагдсан төсөвт Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн дагуу зарцуулах төсвийн хувь хэмжээг тодорхой тайлагнах, ил тод байлгах ёстой атал ХНХЯ-ны ТНБД-ын албан бичгээр явуулсан хүсэлтэнд тоо, баримтгүй ерөнхий нэг өгүүлбэр хариу болгон ирүүлж байгаа нь энэ хуулийн хэрэгжилтийн санхүүгийн нөөц, хуваарилалтыг үнэлэх боломж олгохгүй, хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийн байдалд шууд эргэлзээ төрүүлж байгаа тул Засгийн газрын түвшинд байр суурийг төрийн захиргааны төв байгууллагууд нэгтгэх нь зүйтэй гэж үзэж байна.

**6. Төрийн албан хаагч, хувийн байгууллагын ажилтан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, багш, энэ харилцаанд оролцогчдод хууль тогтоомжийн талаар байнгын сургалтыг үе шаттайгаар, давтамжтайгаар явуулах, хууль таниулах.**

Хуулийн мэдээлэл, таниулга, сургалтын ажил өөрөө тасралтгүй процесс тул ХНХЯ-аас манлайлан энэхүү ажлыг зохион байгуулалттайгаар үргэлжлүүлэх хэрэгцээ, шаардлага байна.

## **АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ**

### **Анхдагч эх сурвалж**

#### **Ном, гарын авлага, илтгэл, сэдэвчилсэн судалгаа**

1. Г.Нарантуяа, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенц, 2008 он, Улаанбаатар хот
2. Европын Ардчиллын Холбоо, Тэгш нийгэм ТББ-ын "Монгол Улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эдийн засгийн эрхийг үнэлэх" төслийн тайлан, 2018 он,
3. Жайка ОУХАБ, Японы хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан бодлогын гарын авлага, Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих төсөл, 2018 он
4. "Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо ТББ"-ын ХНХЯ-ны харъяа байгууллагуудад дэд бүтцийн хүртээмжийн үнэлгээ хийсэн тайлан, 2018 он
5. Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газар, Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжийн гарын авлага, 2013 он, Улаанбаатар хот
6. ННФ, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өгөх санал, шүүмж, 2018 оны 6 дугаар сар, Хуулийн шүүмжийн цуврал 20
7. М.Сүхцоодол, Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын өмнө тулгарч байгаа асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэх боломжит арга замууд илтгэл, 2012 он
8. "Сонгино бие даан амьдрах төв"-ийн ХНХЯ-ны харъяа байгууллагуудад дэд бүтцийн хүртээмжийн үнэлгээ хийсэн тайлан, 2018 он
9. "Түгээмэл хөгжил" төвийн ХНХЯ-ны харъяа байгууллагуудад дэд бүтцийн хүртээмжийн үнэлгээ хийсэн тайлан, 2018 он

10. Үндэсний статистик, Хөгжлийн бэрхшээлтэй иргэд- Хүн ам орон сууцны 2010 оны улсын тооллого, 2011 он, Улаанбаатар хот
11. ҮСХ, Монгол Улсын үндэсний статистикийн эмхэтгэл, 2017 он
12. ХНХЯ, Хөгжлийн бэрхшээл судлал нь салбар дундын шинжлэх ухаан болох нь сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, 2017 он
13. ХНХЯ, Жайка ОУХАБ, "Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийн хэрэгжилт, тулгамдсан асуудал", 2018.07.03-ны өдрийн онол, практикийн бага хурлын илтгэл
14. ХНХЯ, Жайка ОУХАБ, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: бодлого, үйл ажиллагаа, 2017 он,

### **Хууль, тогтоомж, стандарт**

1. Авто тээврийн тухай хууль /1999 он/
2. Бага дунд боловсролын тухай хууль /2002 он/
3. Боловсролын тухай хууль /2002 он/
4. Биеийн тамир, спортын тухай хууль /2017 он/
5. Гамшгаас хамгаалах тухай хууль /2017 он/
6. Гэр бүлийн тухай хууль /1999 он/
7. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль /2017 он/
8. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль /1994 он/
9. Нийгмийн халамжийн тухай хууль /2012 он/
10. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /1994 он/
11. Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль /2002 он/
12. Сонгуулийн тухай хууль /2015 он/
13. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль /2008 он/
14. Хөдөлмөрийн тухай хууль /1999 он/
15. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль /2011 он/
16. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, 2016 он
17. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2013 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн "Сургалтын төлөвлөгөө, хичээлийн жилийн бүтцийг шинэчлэн батлах тухай" А/311 дүгээр тушаалын дөрөвдүгээр хавсралт "Оюуны бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн сургалтын төлөвлөгөө", тавдугаар хавсралт "Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн сургалтын төлөвлөгөө", зургаадугаар хавсралтаар "Харааны бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн сургалтын төлөвлөгөө"
18. "Иргэний барилгын төлөвлөлтөнд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин, үндсэн шаардлага" MNS 6055:2009
19. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2012 оны А/91 тоот тушаалаар батласан "Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх журам"
20. Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт, "Хууль тогтоомж хэрэгжүүлэхтэй холбоотой зардлын тооцоо хийх аргачлал"
21. Засгийн газрын 2017 оны 321 дүгээр тогтоолын хавсралт "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, Хөгжлийг дэмжих үндэсний Хөтөлбөр"
22. Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын хавсралт "Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам"
23. Засгийн газрын 2016 оны 200 дугаар тогтоолын хавсралт "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрэм"

24. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2012 оны А/87 тоот тушаалын хавсралт “Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа ахмад настан, 18 ба түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тэтгэвэр олгох журам”
25. “Нийтийн тээвэр Замналын зогсоол. Ангилал. Техникийн шаардлага” MNS 5879-2012
26. “Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолын төлөвлөлт” БД 32-101-17
27. “Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль” БД 31-101-04/,
28. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/212 дугаар тушаалын хавсралт “Мэргэжлийн ур чадварын олон улсын тэмцээнд амжилттай оролцсон хөгжлийн бэрхшээлтэй хүнд урамшуулал олгох ба урамшуулал олгох журам”
29. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/184 дүгээр тоот тушаал “Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журам”
30. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2017 оны А/213, А/166 дугаар хамтарсан тушаалын хавсралт “Хөтөч нохойг сургах, ашиглах журам”
31. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/184 дүгээр тоот тушаалын хавсралт “Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журам”
32. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/109 дүгээр тушаалын хавсралт “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үнэмлэх олгох журам, үнэмлэхийн загвар”
33. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцсэн зураг төсөл зохиох дүрэм, БД 31-112-11
34. Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын 2018 оны А/80 тоот тушаалын хавсралт “Асаргаа, сувилгааны болон асрамжлах үйлчилгээний ур чадвар эзэмшүүлэх сургалт зохион байгуулах журам”
35. Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын даргын 2012 оны 165 дугаар тушаалын хавсралт “Асаргаа сувилгааны болон асрамжлах үйлчилгээний ур чадвар эзэмшүүлэх сургалт зохион байгуулах журам”
36. Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газрын даргын 2012 оны 162 тоот тушаалын хавсралт “Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээний журам”
37. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцсэн зураг төсөл зохиох дүрэм” БД 31-112-11
38. “Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар” MNS 6056:2009

## Хоёрдогч эх сурвалж

### Цахим хуудас

39. <http://hudulmur-halamj.gov.mn/document/list?cat=63>
40. <http://ubstat.mn/News=1bd7bae5-f8a0-11e0-941d-001fc60e81db>
41. <http://www.ndaatgal.mn/tailan/SIGO-REPORT-2013.pdf>
42. <http://www.legalinfo.mn/law/details/4412?lawid=4412>
43. <https://www.ada.gov/pubs/adastatute08.htm>
44. <http://khanlex.mn/2013/04/06/%D1%85%D3%A9%D0%B3%D0%B6%D0%BB%D0%B8%D0%B9%D0%BD-%D0%B1%D1%8D%D1%80%D1%85%D1%88%D1%8D%D1%8D%D0%BB%D1%82%D1%8D%D0%B9-%D0%B8%D1%80%D0%B3%D1%8D%D0%B4%D0%B8%D0%B9%D0%BD-%D1%87%D0%B8%D0%B3%D0%BB/?lang=mn>

45. <https://www.facebook.com/tuuchee.tbb/posts/1469730873048733:0>
46. [http://apps.who.int/iris/bitstream/handle/10665/70670/WHO\\_NMH\\_VIP\\_11.01\\_mon.pdf;jsessionid=8007869615307DAEBE41820DFEC768DF?sequence=61](http://apps.who.int/iris/bitstream/handle/10665/70670/WHO_NMH_VIP_11.01_mon.pdf;jsessionid=8007869615307DAEBE41820DFEC768DF?sequence=61)
47. <https://president.mn/1352/>
48. [https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---asia/---ro-bangkok/---ilo-beijing/documents/publication/wcms\\_370167.pdf](https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---asia/---ro-bangkok/---ilo-beijing/documents/publication/wcms_370167.pdf)
49. <https://ikon.mn/opinion/1613>
50. <http://www.upr-mongolia.mn/images/4HRNGOForumSubmissiononPWDrightsSepUPR.pdf>
51. <http://www.sonin.mn/news/gemt-hereg/65987>
52. <https://newspress.mn/v1/p/news/1387>
53. <http://erdenetmedee.mn/index.php?newsid=7081>
54. <http://grow.blog.gogo.mn/read/entry525279>
55. [http://www.hudulmur-halamj.gov.mn/uploads/files/20180514\\_02.pdf](http://www.hudulmur-halamj.gov.mn/uploads/files/20180514_02.pdf)
56. <http://bidchadna.mdiscussionsn/>
57. <http://www.khural.mn/n/3bmyr>
58. [http://www.mercycorps.org.mn/CS/Documents/Book%201\\_mon.pdf](http://www.mercycorps.org.mn/CS/Documents/Book%201_mon.pdf)
59. <http://erdenet.mn/medee/d/160400111>
60. <http://www.fcy.gov.mn/data/main/main1492495129.pdf>  
<http://www.fcy.gov.mn/data/main/main1492495129.pdf>
61. <https://www.audit.mn/wp-content/uploads/2017/09/Khovd-tatbar-tailan.pdf>
62. [http://yepp.mn/wp-content/uploads/2017/09/%D0%A5%D3%A9%D0%B3%D0%B6%D0%BB%D0%B8%D0%B9%D0%BD-%D0%B1%D1%8D%D1%80%D1%85%D1%88%D1%8D%D1%8D%D0%BB%D1%82%D1%8D%D0%B9-%D0%B8%D1%80%D0%B3%D1%8D%D0%BD%D0%B4-%D1%85%D3%A9%D0%B4%D3%A9%D0%BB%D0%BC%D3%A9%D1%80-%D1%8D%D1%80%D1%85%D0%BB%D1%8D%D0%BB%D1%82%D0%B8%D0%B9%D0%BD-%D2%AF%D0%B9%D0%BB%D1%87%D0%B8%D0%BB%D0%B3%D1%8D%D1%8D-%D2%AF%D0%B7%D2%AF%D2%AF%D0%BB%D1%8D%D1%85-%D0%B0%D1%80%D0%B3%D0%B0-%D1%85%D0%B0%D0%BD%D0%B4%D0%BB%D0%B0%D0%B3%D0%B0\\_.pdf.pdf](http://yepp.mn/wp-content/uploads/2017/09/%D0%A5%D3%A9%D0%B3%D0%B6%D0%BB%D0%B8%D0%B9%D0%BD-%D0%B1%D1%8D%D1%80%D1%85%D1%88%D1%8D%D1%8D%D0%BB%D1%82%D1%8D%D0%B9-%D0%B8%D1%80%D0%B3%D1%8D%D0%BD%D0%B4-%D1%85%D3%A9%D0%B4%D3%A9%D0%BB%D0%BC%D3%A9%D1%80-%D1%8D%D1%80%D1%85%D0%BB%D1%8D%D0%BB%D1%82%D0%B8%D0%B9%D0%BD-%D2%AF%D0%B9%D0%BB%D1%87%D0%B8%D0%BB%D0%B3%D1%8D%D1%8D-%D2%AF%D0%B7%D2%AF%D2%AF%D0%BB%D1%8D%D1%85-%D0%B0%D1%80%D0%B3%D0%B0-%D1%85%D0%B0%D0%BD%D0%B4%D0%BB%D0%B0%D0%B3%D0%B0_.pdf.pdf)
63. <http://yepp.mn/wp-content/uploads/2017/10/%D0%A5%D3%A9%D0%B3%D0%B6%D0%BB%D0%B8%D0%B9%D0%BD-%D0%B1%D1%8D%D1%80%D1%85%D1%88%D1%8D%D1%8D%D0%BB%D1%82%D1%8D%D0%B9-%D0%B8%D1%80%D0%B3%D1%8D%D0%B4%D0%B8%D0%B9%D0%BD-%D1%82%D0%BE%D1%85%D0%B8%D1%80%D1%83%D1%83%D0%BB%D0%B3%D0%B0%D1%82%D0%B0%D0%B9-%D0%B0%D0%B6%D0%BB%D1%8B%D0%BD-%D0%B1%D0%B0%D0%B9%D1%80%D0%B0%D0%B0%D1%80-%D1%85%D0%B0%D0%BD%D0%B3%D0%B0%D1%85-%D1%82%D1%83%D1%85%D0%B0%D0%B9-%D0%B7%D3%A9%D0%B2%D0%BB%D3%A9%D0%BC%D0%B6.pdf>
64. <http://ekhsurvalj.mn/news/view/4301>
65. <http://montsame.mn/read/79405>
66. [www.meds.gov.mn](http://www.meds.gov.mn)



## ХАВСРАЛТ

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн зардлын тооцоо судалгааны ажилд материал цуглуулах зорилгоор Сангийн яам, Боловсрол соёл шинжлэх ухаан , спортын яам, Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам, Барилга хот байгуулалтын яам, Эрүүл мэндийн яам, Зам тээвэрийн яам, Нийслэлийн хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газар , мөн Статистикийн үндэсний хороогоор орж мэдээлэл цуглуулсан болно.

2018.06.13

Боловсрол соёл шинжлэх ухаан, спортын яам мэргэжилтэн н.Гэрэлтуяа нь тус асуудлыг хариуцсан ажилтан байхгүй байгаа тухайн ажлыг дөнгөж хариуцаад байж байгаа тул шаардлагатай мэдээллүүдийг авах талаарх хүсэлтээ цахимаар илгээж хариуг хүргүүлье гэсэн боловч холбогдох мэдээллийг гаргаж өгөөгүй болно. /Дахин хандсан/

Барилга, хот байгуулалтын яам Ахлах мэргэжилтэн н.Эрдэнэчимэг уулзалт хийж шаардлагатай мэдээллүүдийг авах талаарх хүсэлтээ цахимаар илгээж хариуг хүргүүлье гэсэн боловч холбогдох мэдээллийг гаргаж өгөөгүй болно. /Дахин хандсан/

2018.06.22

Хүнс, хөдөө, аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам Ахлах мэргэжилтэн Э.Ундрал уулзалт хийж шаардлагатай мэдээллүүдийг авах талаарх хүсэлтээ цахимаар илгээж хариуг хүргүүлье гэсэн боловч холбогдох мэдээллийг гаргаж өгөөгүй болно. /Дахин хандсан/

2018.06.27

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхчүүдийн холбоо, Сонсголын бэрхшээлтэй иргэдийн холбоо зэрэг төрийн бус байгууллагуудын төлөөллүүдийн уулзалт зохион байгуулж хүндрэл бэрхшээл, ололт амжилтын талаар ярилцаж судалгааны асуумжийн дагуу тодруулга, ярилцлага зохион байгуулав.

2018.07.05

Сэргээн засах үндэсний төвийн байранд аливаа төрийн болон төрийн бус байгууллагад харьяалагддаггүй дүүрэг болгоны төлөөлөл болох нийт 19 иргэнтэй уулзалт зохион байгуулж бүлгийн болон ганцаарчилсан ярилцлага зохион байгуулав.

2018.08.21

Сангийн яамны төсвийн бодлого төлөвлөлтийн газрын төсвийн зарлагын газрын мэргэжилтэн Мөнхтуяатай уулзсан. Тэрээр сангийн яаманд төрийн нарийн бичгийн даргын дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн салбар зөвлөлд нарийн бичгийн хийдэг ба тус зөвлөл байгуулагдаад ажлын төлөвлөгөөгөө батлуулаад төсөв мөнгө зоосон зүйл байхгүй

үйл ажиллагаа хийхээр бол тухайн үед зардлыг боломжтой санхүүжилтээс гаргадаг гэнэ. Мөн бүх яамдруу явдаг санхүүгийн зардал дотроос тухайн хууль хэрэгжихтэй холбоотой гардаг зардлын багц тоо авахыг хүссэн боловч бид тухайн яамдын сайдын багц тоогоор л шилжүүлдэг яг ямар зардал гарах естойг мэдэхгүй тухайн яамдаас авсан дээр гэх тайлбарыг хийв. Мөн сайдын багцын санхүүжилт тухайн яаман дээр задардаг гэж хэлж байсан.

Боловсрол соёл шинжлэх ухаан ,спортын яаман дээр төсвийн мэргэжилтэн Ганбаатар гэдэг хүнтэй уулзах гээд очсон боловч гадуур ажилтай гээд уулзаж чадсангүй.

2018.08.21

Хараагүй хүмүүсийн хөдөлмөр,сургалтын үйлдвэртэй танилцаж, захирал Болдсайхантай санал солилцов.

2018.08.22

Боловсрол соёл шинжлэх ухаан, спортын яаман дээр очиж төсвийн мэргэжилтэн Ганбаатартай уулзалт хийж материал авах тухай ярилцлаа. Тус яамны сайдын дэргэдэх Зөвлөл ажиллаж байгаа бөгөөд 2018 онд хийх ажлын жагсаалт болон бусад хэрэгтэй материалыг майлээр явуулахаар боллоо. Тус яам тусгай хэрэгцээт боловсролын сургалтын байгууллагуудад суусан зардлыг тооцож хувиаралдаг бөгөөд хуулинд заагдсан зарим журамууд гараагүй байгаа тул зардал бүрэн гараагүй байгаа гэх тайлбарыг хийв.

Эрүүл мэндийн яам мэргэжилтэн С.Бархастай уулзалт хийв. Тус яамны ХБИ-ийн зөвлөлд ажилладаг гэх мөн тус яаманд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг сүүлийн жилүүдийн статистик мэдээ гарч байгаа тэндээс зардал харах боломжтой гэсэн . Мөн Нийгэм хамгаалал хөдөлмөрийн яам, Боловсрол соёл шинжлэх ухаан , спортын яам , Эрүүл мэндийн яамны 3 сайдын хамтарсан үндэсний хөтөлбөр дээр олон ажилууд байгаа тэр бүгд сайд тус бүрийн зардлаас ордог тухай ярилцаж тус яамны дэргэдэх Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс гаргадаг Эрүүл мэндийн үзүүлэлт 2017 оны номыг авч мэдээлэл авахыг зөвлөв.

2018.08.22

Нийслэлийн хөдөлмөр халамж үйлчилгээний газар: Хариуцсан хүн нь байхгүй энэ талаар мэдээлэл алга гээд өгсөнгүй. Санхүүгийн ажилтануудад учир байдлаа тайлбарлахад манай шилэн данснаас ерөнхий тоо харж болно мөн бид хэн нэгэн хүнд албан бичигээр биш бол өгч чадахгүй гэсэн хариу өглөө.

Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яаманд очиж мэргэжилтэн Ганболдтой хүндрэлтэй байгаа нөхцөл байдлын талаар танилцуулж учир байдлаа хэлээд Хэлтсийн даргад нь танилцуулсан. Сангийн яамны 2017 оны тайлан надад байна би чамда майлээр явуулий гэж хэлээд утас майлээ үлдээгээд бидэнд мэдээлэл олоход туслах талаар тайлбар хийсэн.

Барилга хот байгуулалтын яам: Ахлах мэргэжилтэн Эрдэнэчимэг уулзалт хийв. Очтол амралттай байсан тул утсаар ярьж учир байдлаа хэлтэл албан бичиг авсан гэхдээ сайдын дэргэдэх зөвлөл он гараад дөнгөж байгуулагдаад ажилаа хийхээр төлөвлөсөн байгаа гэхдээ бас л төсөв байхгүй гэж байна. Яам яг хууль хэрэгжүүлэхтэй холбоотой

зардал одоогоор төлөвлөсөн зүйл байхгүй гэхдээ ажилууд бол хийгдэнэ гэж байна. Яамнаас норм нормотивын зардал хариуцдаг мэргэжилтэнгээс тус хууль хэрэгжихтэй холбоотой хэсэг зардал гардаг тухай хэлж мөн ирэх 1 дэх өдөр ажилдаа ороод зардлуудыг түүгээд майлээр явуулахаар боллоо. Зөвлөлд хийгдэх ажлын төлөвлөгөө болон тайланг явуулахаар тохиролцсон.

2018.08.24

Зам тээврийн яаман дээр хуулийн мэргэжилтэн Мяндасмаатай уулзав. Учир байдлаа танилцуулахад зардал яг тухайн хуультай холбоотой төсөв санхүү байхгүй байгууллагууд өөрсдөө ажилаа хийхдээ дотроосоо нөөц бололцоогоо ашиглан ажилууд хийдэг тухай ярилцлаа. 2017 онд болон 2018 оны хагасаар хийсэн ажил болон тавигдсан зардал тооцоог бүх харьяа газруудаас авч өгөхөөр албан бичиг явуулж тооцоо гаргаж өгөхөөр болоод дахин ирж хэрэггүй, э-мэйлээр мэдээлэл өгье гэх тайлбарыг хийсэн болно.

**Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийн өнөөгийн байдалд санал асуулга явуулахад дараах дүгнэлтэд хүрч байна.**

Хөгжлийн бэрхшээлтэй нийт 16 хүн хамрагдсанаас 5 эрэгтэй, 11 эмэгтэй хүн байсан ба судалгаанд хамрагдагсад дийлэнх хувь нь 40-өөс дээш насны хүмүүс байна. Аль хэлбэрийн хөгжлийн бэрхшээл илүү алдагдаж байгааг тодруулах зорилгоор хөгжлийн бэрхшээлийн төрлийг асуухад 50 хувь нь хөдөлгөөний хоцрогдол гэх төрлийг сонгосон байна.

Асран хамгаалагчийн тухай асуултад 50 хувьтай асран хамгаалагч байдаг, 50 хувь нь асран хамгаалагч байдаггүй гэж хариулсан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гарч буй зардлын хэмжээг тодруулахад ихэнх хувь нь 800.0001-1.000.000 төгрөг зарцуулдаг байна. Холбогдох байгууллагаас үзүүлж буй тусламж, үйлчилгээний талаарх мэдээллийг олж авдаг эх үүсвэрийг тодруулахад ихэнх нь огт мэдээлэл байхгүй гэж хариулж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд тусламж үйлчилгээ авж байгаа байдлыг тодруулахад Эрүүл мэндийн болон Нийгмийн халамж үйлчилгээний тусламжийг 40 хувьтай авч байна.

Харин Мэдээллээр үйлчилж буй хуулийн этгээдийн мэдээллийг авах /Хуулийн 11 дүгээр зүйл/, Аливаа сургалтын хөтөлбөрт хамрагдах /Хуулийн 14 дүгээр зүйл/, Нийтийн барилга байгууламжийн хүртээмжтэй байдал /Хуулийн 8 дугаар зүйл/, Зам, нийтийн тээврийн хүртээмжтэй байдал /Хуулийн 9 дүгээр зүйл/, /Хуулийн 9 дүгээр зүйл/, Хууль зүйн туслалцааны хүртээмжтэй байдал /Хуулийн 27 дугаар зүйл/, Биеийн тамир спортын үйл ажиллагаа /Хуулийн 33 дугаар зүйл/, Төрийн байгууллага албан тушаалтны буруутай үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгах, нөхөн төлбөр олгох зэрэг тусламж үйлчилгээнүүдийг огт авч чадахгүй байгаа гэж дүгнэгдэж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гэрлэлтийн байдлыг асуухад гэр бүлтэй нь 40 хувь, салсан нь 40 хувь, огт гэрлээгүй нь 20 хувьтай байна. Мөн боловсролын түвшинг тодруулахад бүрэн дунд 45 хувь, бакалавр зэрэгтэй 45 хувьтай бөгөөд магистр зэрэгтэй 1 хүн, бүрэн бус дунд боловсролтой 1 хүн байна.

Ажил эрхлэлтийн байдлыг тодруулахад тэтгэвэрт болон групп байдаг нь 50 хувь, олон нийтийн байгууллага буюу төрийн бус байгууллагад ажилладаг 15 хувь, хувиараа хөдөлмөр эрхэлдэг 15 хувь, төсвийн болон төрийн оролцоот байгууллагад ажилладаг нь 10 хувь, ажил эрхэлдэггүй нь 10 хувийг эзэлж байна.

Эндээс дүгнэхэд хөгжлийн бэрхшээлтэй иргэд ихэнхдээ олон нийтийн төрийн бус байгууллагад ажиллаж байна. Судалгаанд хамрагдсан иргэдийн 50 хувь нь орон сууцанд

амьдардаг бөгөөд бусад нь хашаа байшин, гэрт амьдарч байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 1 сарын дундаж орлогыг тодруулахад 250.000-300.000 төгрөг байна. Хамгийн их орлоготой нь 400.000 төгрөгөөс хэтрэхгүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал нь нийгмийн халамжийн асуудал төдийгүй хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогын төв байх ёстой чухал асуудал юм.

Гэтэл өнөөдөр Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар хууль эрх зүйн болон бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт хангалтгүй, түүнд тавигдах хяналт сул, тэдний эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаанд оролцох эрхүүд нь хязгаарлагдмал, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажиллах боловсон хүчний нөөц дутмаг, дэд бүтцийн орчин нөхцөл бүрэн шийдэгдээгүй асуудлууд байсаар байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд бид өнөөдөр тулгамдаж буй асуудал гэхээсээ илүү хийж бүтээх эрмэлзэлтэй байна. Тэд гар хумхин суухаасаа илүү хийж бүтээж, ирээдүй өөд гэрэлт нүдээр харах хүсэл эрмэлзэлтэй байдаг. Харин үүнийг маань төр засгаас онцгойлон анхаарч тэдний хөдөлмөрийг үнэлж, эдийн засгийн харилцаанд орох боломжийг хангаж өгөх хэрэгтэй байна.

**Төрийн бус байгууллагуудаас хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийн өнөөгийн байдалд санал асуулга явуулахад дараах дүгнэлтэд хүрч байна.**

Судалгаанд хамрагдсан 10 байгууллагын 4 нь хөдөлмөр халамжийн үйлчилгээ үзүүлдэг байгууллага бөгөөд дээд боловсролын байгууллага, ерөнхий боловсролын байгууллага зэрэг төрийн бус байгууллагууд хамрагдсан байна.

Тухайн байгууллагуудын ихэнх нь 6-10 ажилтантай байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд хамтран ажиллаж буй ТББ-ын тоог тодруулахад байгууллага бүр өөр өөр 1-10 хүртэл байна.

Хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд үйлчилгээ, тусламж, дэмжлэг үзүүлж буй иргэдийн тоог тодруулахад байгууллага бүр адилгүй 10-200 хүртэл байна. Хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн тоог тодруулах 1-2 хүртэл байгаа нь хуулийн хэрэгжилтийг хангахад нөлөөлөх төсөл, хөтөлбөр дутмаг байна. Эдгээр асуудлыг хэрэгжүүлэхэд тулгарч буй хүндрэлийг тодруулахад төсөв, эрх зүйн орчин, менежмент гэж дүгнэж байна. Тиймээс судалгаанд хамрагдсан тухайн төрийн бус байгууллагууд дараах саналыг гаргаж байна. Үүнд:

1. Эрх зүйн орчинг бүрдүүлэх, хуулийн хэрэгжилтийн хяналтыг сайжруулах
2. Төсөв болон хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, ил тод болгох
3. Гадаад орнуудын туршлага судлах
4. Сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах зэрэг болно.